

ХҮНИЙ
БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ,
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН

ГЭМТ ХЭРЭГ

ЭСРЭГ

ШАЛТГААН, НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР, 2018

**“ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ:
ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛС” СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Захиалагч: Монголын Эмэгтэйчүүдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв

Гүйцэтгэгч: ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төв

Судалгааны баг:

Багийн ахлагч:

Т.Оюунчимэг ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор

Судалгааны багийн зөвлөх:

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Судалгааны багийн гишүүд:

1. Ч.Нямсүрэн ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор
2. М.Эрдэнэбаяр ХСИС-ийн ЭШХ-ийн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор (Ph.D)
3. Б.Мөнхдорж ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн доктор (Ph.D)
4. Б.Мөнхсэргэлэн ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр
5. Л.Цогтбаяр ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн багш, докторант
6. О.Уулзахжаргал ХСИС-ийн ЭШХ-ийн Хууль сахиулахуйн инновацийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр
7. С.Байгальмаа -Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн эрхлэгч
8. Э.Бямбажаргал -ХСИС-ийн магистрант, цагдаагийн ахмад

Гүйцэтгэсэн хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 20

Тайланг хүлээлгэн өгсөн хугацаа: 2019 оны 01 дүгээр сарын 02

АГУУЛГА

Судалгааны хураангуй	4
Удиртгал	16
Нэгдүгээр бүлэг. Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар судлагдсан байдал	21
Хоёрдугаар бүлэг. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх статистикт дүн шинжилгээ	28
2.1. Цагдаагийн байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	
2.2. Прокурорын байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	
2.3. Шүүхийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	
2.4. Шүүхийн шинжилгээний мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	
2.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа “хүчиндэх” гэмт хэргийн жишээн дээр	
2.6. Эрүүгийн хуулийн 12.1, 12.2, 12.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг дээр хийгдсэн шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний дүгнэлтэнд хийсэн судалгааны үр дүн	
Гуравдугаар бүлэг. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэргүүдийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл, шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээ (Нийслэлийн дүүргүүдийн хэмжээнд)	57
3.1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа /2015-2017/	
3.2. Хэрэгсэхгүй болгосон хэргүүдэд хийсэн дүн шинжилгээ	
3.3. Зарим бодит кейс	
3.4. Мөрдөн шалгах ажиллагааны талаар	
Дөрөвдүгээр бүлэг. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хууль болон 2002 оны Эрүүгийн хуульд хуульчилсан байдал (харьцуулалт)	78
Тавдугаар бүлэг. Гадаад улс орнуудын Эрүүгийн хуульд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал	85
• АНУ-ын Техас мужийн Эрүүгийн хууль	
• Дани улсын Эрүүгийн хууль	
• ХБНГУ-ын Эрүүгийн хууль	
• Испани улсын Эрүүгийн хууль	
• Санмарино улсын Эрүүгийн хууль	
• Франц улсын Эрүүгийн хууль	
• Эстони улсын Эрүүгийн хууль	

- Бүгд найрамдах Латви улсын Эрүүгийн хууль
- Швейцарын холбооны улсын Эрүүгийн хууль
- Швед улсын Эрүүгийн хууль
- Солонгос улсын Эрүүгийн хууль
- Израил улсын Эрүүгийн хууль
- БНХАУ-ын Эрүүгийн хууль

Дэд дүгнэлт

Зургадугаар бүлэг. Гэмт хэрэгт хохирохоос айх байдлын судалгааны зарим үр дүн 114

- а) Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
- б) Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл
- в) Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал

Долдугаар бүлэг. Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгаан, нөхцөл 117

- 5.1. Нийгмийн тэгш бус байдал
 - 5.2. Эд баялаг ба орлого
 - 5.3. Боловсрол мэргэжил
 - 5.4. Эрх мэдэл, нэр хүндийн ялгаа
 - 5.5. Улс төрийн байдал
 - 5.6. Эдийн засгийн байдал
 - 5.7. Соёл, ёс суртахуун, үзэл суртал
 - 5.8. Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн, хотжилт
 - 5.9. Гэр бүлийн байдал
- Дэд дүгнэлт, санал

Нэгдсэн дүгнэлт, санал 149

Ашигласан эх сурвалж 159

Хавсралт

1. Судалгааны ажлын удирдамж
2. Холбогдох статистикийн дэлгэрэнгүй судалгаа
3. Контент анализ хийсэн судалгаа
4. Сэтгэцийн дэлгэрэнгүй судалгаа

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монголын Эмэгтэйчүүдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвөөс захиалж, салбарын мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны багаар **“Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг: шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс”** сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгүүлэв.

Зорилго:

Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн (ЭХ-ийн 12.1, 12.2, 12.5) гаралтад нөлөөлж байгаа шалтгаан, хүчин зүйлсийн талаар тоон болон чанарын судалгаа хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны болон эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулахад чиглэгдсэн.

Хугацаа:

2018 оны 10 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 20-ны хооронд судалгааг хийж, 2019 оны 1 дүгээр сарын 02-нд тайланг захиалагчид хүлээлгэн өгөв.

I. Судалгаа хийсэн арга зүй, онцлог:

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ юмс үзэгдлийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээнд нь бодитойгоор судлах боломж олгодог шинжлэх ухааны түгээмэл аргуудыг хэрэглэх ба сэдэвт холбогдох мэдээ баримтуудыг холбогдох эх сурвалжаас авч, албан ёсны статистик, хавтаст хэргийн материалд дүн шинжилгээ (задлах, нэгтгэн дүгнэх, харьцуулалт) хийх, ярилцлага, ажиглалт, анкетын аргыг өргөнөөр ашиглана.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн зарим аргуудыг дурьдвал:

- **Түүхчлэх, түүвэрлэх, баримт бичгийн аргыг ашиглан**, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн талаар эрдэмтэн, судлаачдын тодорхой эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг түүвэрлэн судлав.

- **Тоон судалгааны аргыг ашиглан**, Цагдаа, Прокурор, Шүүхийн төв байгууллагуудад судалгааны багаас хүсэлт гарган 2018 оны 10 дугаар сард ирүүлсэн 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын мэдээлэлд үндэслэн энэ төрлийн гэмт хэргийн байдалд математик, статистикийн аргуудыг хууль зүйн шинжлэх ухааны зарим аргуудтай хослуулан хэрэглэж, дүн шинжилгээ хийлээ.

- **Хавтаст хэргийг уншиж, дүн шинжилгээ хийх аргыг ашиглан**, сүүлийн 3 жилд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон бодит 72 хавтас бүхий 66 хэргийг уншиж, түүнтэй тэмцэж буй практикт гарч буй алдаа, дутагдлыг засах, эрх зүйн орчныг сайжруулах саналыг дэвшүүлэв. Тодруулбал, 2015-2017 онуудад хүний бэлгийн эрх чөлөө,

халдашгүй байдлын эсрэг нийслэлд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргүүдийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, улмаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн.

- *Харьцуулалтын арга, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх аргыг ашиглан*, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг 2015 оны эрүүгийн хууль болон 2002 оны эрүүгийн хуульд хуульчилсан байдлыг авч үзэж, мөн Гадаадын зарим улс орнуудын бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эрүүгийн хуульд хэрхэн тусгасан судалгааг Америк, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн хийв.

- *Гэмт хэрэгт хохирохоос айх байдлын судалгааг олон улсын аргачлалаар* явуулсан судалгааны үр дүнгээс, энэ төрлийн гэмт хэргээс айх байдлын хэсгийг авч, судалгааны тайланд тусгасан онцлог судалгааны ажил болов.

- *Ажиглалт, индукци, дедикцийн аргыг ашиглан*, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгаан, нөхцөлийг томъёолон дүгнэн бичив.

- *Контент анализын аргаар*, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн талаар сүүлийн 3 жилийн хугацаанд нийтлэгдсэн, тайлбарласан, бичигдсэн сонин, сэтгүүл, цахим хуудас болон олон нийтийн сүлжээнээс интернэт болон хэвлэмэл эх сурвалжаас хайлт хийж, нийт 85 үр дүнг нэгтгэж, агуулга давхцаагүй, олон уншигчид хүрсэн гэх мэт шаардлага хангах 35 нийтлэлийг сонгож, дүгнэлт хийв.

II. Судалгааны баг:

Судалгааг ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны баг гүйцэтгэсэн.

ЦЕГ-ийн харъяа Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба болон Хэрэг бүртгэх алба, Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, ШШГЕГ, Эрүүгийн хэргийн архивын газар, ШШҮХ, ЭМЯ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг байгууллагуудын дэмжлэгийг авч, хамтран ажиллалаа.

III. Судалгааны тайлангийн бүтэц, агуулга:

Судалгааны тайлан нь удиртгал, 7 бүлэг, нэгдсэн дүгнэлт, санал, ашигласан эх сурвалж, хавсралтаас зэргээс бүрдсэн агуулга нь:

IV. Судалгааны үр дүн, дүгнэлт, санал

1. Цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, **хүчиндэх** гэмт хэрэг 2015 онд 279 бүртгэгдэж байсан бол жил дараалан өсч, 2017 онд 376 болж, 34.8 хувиар өссөн. 2018 оны эхний 10 сарын байдлаар 472 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр **40-50 хувиар өсөх прогноз харагдаж байна.**

Гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын байдлыг авч үзвэл, 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар Хүчиндэх 1417 хэрэгт 1232 хүн холбогдон шалгагдаж, 1382 хүн хохирогч болсоны 58 буюу 4.2% нь 7 хүртэлх насны, 233 буюу 16.9% нь 8-13 насны, 384 буюу 27.8% нь 14-17 насны, нийт 675 буюу 48.8% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн **893 буюу 63.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.**

Прокурорын байгууллагаас 2015 онд хүчиндэх 402 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2016 онд буурч, 2017 онд 444 болж, 21.0%-иар өсчээ. 2018 оны эхний 10 сарын байдлаар 948 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр 2.6 дахин өсөн прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хүчиндэх 2161 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, **916 хэрэг буюу 42.4%-ийг шүүхэд шилжүүлжээ.**

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх 776 эрүүгийн хүлээн авсаны 697 буюу 89.8% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 776 эрүүгийн хэргийн **573 буюу 73.8%-ийг шүүхээр шийдвэрлэж, 665 хүнд ял оноосон байна.**

Шүүхээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 665 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 193 хүнд, 2016 онд 226 хүнд, 2017 онд 243 хүнд хорих ял оногдуулжээ. Хүчиндэх гэмт хэрэгт хорих ял оногдуулалт өссөн байна.

2. **Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг** 2015-2017 онуудад 21-23 орчим бүртгэгдэж байсан ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 11 бүртгэгджээ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 76 бүртгэгдэж, 67 хүн холбогдон шалгагдаж, 73 хүн хохирогч болсоны 12 буюу 16.4% нь 7 хүртэлх насны, 26 буюу 35.6% нь 8-13 насны, 6 буюу 8.2% нь 14-17 насны, нийт 44 буюу 60.3% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн

бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн **57 буюу 75.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.**

2015-2016 онуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 52-63 орчим хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 24 болжээ.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 173 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, **139 хэрэг буюу 80.3%-ийг шүүхэд шилжүүлжээ.**

Шүүхээс 2015-2017 онд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 65 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 92.3% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 65 эрүүгийн хэргийн **52 буюу 80.0%-ийг шүүхээр шийдвэрлэж, 55 хүнд ял оноосон байна.**

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн 55 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 18 хүнд, 2016 онд 19 хүнд, 2017 онд 18 хүнд хорих ял оногдуулжээ.

3. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 онд 28-30 бүртгэгдэж байсан бол 2018 оны эхний 10 сарын байдлаар 38 бүртгэгдэж, оны эцсээр 20%-иар өсөх хандлагатай байна.

Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 134 бүртгэгдэж, 119 хүн холбогдон шалгагдаж, 133 хүн хохирогч болсоны 17 буюу 12.8% нь 7 хүртэлх насны, 111 буюу 83.5% нь 8-13 насны хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

2015 онд Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 56 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2017 он хүртэл буурсан боловч 2018 оны эхний 10 сарын байдлаар 78 болж, өмнөх оныхоос оны эцсээр 70%-иар өсөхөөр прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 232 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 107 хэрэг буюу 46.1%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Шүүхээс 2015-2017 онд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 69 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 87.0% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 69 эрүүгийн хэргийн 54 буюу 78.3%-ийг шүүхээр шийдвэрлэж, 65 хүнд ял оноосон байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг үйлдсэн 65 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 15 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2016 онд 13 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2017 онд 15 хүнд хорих, 4 хүнд албадан ажил хийлгэх, 2 хүнд торгох ял оногдуулжээ.

Судалгааны ажлын хүрээнд “Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох нэгжийн гаргаж өгсөн мэдээллийг ашиглалаа. Эдгээр байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээлэл боловсронгуй болсон байна дүгнэж болохоор байна.

4. Өнөөдрийн байдлаар үчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй нийт **530** хоригдол байна. Энэ нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Зөвхөн энэ тооноос харахад хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо Монгол Улсад өндөр байгааг харуулж байна. Үүнээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 81 хоригдол ял эдэлж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдолд оногдуулах ялын бодлого хохирогчийн насны байдлаас шалтгаалан хэт ялгаатай байгаа нь насанд хүрсэн хохирогчийн зөрчигдсөн эрхийг бүрэн сэргээж чадна гэдэгт эргэлзээ төрүүлж байна. Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг нь материаллаг гэхээсээ илүү хохирогчийн сэтгэл зүй, алдар хүнд, оюун санааны хэлбэрээр илэрдэг тул үүнийг мөнгөн илэрхийллээр тооцдог эрх зүйн механизм манай улсад учир дутагдалтай байна. Энэ байдал нь хохирогч гэмт хэргийн золиос болсноо нуух, гэмт этгээдийг илчлэхээс эмээх цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд бугшмал байдлаар өсөн нэмэгдэх эрсдэл байна.

5. 2015-2017 онд Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1 дүгээр зүйлд заасан хэргүүдэд нийт 332 шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийж үзэхэд эдгээр хэргүүдийн 88 хувь нь хүчиндэх (126.1), (12.1) гэмт хэрэг зүйл эзэлж байна.

Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд эзэлж байгаа ч, насны хувьд бага насны хүүхэд өртөж байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч **44.8 хувь нь 11-16 насны охид** эзэлж байна.

Тухайн онуудад **нийт 361 хохирогч, холбогдогч хамрагдсанаас сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан 88**, үүнээс 58 /65 хувь/ хохирогч нь эмэгтэй байна.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7 хувь нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой байлаа.

Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4 хувь нь 17-21 насны залуус эзэлж байна.

6. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэх аргыг “хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах” гэж диспозицид дэлгэрэнгүй зааж, **“хохирогчийн хүсэл зоригийн эсрэг”** гэж субъектив талын шинжийг шинээр зааж өгсөн нь практикт энэ төрлийг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.

Зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог болсон, хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болохоор тугасан зэрэг нь олон улсын жишигт нийцсэн.

Мөн “бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж заасан нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан үйлдэл (хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар бэлэг эрхтнийг хөхүүлэх, хохирогчийн ам, суга, цавь, шулуун гэдсэнд дур тавих г.м)-ийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулж, гэмт этгээдэд ял завшуулж байсан буруу тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцсэн алхам болсон.

- “Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэж заасан нь практикт бага насны хүүхдийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах арга хэрэглэсэн байхыг шаарддаг буруу хандлагыг өөрчилсөн.

Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан; арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол онц хүндрүүлэхээр заасан нь өсвөр насны хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг онцгойлон эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан алхам болсон.

- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив талыг хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэж шинээр томъёолохдоо объектив талын нэмэгдэл шинж болох цаг хугацааг зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэрэг болохоор заагласан байна.

- Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх хүний насыг 18 байхаар зааж, халдлагад өртөгч (хохирогч)-ийг 14-16 настай болохыг мэдэх боломжтой, мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь практикт энэ хэргийн зүйлчлэлийн талаар үүсдэг маргааныг шийдвэрлэхэд дөхөм болсон. 14 хүртэлх насны буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн шинжид хуульчилсан. Ингэж энэ гэмт хэргийн хохирогчийн насыг тодорхой зааж өгсөн нь нэг мөр ойлголт өгсөн ач холбогдолтой болсон байна.

7. Гадаадын зарим улс орнуудын бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эрүүгийн хуульд хэрхэн тусгасан судалгааг Америк, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн хийж үзэхэд Монгол Улсад бие үнэлэхтэй тэмцэх асуудал **“захиргааны аргаас хэтрэхгүй”** байна. Судалгааны үндсэн хэсэгт дурьдсан дүгнэлт, саналыг харгалзан үзэх нь зүйтэй.

8. Монголчуудын гэмт хэрэгт хохирохоос айх байдлын судалгааг нийт 1449 иргэнээс авсанаас бөгөөд тодорхой төрлийн 8 гэмт хэргээс түгших хандлагыг дараах асуултаар шалгасан. Судалгааны дүнгээс үзвэл “Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ” гэхээс айдаг гэсэн асуултанд хариулсан байдлын дундаж нь 3.18 бол дараагийн дугаарт “Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна” гэхээс айдаг гэсэн асуултын дундаж хариулт 3.14 гэсэн үзүүлэлттэй байна. **Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн төрөлд бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.94 гэсэн дундаж үзүүлэлтээр орж байгаа бол хууль бусаар мөрдөх гэмт хэргийн 2.96 гэсэн үзүүлэлттэй байна.**

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 15 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн

шинжилгээ хийсэн болно. Эх олонлогоос түүвэрлэлт хийх замаар судалгаанд оролцогчдыг сонгож авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын нөхцөл байдлыг илэрхийлэх чадвартай гэж үзсэн болно.

Гэмт хэргийн улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмблэн харуулахад судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 389 буюу 26.9 хувь нь ямар нэгэн байдлаар хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авах замаар хохирсон гэж тус тус хариулжээ. **Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байгаа нь өмнөх асуулгын үр дүнтэй нийцэж байна.**

9. Контент анализын аргаар хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл¹, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл гэдэг сэдэв нь өөрөө хүний эмзэг асуудлыг хөндсөн сэдэв учраас сэтгүүлч, нийтлэгч нар ихээхэн сонирхож, судалж бичдэг болох нь харагдав. Үүн дотор хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэг гэх мэт дуулиантай хэргүүдийн талаар олон талаас бичсэн нийтлэлүүд цөөнгүй байна. Хэн нэгэн УИХ-ын гишүүн, олны танил хүмүүс тус гэмт хэрэгт холбогдсон талаар хамгийн олон хандалттай, хамгийн олон нийтлэгдсэн байгааг харж үзвэл, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээр бус улс төрийн зорилготой нийтэлсэн гэж харагдаж байна. Мөн нийтлэлүүд нь тоон судалгааг ашигласан байгаа боловч албан ёсны мэдээнээс зөрсөн тохиолдлууд цөөнгүй анзаарагдав. Зарим төр, холбогдох хуулийн байгууллагыг буруутгасан хэн нэг байр сууринаас хандсан нийтлэлүүд ч цөөнгүй байна. Харин албан ёсны байгууллагаас мэргэжлийн тайлбар, ярилцлага өгсөн нийтлэл маш цөөн байгаа нь тухайн хуулийн байгууллагыг олон нийт буруутгах хандлагатай сөрөг үр дагавар харагдаж байна.

10. Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн тусгай ангийн /цаашид ЭХТА гэх/ 122 дугаар зүйл буюу 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, 125 дугаар зүйл буюу бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 126 дугаар зүйл буюу хүчиндэх зүйл ангиар зүйлчлэгдсэн нийт **72 хавтас бүхий 66 хэрэг** байгаагийн 17 нь Чингэлтэй, 10 нь Хан-Уул, 29 нь Баянзүрх, 10 нь Сүхбаатар дүүрэгт тус тус байна. Эдгээр хэргийг уншиж, дүн шинжилгээ хийхэд:

¹ Контент анализ хийсэн дэлгэрэнгүй судалгааны түүврийг хавсаргав.

-Орчин үед өсвөр үеийнхний бэлгийн бойжилт эрт явагдаж байгаатай холбоотойгоор охид ихэвчлэн 14 наснаас, хөвгүүд 15 наснаас бэлгийн харьцаанд орж байх бөгөөд 10 жилийн сургуулийн охидын хувьд хөвгүүдэд таалагдахын тулд архи уух, бэлгийн харьцаанд ороход бэлэн байх нь элбэг байна.

-Нийслэлийн хэмжээнд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэргүүдтэй танилцах явцад 13-21 насны хохирогчдын 44% нь өөрийгөө хянах чадваргүй болтлоо согтсоноос бэлгийн хүчирхийлэлд өртөж байна.

-Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн 80 % нь хохирогчийг урьд нь таньдаг эсхүл танилцсан хүн нь хүчирхийлдэг байна.

-Хүүхэд, залуус энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаагийн гол шалтгаан нь хийх ажилгүй, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эдийн засгийн боломжгүйтэй холбоотой байна.

-Хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн 80 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхдээ зөвхөн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, тайлбар зэргийг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь өмнөх ЭБШ хуулийн 166 дугаар зүйлийн 166.1. дэх хэсэгт заасан: “Гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байвал эрүүгийн хэрэг үүсгэнэ” гэснийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн тоо өсч харагдах, мөрдөгч нарына ачаалал зохиомлоор өсөхөд нөлөөлж байна.

-Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3, 25 дугаар зүйлийн 25.1 дүгээр үндэслэлээр хүчиндэх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа буруу практик байна. Учир нь хүчиндэх гэмт хэрэг нь хувийн болон төрийн яллах ажиллагааны буюу хосолсон яллах ажиллагааны гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хүчиндэх гэмт хэрэг нь хохирогчийн /насанд хүрсэн/ гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэх боловч, төрийн яллах ажиллагаа нэгэнт эхэлсэн бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг дуустал явуулах учиртай.

11. Энэ төрлийн шүүхийн шийдвэрүүдэд түүвэрлэн хийсэн судалгаанаас дүгнэн үзвэл, өсвөр насны охидод эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс тавьж буй хараа хяналт сул, халамж дутагдаж охид гэмт хэрэгтний олз болж байна. “Энэ нөхцөл байдал нь гэмт хэрэгтэн нэг үйлдлээ дахин давтан хийх сэдлийг өдөөж байдаг гэж үзэж болно”. Ялангуяа хөдөө, орон нутагт буйдхан газар, гуу жалга, эзгүй гэр, сууц, орон байр, захын хороолол, дэн буудал, зочид буудал, маншины бүхээгт энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгджээ.

Хохирогчийн ар гэрийхэнд *“арай ч ойр дотны, бага насны охин хүүхдийг хүчиндэхгүй байлгүй дээ”* гэсэн итгэмээргүй нөхцөл байдалд орж, эргэлзээ үүсгэдэг нь хараа хяналтаа сулруулах хүчин зүйл болж байна.

Хохирол нэхэмжлэх асуудал ихэнхдээ орхигддог, ялангуяа **“хөдөө, орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч тал хохирол нэхэмжлэх асуудлыг тоохгүй өнгөрөөх, далдуур тохирдог зүйл их байдаг тал ажиглагдлаа”**. Энэ нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох томоохон хүчин зүйл болдог.

“Хүчиндэх гэмт хэргийг эвлэрлийн гэрээ байгуулсан нэрээр (эвлэрсэн гэсэн үндэслэлээр) хууль бусаар хэрэгсэхгүй болгож” байна. Жишээ нь: Эрүүгийн 201525011364 дугаартай хэрэг.

Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдол ихэвчлэн хохирол төлбөргүй байдаг нь дээр дурдсан шалтгаан нөлөөлдөг. Хохирол нөхөн барагдуулалтын тухайд 66 хэргийн хохирогчдоос **9 хохирогч ямар нэг хэмжээгээр нөхөн төлбөр авсан** байна.

Хүчиндэх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэдэг нэг үндэслэл нь **хохирогч өөрийн нийгмийн байдалд гарч болзошгүй сөрөг нөлөөллийг тооцоолж, өөрт ашигтай буюу яллагдагчаас хохирол нэхэмжилж шийдвэрлүүлэх, тохиролцсон болж хувирах, гомдлоо буцаах арга замыг сонгох тохиолдол элбэг** байна.

Гэм буруутай хүн энэ гэмт хэргийг урьдаас төлөвлөх болон гэнэт үүссэн гэмт санаагаар үйлддэг байна. **“Бодлогын хэмжээнд хэрэгжүүлж буй хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаа хүүхэд бүрт хүрэхгүй байгаа нөхцөл”** байдалтай байна.

Дэд судалгааны тайлан тус бүрд тавьсан саналуудаас гадна мөн дараах саналыг нэмж дэвшүүлж байна. Үүнд:

1. Өсвөр үеийнхний бэлгийн бойжилт эрт явагдаж байгаатай холбоотойгоор эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар тогтмол зөвлөгөө өгч байх;

2. Бэлэгсийн гэмт хэрэгт хохирогч санал хүсэлтээ илэрхийлж болохоос гомдлоо буцаан татах тухай асуудал байхгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ердийн журмаар явагдана гэдгийг хуульчид нэг мөр ойлгох;

3. Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн боловсон хүчнийг бэлтгэх хамтын ажиллагаанд анхаарал тавих;

4. Эмэгтэйчүүд хүүхдийн эрхийг хамгаалах талаар хийсэн судалгааны ажил нэг бүрд мониторинг хийж, хэрэгжилтийн үр дүнг тооцож байх. Ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэж, уг мониторинг шинжилгээний үр дүнг нийтээр жилд нэг удаа хэлэлцдэг байх;

5. Гадаад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх, ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг уруу татсан, олон хүнийг (2 ба түүнээс дээш) зохион байгуулалттайгаар биеийг үнэлүүлсэн, мөн үйлчлүүлэгч (үнэлж авсан) нар, тэднийг ашиг хонжоо олох байнгын хэрэгсэл болгосон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг чангатгах;

6. Бэлгийн мөлжлөг, биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдаалах, бэлгийн эрх чөлөөний эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх урт хугацааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамгийн чухлаар тавигдах ёстой, түүнчлэн хохирогчдыг нөхөн сэргээх нөхцлийг сайжруулах, тэднийг хэвийн амьдралд нь эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг идэвхтэй шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;

7. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын ихэнх нь бага насны эсхүл насанд хүрээгүй хүн хүчиндсэн байгаа нь дээр дурдсан **“ялын бодлогын оновчтой биш”** байдалтай холбоотой. Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдол ихэвчлэн хохирол төлбөргүй байдаг нь судалгааны тайланд дурдсан шалтгаан нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс төлбөртэй хоригдлын төлбөрийг барагдуулах тэднийг цалинтай ажлын байраар хангах зорилгоор тодорхой ажил зохион байгуулж ирсэн боловч хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс шинэ хууль тогтоомжоор байхгүй болсон нь энэ төрлийн үйл ажиллагаанд саад болж байна.

Иймд Хүчиндэх гэмт хэргийн хохирогчийн насны байдлыг харгалзан оногдуулж ирсэн ял шийтгэлийн ялгаатай байдлыг багасгах, хүндрүүлж авч үзэх; Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох; Хоригдлыг ялангуяа төлбөртэй хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн орчныг сэргээх нь зүйтэй.

8. Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7% нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой гэснээс үзэхэд “оюуны хомсдол”-той хүмүүсийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгааг харуулж байна. Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх; Мөн хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын **53.4% нь 17-21 насны залуус эзэлж байгаа тул өсвөр үе, залуучуудад чиглэсэн хүмүүжил, хууль, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хийх шаардлагатай байгааг харуулж** байна.

9. ХЗДХЯ-наас хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлсэн “Хууль зүйн цахим нэгтгэл” мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох төсөл, мөн ХСИС-иас ХЗДХЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” судалгааны төслийн үр дүнд бий болсон эдгээр байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийн ашиглалтыг хөгжүүлж, **“цагдаад бүртгэгдсэн, цагдаагаас шилжүүлж, прокурор хүлээн авсан, прокурор шилжүүлж, шүүх хүлээн авсан, шүүхээс шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээллийн урсгал”-ыг** харуулсан статистикийн үзүүлэлтийг сайжруулан гаргаснаар гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

--0--

УДИРТГАЛ

Монгол Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид 1999 онд, Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай 182 дугаар конвенцид 2002 онд, Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох Палермогийн протоколд 2008 онд тус тус нэгдэн орсон. Эдгээр олон улсын гэрээ нь улс орнуудыг хүүхдийн тэвчишгүй хэлбэрүүд болон хүүхдийн бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх арга хэмжээг хойшлуулшгүй авахыг шаарддаг.

Манай улсын тухайд сүүлийн жилүүдэд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж түүнд насанд хүрээгүй хүн өртөх тохиолдол нэмэгдсээр байна. Шүүхийн шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн тоо мэдээгээр бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн улмаас тус хүрээлэнгээр шинжилгээ хийлгэгчдийн 45.6% буюу 881 нь 0-19 хүртэлх насны хүүхдүүд², 108 хүүхдийн тусламжийн утсанд 2014 онд 46, 2015 онд 131, 2016 онд 169, 2017 оны эхний 5 сарын байдлаар 75 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн дуудлага³ бүртгэгджээ. Энэ бүхэн нь насанд хүрээгүй хүн бэлгийн мөлжлөг, хүчингийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгаа харуулж байгаа юм. Энэ бол зөвхөн бидэнд мэдэгдэж байгаа тоо мэдээлэл бөгөөд хэрэгсэхгүй болсон, буцсан, нуугдмал, тусламж авч чадахгүй байгаа гэмт хэргийн гаралт, хохирогчийг мэдэх, тооцох аргагүй юм.

Бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж гэмт хэрэгтэй холбоотой зарим тоо мэдээллээс дурдвал:

- Цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилд 947 буюу ойролцоогоор өдөрт 1 бэлгийн хүчирхийлэл бүртгэгдэж шалгагдсан. Хохирогчдын 80% орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байгаа бөгөөд насанд хүрээгүй хохирогчдын 87 хувь нь ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчид байна. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30 хувиар нэмэгдсэн. Гэвч энэ тоо мэдээ нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг бүхэлд нь илэрхийлж буй тоо мэдээ биш байх магадлалтай. Ихэнх тохиолдолд хохирогчид хууль хяналтын байгууллагад хандахгүй өнгөрөөдөг, хандсан ч хэрэгсэхгүй болох, өргөдлөө татаж авах, гомдолгүй, тохиролцсон гэх зэргээр асуудал орхигддог.

² ЭМЯ, ГС, ХТЭТ. “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018. 10-р хуудас.

³ Хөгжлийн академи ТББ. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. УБ., 2017. 1-р хуудас.

- НҮБ-аас 57 оронд хийсэн судалгаагаар⁴ энэ төрлийн гэмт хэргийн 11% нь, БНЭУ-д хохирогчдын 5-6% хуулийн байгууллагад ханддаг гэсэн бол манай улсад үүнийг тооцоолж гаргасан судалгаа одоогийн байдлаар байна.

Зөвхөн Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоо мэдээнээс харахад нийт хүн амын 17%-ийг эзэлж буй 10-29 насны 500 хүн тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн золиос болж байна. ЭМЯ, Глобал сангийн захиалгаар ХТЭТ-ийн гүйцэтгэсэн 2017⁵ оны судалгааны үр дүнгээс үзэхэд Цагдаагийн байгууллагад хандсан 3 хохирогч тутмын 2 нь шүүхээр асуудлаа эцэслэн шийдвэрлүүлсэн гэжээ.

- 2017 оны судалгаагаар⁶ хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчдын 53.7% нь ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн хохирогч болдог ба энэ нь цагдаагийн байгууллагад бүртгэгддэггүй, ихэнх тохиолдолд хохирогчийг төлөөлж эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар нь хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод л үлддэг асуудал түгээмэл, нийтлэг болсон талаарх мэргэжлийн бүлгийнхэн бүлгийн ярилцлагаар илэрхийлсэн байдаг. Түүнчлэн, 3 хүн тутмын нэг нь насанд хүрээгүй байхдаа, 10 хүн тутмын 9 нь 24 хүртэлх насандаа анх удаа энэ гэмт хэргийн хохирогч болж байсан байна.

Иймд хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, ялангуяа хэрэгсэхгүй болсон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргүүдийг судалж шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх судалгааны ажлыг Монголын Эмэгтэйчүүдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвөөс захиалж, салбарын мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны багаар *“Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг: шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс”* сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгүүлэв.

Зорилго:

Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн (ЭХ-ийн 12.1, 12.2, 12.5) гаралтад нөлөөлж байгаа шалтгаан, хүчин зүйлсийн талаар тоон болон чанарын судалгаа хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны болон эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулахад судалгааны зорилго оршив.

⁴ UN Women (May 2013). Factsheet - Global, Progress of the World's Women 2011-12 (PDF)

⁵ ЭМЯ, ГС, ХТЭТ, “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018. 10-р хуудас.

⁶ Мөн тэнд, 9-р хуудас.

Зорилт:

- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгаан, нөхцлийг тогтоох;
- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар хийгдсэн судалгааны бүтээлүүдэд дүн шинжилгээ хийх замаар судлагдсан байдлыг тодорхойлох;
- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх статистикт дүн шинжилгээ хийх;
- 2015-2017 онуудад үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох хэрэгсэхгүй болгосон хэргийг судалж, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, хүчин зүйлсийг тогтоох;
- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай 2002, 2017 оны Эрүүгийн хууль тогтоомжуудад харьцуулсан судалгаа хийж, холбогдох зүйл, заалтуудыг сайжруулах талаар санал боловсруулах;
- Олон улсын болон гадаадын зарим орнуудад “Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгаа хийх, дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах.

Хугацаа:

2018 оны 10 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 20-ны хооронд судалгааг хийж, 2019 оны 1 дүгээр сарын 02-нд тайланг захиалагчид хүлээлгэн өгөв.

Судалгаа хийсэн арга зүй:

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ юмс үзэгдлийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээнд нь бодитойгоор судлах боломж олгодог шинжлэх ухааны түгээмэл аргуудыг хэрэглэх ба сэдэвт холбогдох мэдээ баримтуудыг холбогдох эх сурвалжаас авч, албан ёсны статистик, хавтаст хэргийн материалд дүн шинжилгээ (задлах, нэгтгэн дүгнэх, харьцуулалт) хийх, ярилцлага, ажиглалт, анкетын аргыг өргөнөөр ашиглана.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн зарим аргуудыг дурьдвал:

- *Түүхчлэх, түүвэрлэх, баримт бичгийн аргыг ашиглан*, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн талаар эрдэмтэн, судлаачдын тодорхой эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг түүвэрлэн судлав.

- *Тоон судалгааны аргыг ашиглан*, Цагдаа, Прокурор, Шүүхийн төв байгууллагуудад судалгааны багаас хүсэлт гарган 2018 оны 10 дугаар сард ирүүлсэн

2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын мэдээлэлд үндэслэн энэ төрлийн гэмт хэргийн байдалд математик, статистикийн аргуудыг хууль зүйн шинжлэх ухааны зарим аргуудтай хослуулан хэрэглэж, дүн шинжилгээ хийлээ.

- *Хавтаст хэргийг уншиж, дүн шинжилгээ хийх аргыг ашиглан*, сүүлийн 3 жилд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон бодит 72 хавтас бүхий 66 хэргийг уншиж, түүнтэй тэмцэж буй практикт гарч буй алдаа, дутагдлыг засах, эрх зүйн орчныг сайжруулах саналыг дэвшүүлэв. Тодруулбал, 2015-2017 онуудад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийслэлд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргүүдийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, улмаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн.

- *Харьцуулалтын арга, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх аргыг ашиглан*, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг 2015 оны эрүүгийн хууль болон 2002 оны эрүүгийн хуульд хуульчилсан байдлыг авч үзэж, мөн Гадаадын зарим улс орнуудын бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эрүүгийн хуульд хэрхэн тусгасан судалгааг Америк, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн хийв.

- *Гэмт хэрэгт хохирохоос айх байдлын судалгааг олон улсын аргачлалаар* явуулсан судалгааны үр дүнгээс, энэ төрлийн гэмт хэргээс айх байдлын хэсгийг авч, судалгааны тайланд тусгасан онцлог судалгааны ажил болов.

- *Ажиглалт, индукци, дедикцийн аргыг ашиглан*, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгаан, нөхцөлийг томъёолон дүгнэн бичив.

- *Контент анализын аргаар*, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн талаар сүүлийн 3 жилийн хугацаанд нийтлэгдсэн, тайлбарласан, бичигдсэн сонин, сэтгүүл, цахим хуудас болон олон нийтийн сүлжээнээс интернэт болон хэвлэмэл эх сурвалжаас хайлт хийж, нийт 85 үр дүнг нэгтгэж, агуулга давхцаагүй, олон уншигчид хүрсэн гэх мэт шаардлага хангах 35 нийтлэлийг сонгож, дүгнэлт хийв.

Судалгааг ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны баг гүйцэтгэсэн бөгөөд ЦЕГ-ийн харъяа Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба болон Хэрэг бүртгэх алба, Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, ШШГЕГ, Эрүүгийн хэргийн архивын газар, ШШҮХ, ЭМЯ, Сэтгэцийн эрүүл

мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг байгууллагуудын дэмжлэгийг авч, хамтран ажиллалаа.

Судалгаа хийхдээ дараах зохион байгуулалтын дагуу хийж гүйцэтгэв. Үүнд:

- Судалгааны багийн ахлагч нь удирдамж, төлөвлөгөөний дагуу судлаачдыг удирдан зохион байгуулж, судалгааны ажлыг гүйцэтгэх;
- Судалгааг хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах болон эрх зүйн орчинг сайжруулахад нөлөөлөх бодлого боловсруулахад анхаарах асуудлыг тодорхойлох;
- Судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэх;
- Захиалагч талын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хэмжээнд судалгааг явуулж, тайлан бэлтгэх;
- Судалгааны баг нэгдмэл удирдлагыг баримталж, багийн ахлагч судалгааны үр дүнг хариуцах.

Судалгааны үр дүн:

Судалгааны үр дүнгээр тайлан гаргах бөгөөд тайланд тусгагдсан санал, зөвлөмжийг төр засгийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргагчид болон хэрэгжүүлэгчидэд хүргүүлснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх талаар үндэслэл, бүхий оновчтой шийдэлд хүрэхэд судалгааны үр дүн чиглэгдэнэ.

Түүнчлэн, бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнийг илрүүлснээр урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааны стратеги боловсруулахад чухал хувь нэмрээ оруулж болох юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ, ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн талаар эрдэмтэн, судлаачид тодорхой эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хавсарга болон дагнан хийсэн байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд энэ чиглэлээр тоон болон чанарын судалгааг гаргасан байна.

Тухайлбал, 1999 онд академич С.Нарангэрэл “Монгол Улсын эрүүгийн эрх зүй”, 1973 онд доктор (Sc.D), профессор Г.Совд “Эрүүгийн эрх зүйн курс”, 2002 онд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2011 онд доктор (Sc.D), профессор С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал), 2002 онд доктор (Sc.D), профессор Ж.Болдбаатар “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголт”, 2008 онд Ж.Болдбаатар, З.Төрмандах нар “Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий, тусгай анги”, 2011 онд доктор (Ph.D), профессор Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол” зэрэг бүтээлдээ бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжийн талаар тус тус бичсэн байна.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудлыг дагнан судалж, бичсэн нэг сэдэвт бүтээл одоогоор нийтлэгдээгүй байна.

Харин Хууль сахиулахын их сургуульд 2007-2018 онд гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн талаар нийт 14 магистрын ажил хамгаалсан байна.

Тоон судалгааны тухайд, Улсын Дээд Шүүхийн судалгааны төв, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Нийслэлийн шүүх, Нийслэлийн прокурорын газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Иргэдийн Аллианс төв, Гүнж төв, Хүний эрх, хөгжил төв, Хүйсийн тэгш эрхийн төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд энэ чиглэлээр үйл ажиллагааны тайлан, судалгааны тайлан, илтгэл, мэдээлэл бэлтгэн олон нийтэд болон шийдвэр гаргагч нарт түгээж ажиллаж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газраас ирүүлсэн материалаас харахад Хөгжлийн академи ТББ, “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл”-д хамаарах хэд хэдэн судалгааг хийж, нэгдсэн тайланг боловсруулсан байна.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн материалтай танилцсан талаарх тайлан /тайлангийн хэсгээс/:

Энэхүү судалгаагаар 2014-2016 онд шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 80 хэргийн материалтай уншиж танилцан, тайланд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- хүчингийн гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагад хэнээс, ямар хугацааны дотор гаргаж байгаа талаар;
- цагдаагийн байгууллага хүлээн авснаас хойш ямар хугацаанд шалган шийдвэрлэж байгаа талаар;
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хуулиар тогтоосон шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэх;
- хохирогч хүүхдэд холбогдогч этгээдийн талаас ямарваа нэгэн дарамт шахалт ирж буй эсэх;
- гэм буруутай этгээдэд оногдуулж буй ялын бодлогын талаар;
- хохирогч хүүхдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөл зэрэг болно.

2017 оны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 оны эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгч, хохирогч хүүхдийн талаар хэрхэн тусгасныг харьцуулан судалсан нь:

Энэхүү судалгаагаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь “хүүхэд, өсвөр насны хүнд хамаарах эрх зүйн зохицуулалт”-ыг харьцуулан судалсан байна.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт стратегийн өмгөөлөл үзүүлэх нь /судалгааны хэсгээс/:

Нийтийн болон нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах зорилготойгоор явагддаг энэхүү ажиллагаа тогтвортой, байнгын шинжтэй байж чадахгүй, түүнчлэн сум, орон нутгийн иргэд хууль зүйн туслалцаа үйлчилгээ авах хүртээмж үнэхээр сул байна.

Иймд стратегийн өмгөөллийн эрх зүйн орчныг сайжруулах замаар нийтийн болон эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн эрхийг хамгаалж, зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотой дараах ерөнхий саналыг дэвшүүлсэн байна.

- Хуульчдыг тодорхой хугацаанд орон нутагт заавал хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлдэг байх шалгуур тогтоох зэргээр орон нутагт иргэд, эмзэг бүлгийнхэн хууль эрх зүйн туслалцаа, үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Стратегийн өмгөөлөл явуулах, нийтийн болон эмзэг бүлгийнхний эрх ихэвчлэн зөрчигддөг салбарын жагсаалтыг гарган энэхүү салбар, нийгмийн тодорхой бүлгийн эрх ашиг зөрчигдвөл стратегийн өмгөөлөл явуулна гэсэн байдлаар 'target area' буюу эрх ашиг нь зөрчигдөж үүнийг стратегийн өмгөөлөл явуулах замаар эрх ашгийг нь хамгаалах хүрээг тодорхойлох;
- Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд эрх ашиг нь зөрчигдсөн аливаа иргэн, бүлэг хүмүүс, эсвэл сонирхогч этгээд (энэ нь иргэн хуулийн этгээд, тэр дундаа төрийн бус байгууллага) байж болохоор хуульчлах. Ингэхдээ, салбарын хуулиудад, тухайлбал Төрийн байгууллагын тухай"Монгол улсын хуульд төрийн бус байгууллагыг шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах эрхийг нэн даруй хуульчлан оруулах;
- Прокурор зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр бус сонирхогч этгээдийн хүсэлтээр төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн хүчин төгөлдөр эрх зүйн актуудад оруулах;
- Шүүхийн маргаанд ялагдсан тал нь ялсан талынхаа улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн нөхөн төлөгдөх зардал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, өмгөөллийн зардал зэргийг төлөх олон улсын жишигт дотоодын эрх зүйн зохицуулалтыг нийцүүлэх;
- Эсвэл стратегийн өмгөөлөл явуулахад шүүхээс аливаа төрлийн хураамж авдаггүй байх, тухайлбал, шинжээчийн зардал, нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой зардал зэргийг төрөөс гаргах, өмгөөллийн зардлыг хуульчдыг урамшуулах замаар (тухайлбал, кредит цагт тооцох, нэр хүндийг нь өргөх бусад арга хэмжээ зэрэг) шийдвэрлэх;

Анкетын аргаар иргэд, хуулийн болон хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтнуудаас хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн талаар авсан судалгааны тайлан /тайлангийн хэсгээс/:

Энэхүү судалгаанд хүүхдийн бэлгийн эрх ашгийг хамгаалахад хувь нэмэр оруулах үүрэг бүхий зорилтот бүлгүүдийн санал бодлыг харьцуулах үүднээс дараах 3 зорилтод бүлгийг сонгон авч санал асуулга явуулж, түүнийг дүгнэсэн байна. Үүнд:

- 2017 оны 11 сарын байдлаар хуулийн байгууллагад ажиллаж буй албан хаагчид;
- хүүхдийн асуудал хариуцсан ажилчид болон иргэдийн төлөөллийг хамруулсан болно;
- газар нутгийн хувьд нийслэл болон орон нутгийн төлөөллийг тус тус хамруулсан.

“Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан:

Энэхүү тайлангаар 2002 оны Эрүүгийн хууль болон 2002 оны ЭБШХ, 2017 оны ЭХХШТХ-ийг шүүхээс хэрэглэж буй байдал болон Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протоколуудыг хэрхэн хэрэгжүүлж буй байдлыг тодруулахыг зорьсон байна. Тайланд дараах чиглэлээр санал тусгагдсан байна. Үүнд:

1. Насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хүчингийн гэмт хэргийг шийдвэрлэдэг шүүгч нарт;
2. Хууль тогтоогчдод.

Монгол Улс дахь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн Гэмт явдал судлалын хүрээлэнгийн захиалгаар “Хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт” судалгааны ажлыг 2018 оны 1-5 сарын хооронд хийлгэж байна.

ХСИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирлын ахалсан судалгааны баг “Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдвээр судалгаа хийж, үр дүнгээ 2018 оны 2 дугаар сард Цагдаа судлалын профессорын багаар хэлэлцүүлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. Уг судалгаа, тайланд хүүхэд хохирсон, хүүхдийн эсрэг гэмт явдлын талаар авч үзжээ.

Энэ сэдвийн хүрээнд 1 докторын ажил, 13 орчим магистр, бакалаврын ажил бичигджээ. Үүнд:

1. Г.Ганбаатар. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал” докторын диссертаци. УБ., 2015.
2. П.Батбаатар. “Хүчиндэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал” магистрын ажил. УБ., 2007.
3. Н.Энхтуул. “Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”. УБ., 2010.
4. С.Үзмээ. “Хүчиндэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологи шинж” магистрын ажил. УБ., 2012.

5. Д.Төмөрбаатар. “Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг нотлох ажиллагаа” магистрын ажил. УБ., 2014.
6. Ө.Дэлгэрцэцэг. “16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж зүйлчлэлийн зарим асуудал” магистрын ажил. УБ., 2014.
7. С.Мөнхжин. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт явдлын криминологи шинж” магистрын ажил. УБ., 2015.
8. Н.Мөнхзул. “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга зам” магистрын ажил. УБ., 2016.
9. Д.Баасанбат. “Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг зарим гэмт хэргийн криминологи шинж” магистрын ажил. УБ., 2016.
10. Б.Хулан. “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж” магистрын ажил. УБ., 2017.
11. Н.Хулан. “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гэрч хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал” магистрын ажил. УБ., 2017.
12. Э.Онон. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн оролцоо эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал” магистрын ажил. УБ., 2018.
13. О.Энхбат. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн оролцоо эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал”. УБ., 2018.
14. Ө.Батжаргал. “Хүчиндэх гэмт хэргийн газрын үзлэгээр гэмт үйлдлийн мөртэй ажиллах онол, арга зүйн зарим асуудлууд” бакалаврын ажил. УБ., 2011.

Энэ сэдвээр дагнан бичсэн 7 эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл байна:

1. Н.Чинчулуун. “Нийгэм, олон нийтийн бэлгийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрсөн байдлыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага”. Хүний эрх. 2008. №2.
2. Г.Оюунболд. “Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин”. Хууль дээдлэх ёс. 2010. №2 (29).
3. Ю.Бадамханд. “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, тэдгээрт оногдуулах ял шийтгэлийн бодлого, харьцуулсан судалгаа”. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2012. №1 (39)
4. Д.Саруул. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн шинэтгэл”. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2014 №1 дугаар.
5. Г.Ганбаатар. “Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг дэх эрсдэл”. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2015 №3,4 дугаар.
6. Д.Баасанбат. “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг зүйлчлэхэд

анхаарах асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл. 2016 №1 дугаар.

7. Б.Хулан. “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж”. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2017 №2 дугаар.

Энэ сэдвээр 26 орчим судалгааны тайлан, ном, гарын авлага, бусад материалууд байна. Үүнд:

1. Хүний эрх хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин” судалгааны тайлан. УБ., 2002.
2. МННХ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо. “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам”. УБ., 2003.
3. Ред. П.Цэцгээ. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам” гарын авлага. 2003
4. М.Ичинноров. “Гэрлэлт дэх хүчингийн хэргийг шийдвэрлэх ба нотлох баримтын талаарх зарим асуудал” судалгаа. УБ., 2003.
5. Б.Батзориг. “Хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хохирогчтой харилцах цагдаагийн албан хаагчдын гарын авлага”. 2003.
6. Ред: С.Отгонбаяр. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги”. УБ., 2005.
7. Орч.: Г.Ануударь, Ц.Баасанжав. “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хууль эрх зүйн зохицуулалт (бусад орны хууль)”. УБ., 2005.
8. “Хүн худалдах гэмт хэрэг ба охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг” судалгааны тайлан. НҮБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхийн зөн Монгол байгууллага. УБ., 2007.
9. Хүний эрхийн үндэсний комисс. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа” УБ., 2007.
10. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдал” судалгааны тайлан. УБ., 2007.
11. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа”-ны тайлан. УБ., 2007.
12. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн Монгол Улс дахь байдал: Суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа”-ны тайлан. УБ., 2007.
13. НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын нийгэм, Эдийн Засгийн асуудал эрхлэх газрын Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах хэлтэс.

- “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа”. УБ., 2007.
14. Иргэдийн Альянс төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Хүчингийн гэмт хэргийн эрх зүйн орчин” судалгааны тайлан. УБ., 2008.
 15. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй төрөл” судалгааны тайлан. УБ., 2008.
 16. ОУ-ын хөдөлмөрийн байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах нь” дүн шинжилгээний тайлан. УБ., 2010.
 17. Г.Оюунболд, Д.Тамир, Т.Ганчимэг. “Хүүхдийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг” гарын авлага. УБ., 2010.
 18. Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин” судалгааны тайлангийн эмхтгэл-II (2010-2011). УБ., 2012.
 19. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Монгол Улс) хүний эрхийн тайлан. УБ., 2014.
 20. ХСИС-ийн ЭШХХ-ийн Цагдаа судлалын төв. “Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар эрх зүйн зохицуулалт, анхаарах зарим асуудал” судалгааны ажлын дэд тайлан. УБ., 2015.
 21. Ред: Ю.Бадамханд. “Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл” гарын авлага. УБ., 2016.
 22. Олон улсын хөгжлийн эрх зүй байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага”. УБ., 2017.
 23. Үндэсний статистикийн хороо. “Хүчирхийллийн нүцгэн үнэн” жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан. УБ., 2017.
 24. Ред: Т.Цогзолмаа. “Хууль зүйн дүн шинжилгээ (жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хэрэг)”. УБ., 2018.
 25. Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи илтгэлүүд” нийт 16 илтгэл. (2000-2017)
 26. Б.Баттуул, Ц.Мөнхбат, Б.Гүнжидмаа. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”. “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ” эмхэтгэл I. УБ., 2018.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН
ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ СТАТИСТИКТ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Энэхүү бүлгийн судалгааны дүн шинжилгээг хийхдээ Цагдаа, Прокурор, Шүүхийн төв байгууллагуудад судалгааны багаас хүсэлт гарган 2018 оны 10 дугаар сард ирүүлсэн 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын мэдээлэлд үндэслэв. Өөрөөр хэлбэл, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагуудын гаргасан тоон судалгааг ашиглан математик, статистикийн аргуудыг хууль зүйн шинжлэх ухааны зарим аргуудтай хослуулан хэрэглэж, дүн шинжилгээ хийсэн болно.

Цагдаагийн байгууллага нь 2017 онд иргэд, хуулийн этгээдээс 192618 гомдол, мэдээлэл хүлээн авсаны 78722 буюу 40.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 113896 буюу 59.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгажээ.⁷

Харин прокурорын байгууллага нь 36574 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6419 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалтанд хяналт тавьж ажилласан бол Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 10390 хэргийг хүлээн авч, 9019 хүнд ял шийтгэл хүлээлгэсэн байна.

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн бөгөөд зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4840 (36.3%), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 буюу 49.2%-иар тус тус өссөн статистик тоон үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 2017 онд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 21947 буюу 68 хувь нь Улаанбаатар хотод, 10273 буюу 31.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулбал:

Хүснэгт 2.1.

Үзүүлэлт	Улсын хэмжээнд		Улаанбаатарт		Орон нутагт	
	2016	2017	2016	2017	2016	2017
Тоо	27167	32259	17909	21974	9222	10723
Өсөлт, бууралт	18.7 хувь		22.5 хувь		11.4 хувь	

⁷ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн гэмт хэргээс харахад Дээрэмдэх гэмт хэрэг 2.6⁸ дахин, Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 2.3 дахин, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2.0 дахин өссөн байх ба хэргийн төрлөөр өсөлт, бууралтыг авч үзвэл,

Хүснэгт 2.2.

д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
		2016	2017		
1	Хүнийг алах	174	189	8.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8248	8812	6.8	27.3
3	Хүчиндэх	290	376	29.7	1.2
4	Хулгайлах	9065	12222	34.8	37.9
5	Дээрэмдэх	474	1233	2.6 дахин	3.8
6	Залилах	2165	2996	38.4	9.3
7	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	1449	727	-49.8	2.3
8	ХАБ,ТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг	1783	1525	-14.5	4.7
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	165	330	2.0 дахин	1.0
10	Бусдыг амиа хорлоход хүргэх	206	470	2.3 дахин	1.5
11	Бусад	2826	3010	-6.5	9.3

Дээрхи байдлаас харахад Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлээс хамаарч, тухайлбал, хулгайлах гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгосон, зарим гэмт хэргийг шинээр хуульчлан оруулсан, мөн урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагааны үр дүн зэргээс шалтгаалж, гэмт хэргийн гаралт нэмэгдсэн хэмээн практик байгууллагууд, зарим судлаачид үзэж байгаатай бид санал нэг байна.


Бидний судалгааны ажлыг үндсэн асуудал болох Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн байдалд 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын мэдээлэлд үндэслэн дараах дүн шинжилгээ хийлээ.

⁸2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд, 2002 оны Эрүүгийн хуульд байсан “булаах” гэмт хэргийг “дээрэмдэх” гэмт хэрэгт хамтатган хуульчилсантай холбоотойгоор 2017 онд бүртгэгдсэн “дээрэмдэх” гэмт хэргийн тоо ийнхүү өсөлттэй гарахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн.

2.1. Цагдаагийн байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, хүчиндэх гэмт хэрэг 2015 онд 279 бүртгэгдэж байсан бол жил дараалан өсч, 2017 онд 376 болж, 34.8 хувиар өссөн байна. Мөн 2018 оны эхний 10 сарын байдлаар 472 болж, **2018 оны жилийн эцсийн мэдээллээр 40-50 хувиар өсөх прогноз харагдаж байна.**

График 2.1.



Харин бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2015-2017 онуудад 21-23 орчим бүртгэгдэж байсан ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 11 бүртгэгджээ.

Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 онд 28-30 бүртгэгдэж байсан бол 2018 оны эхний 10 сарын байдлаар 38 бүртгэгдэж, **оны эцсээр 20%-иар өсөх хандлагатай** байна.

Гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын байдлыг авч үзвэл, 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар Хүчиндэх 1417 хэрэгт 1232 хүн холбогдон шалгагдаж, **1382 хүн хохирогч** болсоны 58 буюу 4.2% нь 7 хүртэлх насны, 233 буюу 16.9% нь 8-13 насны, 384 буюу 27.8% нь 14-17 насны, нийт **675 буюу 48.8% нь хүүхдүүд** байсан байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 76 бүртгэгдэж, 67 хүн холбогдон шалгагдаж, **73 хүн хохирогч** болсоны 12 буюу 16.4% нь 7 хүртэлх насны, 26 буюу 35.6% нь 8-13 насны, 6 буюу 8.2% нь 14-17 насны, нийт **44 буюу 60.3% нь хүүхдүүд** байсан байна.

Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 134 бүртгэгдэж, 119 хүн холбогдон

шалгагдаж, **133 хүн хохирогч** болсоны 17 буюу 12.8% нь 7 хүртэлх насны, 111 буюу 83.5% нь 8-13 насны **хүүхдүүд** байсан байна.

График 2.2.



Цагдаагийн байгууллагад дээрх хугацаанд бүртгэгдсэн Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт **хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар:**

2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн **1417** хүчиндэх гэмт хэргийн:

- 65 буюу 3.8%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,
- **893 буюу 63.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,**
- 33 буюу 2.3%-ийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- Одоогийн байдлаар 30.1% буюу 426 (2015 оны 7, 2016 оны 37, 2017 оны 125, 2018 оны 257) эрүүгийн хэргийн шалгалтын ажиллагаа явагдаж байна.


2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах **76** гэмт хэргийн:

- 4 буюу 5.3%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,
- **57 буюу 75.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,**
- 1 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- Одоогийн байдлаар 18.4% буюу 14 (2016 оны 3, 2017 оны 4, 2018 оны 7) эрүүгийн хэргийн шалгалтын ажиллагаа явагдаж байна.

2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох **134** гэмт хэргийн:

- 10 буюу 7.5%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,
- 88 буюу 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,
- 1 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- Одоогийн байдлаар 26.1% буюу 35 (2016 оны 5, 2017 оны 14, 2018 оны 16) эрүүгийн хэргийн шалгалтын ажиллагаа явагдаж байна.

График 2.3.




Дүгнэн үзвэл, цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн 63.0%-ийг, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн 75.0%-ийг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

2.2. Прокурорын байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Прокурорын байгууллага хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийлээ⁹.

График 2.4.



Прокурорын байгууллагаас 2015 онд хүчиндэх 402 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2016 онд буурч, 2017 онд 444 болж, 21.0%-иар өсчээ. 2018 оны эхний 10 сарын байдлаар 948 болж, **2018 оны жилийн эцсийн мэдээллээр 2.6 дахин өсөн прогноз харагдаж байна.**

2015-2016 онуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 52-63 орчим хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 24 болжээ.


2015 онд Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 56 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2017 он хүртэл буурсан боловч **2018 оны эхний 10 сарын байдлаар 78 болж, өмнөх оныхоос оны эцсээр 70%-иар өсөхөөр прогноз харагдаж байна.**

⁹ Улсын Ерөнхий прокурорын газрын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

Прокурорын байгууллага дээрх хугацаанд бүртгэгдсэн Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, хяналт тавьсанаар:


Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хүчиндэх 2161 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 916 хэрэг буюу 42.4%-ийг шүүхэд шилжүүлжээ.

График 2.5.




Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 173 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 139 хэрэг буюу 80.3%-ийг шүүхэд шилжүүлжээ.

График 2.6.



Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 232 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 107 хэрэг буюу 46.1%-ийг шүүхэд шилжүүлжээ.

График 2.7.




2.3. Шүүхийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох эрүүгийн хэргийг хүлээн авч, шийдвэрлэсэн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийлээ¹⁰.

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх 776 эрүүгийн хүлээн авсаны 697 буюу 89.8% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 776 эрүүгийн хэргийн **573 буюу 73.8%-ийг шүүхээр шийдвэрлэж**, 665 хүнд ял оноосон байна.

График 2.8.



¹⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

Шүүхээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 665 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 193 хүнд, 2016 онд 226 хүнд, 2017 онд 243 хүнд хорих ял оногдуулжээ. **Хүчиндэх гэмт хэрэгт хорих ял оногдуулалт өссөн байна.**

Шүүхээс 2015-2017 онд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 65 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 92.3% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 65 эрүүгийн хэргийн 52 буюу 80.0%-ийг шүүхээр шийдвэрлэж, 55 хүнд ял оноосон байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн 55 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, **2015 онд 18 хүнд, 2016 онд 19 хүнд, 2017 онд 18 хүнд хорих ял оногдуулжээ.**


Шүүхээс 2015-2017 онд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 69 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 87.0% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 69 эрүүгийн хэргийн 54 буюу 78.3%-ийг шүүхээр шийдвэрлэж, 65 хүнд ял оноосон байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг үйлдсэн 65 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, **2015 онд 15 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2016 онд 13 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2017 онд 15 хүнд хорих, 4 хүнд албадан ажил хийлгэх, 2 хүнд торгох ял оногдуулжээ.**

2.4. Шүүхийн шинжилгээний мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллагад хүчиндэх гэмт хэрэгтэй холбоотойгоор эр эс илрүүлэх биологийн шинжилгээ 2015 онд 969, 2016 онд 828, 2017 онд 884 удаа хийлгэжээ.


График 2.9.



Дээрх эр эс илрүүлэх биологийн шинжилгээ 2015 оны 67.0%, 2016 оны 89.1%, 2017 онд 91.5% нь эмэгтэй хүмүүс шинжилгээнд хамрагджээ.

Бэлгийн замын халдварт өвчин илрүүлэх шинжилгээ 2015 онд 888, 2016 онд 815, 2017 онд 835 удаа хийлгэжээ.


График 2.10.



Дээрх эр эс илрүүлэх биологийн шинжилгээ 2015 оны 67.0%, 2016 оны 89.1%, 2017 онд 91.5% нь эмэгтэй хүмүүс шинжилгээнд хамрагджээ.

Дээрх шинжилгээнд хүүхэл хамрагдсан байдлыг авч үзвэл¹¹,

График 2.11.



Энэ тоон үзүүлэлт нь биологийн лабораторит хийгдсэн шинжилгээний тоо. Үүнээс гадна шүүх эмнэлгийн үзлэг хийж заримд нь биологийн шинжилгээ хийгддэг.

Хүснэгт 2.3.

Он	2015						2016						2017					
	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18
эр бэлгийн эс илэрсэн	17	0	0	0	6	11	24	0	0	0	2	22	26	0	0	0	9	17
эр бэлгийн эс илрээгүй	218	0	12	31	71	104	199	0	11	35	66	87	269	0	6	24	67	172

Дээрх тоон үзүүлэлтэд зөвхөн шүүх эмнэлгээр үзлэг хийгдээд эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээ хийсэн тоон мэдээ бөгөөд биологийн лабораторид хийгдсэн шинжилгээний зарим нь үзлэгээр авсан арчдаст хийсэн байгаа бол үлдсэн нь зөвхөн цус ирүүлж хийсэн шинжилгээнүүд юм.

¹¹ Жич: Тогтоолд нас бичигдээгүй ирүүлдэг тул насыг 0 сонголтоор идэвхжүүлдэг учир 0-1 насны тоог гаргах боломжгүй байна.

Дэд дүгнэлт

1. Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн бөгөөд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 буюу 49.2%-иар тус тус өссөн статистик тоон үзүүлэлттэй байна. Ялангуяа хүчиндэх гэмт хэрэг 2017 онд 376 бүртгэгдэж, 29.7%-иар өссөн байна.

2. Цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, **Хүчиндэх** гэмт хэрэг 2015 онд 279 бүртгэгдэж байсан бол жил дараалан өсч, 2017 онд 376 болж, 34.8 хувиар өссөн. 2018 оны эхний 10 сарын байдлаар 472 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр 40-50 хувиар өсөх прогноз харагдаж байна.

Гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын байдлыг авч үзвэл, 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар Хүчиндэх 1417 хэрэгт 1232 хүн холбогдон шалгагдаж, 1382 хүн хохирогч болсоны 58 буюу 4.2% нь 7 хүртэлх насны, 233 буюу 16.9% нь 8-13 насны, 384 буюу 27.8% нь 14-17 насны, нийт 675 буюу 48.8% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн 893 буюу 63.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

Прокурорын байгууллагаас 2015 онд хүчиндэх 402 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2016 онд буурч, 2017 онд 444 болж, 21.0%-иар өсчээ. 2018 оны эхний 10 сарын байдлаар 948 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр 2.6 дахин өсөн прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хүчиндэх 2161 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 916 хэрэг буюу 42.4%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх 776 эрүүгийн хүлээн авсаны 697 буюу 89.8% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 776 эрүүгийн хэргийн 573 буюу 73.8%-ийг шүүхээр шийдвэрлэж, 665 хүнд ял оноосон байна.

Шүүхээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 665 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 193 хүнд, 2016 онд 226 хүнд, 2017 онд 243 хүнд хорих ял оногдуулжээ. Хүчиндэх гэмт хэрэгт хорих ял оногдуулалт өссөн байна.

3. **Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг** 2015-2017 онуудад 21-23 орчим бүртгэгдэж байсан ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 11 бүртгэгджээ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 76 бүртгэгдэж, 67 хүн холбогдон шалгагдаж, 73 хүн хохирогч болсоны 12 буюу 16.4% нь 7 хүртэлх насны, 26 буюу 35.6% нь 8-13 насны, 6 буюу 8.2% нь 14-17 насны, нийт 44 буюу 60.3% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн 75.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

2015-2016 онуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 52-63 орчим хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 24 болжээ.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 173 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 139 хэрэг буюу 80.3%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Шүүхээс 2015-2017 онд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 65 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 92.3% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 65 эрүүгийн хэргийн 52 буюу 80.0%-ийг шүүхээр шийдвэрлэж, 55 хүнд ял оноосон байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн 55 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 18 хүнд, 2016 онд 19 хүнд, 2017 онд 18 хүнд хорих ял оногдуулжээ.

4. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 онд 28-30 бүртгэгдэж байсан бол 2018 оны эхний 10 сарын байдлаар 38 бүртгэгдэж, оны эцсээр 20%-иар өсөх хандлагатай байна.

Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 134 бүртгэгдэж, 119 хүн холбогдон шалгагдаж, 133 хүн хохирогч болсоны 17 буюу 12.8% нь 7 хүртэлх насны, 111 буюу 83.5% нь 8-13 насны хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

2015 онд Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 56 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2017 он хүртэл буурсан

боловч 2018 оны эхний 10 сарын байдлаар 78 болж, өмнөх оныхоос оны эцсээр 70%-иар өсөхөөр прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 232 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 107 хэрэг буюу 46.1%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Шүүхээс 2015-2017 онд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 69 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 87.0% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 69 эрүүгийн хэргийн 54 буюу 78.3%-ийг шүүхээр шийдвэрлэж, 65 хүнд ял оноосон байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг үйлдсэн 65 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 15 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2016 онд 13 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2017 онд 15 хүнд хорих, 4 хүнд албадан ажил хийлгэх, 2 хүнд торгох ял оногдуулжээ.

Судалгааны ажлын хүрээнд “Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох нэгжийн гаргаж өгсөн мэдээллийг ашиглалаа. Эдгээр байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээлэл боловсронгуй болсон байна дүгнэж болохоор байна.

Цаашид ХЗДХЯ-наас хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлсэн **“Хууль зүйн цахим нэгтгэл”** мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох төсөл, мөн ХСИС-иас ХЗДХЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн **“Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал”** судалгааны төслийн үр дүнд бий болсон эдгээр байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийн ашиглалтыг хөгжүүлж, **“цагдаад бүртгэгдсэн, цагдаагаас шилжүүлж, прокурор хүлээн авсан, прокурор шилжүүлж, шүүх хүлээн авсан, шүүхээс шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээллийн урсгал”**-ыг харуулсан статистикийн үзүүлэлтийг сайжруулан гаргаснаар гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

2.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа “хүчиндэх” гэмт хэргийн жишээн дээр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын учруулсан хохирлыг барагдуулах, хохирогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны өнөөгийн байдлыг авч үзье.

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;

2.2.бүлэглэж;

2.3.гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

2.4.хохирогчийг жирэмсэн болгож;

2.5.хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

2.6.хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;

2.7.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

2.8.харгис хэрцгий аргаар;

2.9.хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол **хоёр жилээс найман жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.


3.Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол **таван жилээс арван хоёр жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг **бага насны хүүхдийн** эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол **арван хоёр жилээс хорин жил** хүртэл хугацаагаар, эсхүл **бүх насаар хорих** ял шийтгэнэ.

Өнөөдрийн байдлаар хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй нийт 530 хоригдол байна. Энэ нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна.

Зөвхөн энэ тооноос харахад хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо Монгол Улсад өндөр байгааг харуулж байна. Үүнээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 81 хоригдол ял эдэлж байна.

График 2.12.



Монгол Улсын Эрүүгийн хуульд насанд хүрээгүй эсхүл бага насны хүүхэд хүчиндсэн тохиолдолд оногдуулах ялын бодлого чанга, харин насанд хүрсэн хүнийг хүчиндсэн тохиолдолд оногдуулах ялын бодлого зөөлөн. Өөрөөр хэлбэл хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого хэтэрхий ялгаатай байгааг харуулж байна. Мэдээж насанд хүрээгүй хүн, бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд оногдуулах ял хүнд байх нь зайлшгүй гэдэгтэй санал нэг байна. Харин насанд хүрсэн хүнийг хүчиндсэн тохиолдолд оногдуулах ял хөнгөн байгаа нь ямар учир шалтгаантайг тодруулсан болон энэ асуудлыг хөндсөн нэг ч байгууллага алга байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын насны байдлыг энэ оны байдлаар авч үзвэл.


График 2.13.



Дээрх графикаас харахад 26-41 насны эрчүүд дийлэнх хувийг эзэлж байна.


Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл тус гэмт хэрэг үйлдсэн нийт хоригдлын 74,9% ажилтай байна.

График 2.14.



Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 103 буюу 20 хувь нь төлбөртэй байна. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжоор зөвхөн гэмт хэргийн материаллаг хохирлыг авч үздэг. Харин материаллаг бус сэтгэл зүй, оюун санааны хохирлыг мөнгөн илэрхийллээр тооцдоггүй нь дээрх тоон үзүүлэлттэй холбогдоно. Гэтэл хүчиндэх гэмт хэргийн хор уршиг нь материаллаг гэхээсээ илүү сэтгэл зүй, нэр хүнд, оюун санааны байдлаар илэрч байдаг. Энэ байдлаас шалтгаалж хохирогчид гэмт хэргийн талаар мэдээлэл өгөхөөс зайлсхийдэг нуун дарагдуулдаг. Энэ нь нийгэмд хүчиндэх гэмт хэрэг даамжирах, энэ төрлийн бугшмал гэмт хэрэг өсөн нэмэгдэх шалтгаан болдог.


График 2.15.



Төлбөртэй хоригдлын төлбөрийн хэмжээ, хохирол нөхөн төлсөн байдлыг авч үзвэл:

График 2.16.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдээд хоригдож буй хоригдлуудын төлбөр барагдуулалт



37 хоригдлын 58.808.240 төгрөгийн төлбөрийг ар гэрээс нь барагдуулсан бол бусад хоригдлын төлбөрийг барагдуулах зорилгоор тэднийг цалинтай ажлын байраар хангахад тус байгууллагаас ихээхэн анхаарч ирсэн. Гэвч 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т заасан “хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх” тухай заалт 2017 онд батлагдсан тус хуулийн агуулгаас хасагдсан нь хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж төлбөр барагдуулах ажилд хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл хүчиндэх гэмт хэргийн хохирлын барагдуулах зорилгоор тухайн хоригдлыг албадан хөдөлмөр хийлгэх эрх зүйн орчин байхгүй болсон.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын хохирлыг нөхөн төлүүлэхэд дараах нөхцөл байдал сэргөөр нөлөөлдөг.

- Хоригдлын ар гэрийн эдийн засгийн боломж бага мөн ар гэрийг хохирол барагдуулахыг шаардах нь хууль бус зүйл бөгөөд сайн дурын үндсэн дээр энэ үйл ажиллагаа явагддаг.
- Тухайн хоригдол хөдөлмөрийн чадваргүй байх
- Хорих ангид хоригдлыг ажлын байраар хангах боломж хязгаарлагдмал
- Хоригдол өөрөө хохирол төлбөрөө барагдуулахад санаачлагагүй байх, ажил хөдөлмөр эрхлэхээс татгалзах
- Хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх боломжгүй, энэ нь хуулиар тогтоомжоор хориглогдсон.


- Хаалттай хорих ангийн тусгай нэгжид байгаа хоригдлыг цалинтай ажлын байраар хангахад төвөгтэй.

2018 оны байдлаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн 167 хоригдол суллагдсан байна. Эдгээрийн 29 нь төлбөртэй хоригдол байсан бөгөөд тэдгээр хоригдлууд төлбөрийнхөө 45,9% буюу 14206485 төгрөгийн хохирлыг барагдуулж, 54,1% буюу 16727450 төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.

“Хохирлоо барагдуулсан тохиолдолд хугацааны өмнө суллах” эрүүгийн эрх зүйн зохицуулалт нь хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээхэд зохих үр дүнгээ өгч байгаа боловч энэ чиглэлд эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Суллагдсан хоригдлуудын төлбөр төлөлтийн байдлыг авч үзвэл:

График 2.17.



Шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай гүйцэтгэх хуудас материалыг шийтгэх тогтоолтой хамт зарим тохиолдолд ирүүлдэггүй нь төлбөр барагдуулах ажиллагаанд хүндрэл учруулдаг.


Жишээ нь: Нийслэлийн хэмжээнд хорих ял эдэлж байгаа төлбөртэй 37 хоригдлын 7 нь гүйцэтгэх хуудастай бусад нь гүйцэтгэх хуудас бичигдээгүй байгаа нь энэ чиглэлээр ажиллаж буй шүүх, шийдвэр гүйцэтгэх алба, хорих ял эдлүүлэх албаны хамтын ажиллагаа хангалтгүйг илэрхийлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөртэй хоригдолд ажил хийх боломж олгох үүднээс ажлын байрыг нэмэгдүүлж хөдөлмөрийн хөлсний хэмжээг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн.

Тухайлбал, энэ оны 10 дугаар сарын байдлаар барилгын материалын үйлдвэрлэлд 165, уул уурхайн олборлолт 58, хувцас, гутал, нэхмэл, эсгий, оёдол 309, мод бэлтгэл, модон эдлэл 105, чулуу бэлтгэл, чулуун бүтээгдэхүүн 36, газар тариалан 185, мал аж ахуй 125, гар урлал 27, хэвлэх цех 41, өөрсдийн барьж буй барилга дээр 34, туслах аж ахуйд 990, гэрээгээр 310 нийт 2075 хоригдлыг хөдөлмөрөөр хангасан нь нийт хоригдлын 67 хувийг эзлэх бөгөөд тэдэнд 559,974,8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

График 2.18.

Нийт хоригдлын хөдөлмөр эрхлэлт тоо



Энэ оны байдлаар Говьсүмбэр аймаг дахь 425 дугаар нээлттэй хорих ангид 84,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ноос угаах үйлдвэр”, “Газар Ивээл” ТӨААТҮГ-ыг түшиглэн 160,5 сая төгрөгийн өртөг бүхий “Сүлжмэл эдлэл”-ийн үйлдвэрийг тус тус ашиглалтад оруулаад байна. Түүнчлэн хуучин ажиллаж байсан үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, гадны байгууллагуудтай гэрээ байгуулах зэргээр энэ онд нийт 319 ажлын байрыг шинээр бий болгосон.

Хүснэгт 2.4. 2018 онд нэмэгдсэн ажлын байр

д/д	Анги байгууллага	Зарцуулсан төсөв /төг/	Ажлын байр	Ажлын байрны тоо
1	425-р нээлттэй, хаалттай хорих анги	84,4 сая	Ноос угаах үйлдвэр	8
2	409-р хаалттай хорих анги	160,5 сая	Сүлжмэл эдлэлийн үйлдвэр	15

3		24,1 сая	Сувинер үйлдвэрлэл	10
4		22,2 сая	Оёдлын үйлдвэр	20
5		32,2 сая	Зөөлөн эдлэлийн оёдлыг үйлдвэр	20
6	Хэрэмт цамхаг	37,2 сая	Авто машин засвар	8
7	Орон нутгийн хорих ангиудад	72 сая	Модны үйлдвэр	20
8	Гадны байгууллагатай гэрээгээр		Эсгий тавчикны үйлдвэр	25
9			Үндэсний үйлдвэрлэгч компаниудтай хамтарч	133
10	415, 435, 437-р ангиудын бүсэд		Гадны байгууллагуудтай хамтран	60
Нийт		432,6 сая		319

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдолд оногдуулах ялын бодлого хохирогчийн насны байдлаас шалтгаалан хэт ялгаатай байгаа нь насанд хүрсэн хохирогчийн зөрчигдсөн эрхийг бүрэн сэргээж чадна гэдэгт эргэлзээ төрүүлж байна. Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг нь материаллаг гэхээсээ илүү хохирогчийн сэтгэл зүй, алдар хүнд, оюун санааны хэлбэрээр илэрдэг тул үүнийг мөнгөн илэрхийллээр тооцдог эрх зүйн механизм манай улсад учир дутагдалтай байна. Энэ байдал нь хохирогч гэмт хэргийн золиос болсноо нуух, гэмт этгээдийг илчлэхээс эмээх цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд бугшмал байдлаар өсөн нэмэгдэх эрсдэл байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын ихэнх нь бага насны эсхүл насанд хүрээгүй хүн хүчиндсэн байгаа нь дээр дурдсан ялын бодлогын оновчтой биш байдалтай холбоотой. Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдол ихэвчлэн хохирол төлбөргүй байдаг нь дээр дурдсан шалтгаан нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс төлбөртэй хоригдлын төлбөрийг барагдуулах тэднийг цалинтай ажлын байраар хангах зорилгоор тодорхой ажил зохион байгуулж ирсэн боловч хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс шинэ хууль тогтоомжоор байхгүй болсон нь энэ төрлийн үйл ажиллагаанд ихээхэн саад болж байна.

Иймд Хүчиндэх гэмт хэргийн хохирогчийн насны байдлыг харгалзан оногдуулж ирсэн ял шийтгэлийн ялгаатай байдлыг багасгах, хүндрүүлж авч үзэх; Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох; Хоригдлыг ялангуяа төлбөртэй хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн орчныг сэргээх нь зүйтэй.

2.6. Эрүүгийн хуулийн 12.1, 12.2, 12.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг дээр хийгдсэн шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний дүгнэлтэнд хийсэн судалгааны үр дүн


2015-2017 онд Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1 дүгээр зүйлд заасан хэргүүдэд нийт 332 шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийсэн байна.

Эрүүгийн шинэчилсэн хуулийн 12.2, 12.5 дугаар зүйлээр 2015-2017 онуудад сэтгэцийн байдлын магадлан шинжилгээ хийгээгүй байна.

Дээрх шинжилгээг хэргийн төрлөөр авч үзвэл,

- 126.1-р зүйлд заасан хэрэгт 138 буюу 41.5 хувь
- 126.2-р зүйлд заасан хэрэгт 19 буюу 5.7 хувь
- 126.3-р зүйлд заасан хэрэгт 90 буюу 27.1 хувь
- 126.2.4-р зүйлд заасан хэрэгт 20 буюу 6 хувь
- 126.2.6-р зүйлд заасан хэрэгт 6 буюу 1.8 хувь
- 125.1-р зүйлд заасан хэрэгт 2 буюу 0.6 хувь
- 125.2-р зүйлд заасан хэрэгт 12 буюу 3.6 хувь
- 12.1-р зүйлд заасан хэрэгт 32 буюу 9.6 хувь
- 12.1.4-р зүйлд заасан хэрэгт 11 буюу 3.3 хувь
- 12.1.3-р зүйлд заасан хэрэгт 2 буюу 0.6 хувь

График 2.19.



Судалгаанд хамрагдагсдыг хүйсээр нь авч үзвэл, эрэгтэй 198 буюу **53.6** хувь, эмэгтэй **134** буюу **40.3** хувь нь байна.


График 2.20.



Гэмт хэргийн хохирогч нарыг оноор нь авч үзвэл:


- 2015 онд 41 буюу 26.6 хувь
- 2016 онд 58 буюу 37.6 хувь
- 2017 онд 55 буюу 35.7 хувь

График 2.21.



Гэмт хэрэгт холбогдогчдыг оноор нь харьцуулан үзвэл нийт 198 холбогдогч бүртгэгдэж 2017 онд гэрчээр 1 иргэнд шинжилгээ хийсэн байна.

- 2015 онд 37 буюу 18.6 хувь
- 2016 онд 94 буюу 47.4 хувь
- 2017 онд 67 буюу 33.8 хувь



2015-2017 онд дээрх гэмт хэргийн хэргийн холбогдогч, хохирогч нарт шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийсэн дүгнэлтээс харахад:

2015 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой ШСЭСМШ хийлгэгсдийн **21 /7** холбогдогч, 14 хохирогч/ буюу **5.8** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.

Үүнд: **7 /33.3 хувь/ холбогдогчид** “оюуны хөнгөн хомдол”, “тархины өвчин, гэмтэл үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний ба зан төрхийн бусад органик эмгэг, харин **14 /66.6 хувь/ хохирогчид** “төрх үйлийн эмгэг”, “сэтгэл түгших ба сэтгэл гутрах эмгэг”, “төрх үйлийн эмгэг давамгайлсан дасан зохицолтын эмгэг”, “оюуны хөнгөн хомдол”, “хөнгөн хэлбэрийн сэтгэл гутрал” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

2016 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой ШСЭСМШ хийлгэгсдийн **30 /10** холбогдогч, 20 хохирогч/ буюу **8.3** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.

Үүнд: **10 /33.3 хувь/ холбогдогчид** “оюуны хомсдол, шинж тэмдгийн уналт”, “сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол”, “тархины өвчин, гэмтэл үйлийн хямралын шалтгаант бие хүний ба төрх үйлийн органик эмгэг шинж тэмдгийн уналт, зан төрхийн өөрчлөлт сэтгэц органик хам шинж”, “оюуны хөнгөн хомсдол”, харин **20 /66.6 хувь/ хохирогчид** “оюуны хөнгөн хомсдол, шинж тэмдгийн уналт”, “бусад бүлэгт ангилагдсан тодорхой өвчний үе дэх хэсэгчилсэн тэнэгрэл”, “зан үйлийн хямрал давамгайлсан дасан зохицохуйн эмгэг”, “холимог диссоциатив эмгэг”, “сэтгэлийн дарамтанд хариулах цочмог хариу урвал” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

2017 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой ШСЭСМШ хийлгэгсдийн **37 /11** холбогдогч, 26 хохирогч/ буюу **23.7** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.


Үүнд: **11 /29.7 хувь/ холбогдогчид** “оюуны хөнгөн хомсдол”, “тархины гэмтлийн шалтгаант уналт зан төрхийн өөрчлөлт”, харин **26 /66.6 хувь/ хохирогчид** “оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдол”, “гэмтлийн дараах стрессийн хариу урвал”, “түгшүүрлэх, сэтгэл гутрал холимог хариу урвал давамгайлсан дасан зохицлын эмгэгт”, “дасан зохицолтын эхлэл, ээнэгшлийн байдал”, “гэмтлийн дараах стрессийн

эмгэг”, “сэтгэл гутрал сунжирсан хариу урвал бүхий дасан зохицохуйн эмгэг” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

“Сэтгэцийн хувьд эрүүл” гэж оношлогдсон:

- 2015 онд 57 буюу 15.9 хувь
- 2016 онд 126 буюу 35.1 хувь
- 2017 онд 87 буюу 24.3 хувь

График 2.23.



Хүчингийн гэмт хэргийн холдбогдогч нарын 354 нь сэтгэцийн хувьд эрүүл хэрэг хариуцах чадвартай


Хэрэг **хариуцах** чадвартай:

- 2015 онд 78
- 2016 онд 154
- 2017 онд 122

Хэрэг **хариуцах** чадваргүй:

- 2015 онд 2
- 2016 онд 2
- 2017 онд 3

График 2.24.



Хэрэг хариуцах чадваргүй 3 холбогдогч нь 2015 онд сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгосон. Үүнд: “Оюуны хүндэвтэр хомсдол”, “бие хүний эмгэг зан төрхийн өөрчлөлт, шинж тэмдгийн уналт, тархины өвчин, эмгэг үйлийн хямралын шалтгаант бие хүний ба төрх үйлийн органик эмгэг, шинж тэмдгийн уналт”, “зан төрхийн сэтгэц органик хам шинж” зэргээр оношлогдсон байна.


Хэрэг хариуцах чадваргүй 1 холбогдогч нь 2016 онд “тархины өвчин, гэмтэл үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний төрх үйлийн органик”, 1 хохирогч нь “оюуны хүндэвтэр хомсдол шинж тэмдгийн уналт таталт” зэрэг сэтгэцийн эмгэгийн оношоор оношлогдсон байна.

Хэрэг хариуцах чадваргүй 1 холбогдогч нь 2017 онд “оюуны хүндэвтэр хомсдол”, 2 хохирогч нь “шизоаффектив эмгэгийн холимог хэлбэр”, “оюуны хүндэвтэр хомсдол” оношоор оношлогдсон байна.

2015-2017 онд сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч, холбогдогч нийт 88, үүнээс 58 буюу 65.9% нь хохирогч, 34% нь холбогдогч байна.

Хэрэг хариуцах чадвартай хэдий ч сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч холбогдогч нарыг оноор нь авч үзвэл:

График 2.25.



Хохирогч нарыг насны бүтцээр нь харуулбал;

Хүснэгт 2.7.

№	Нас	2015 он	2016 он	2017 он
1	0-5 нас	0	5	1
2	6-10 нас	5	9	7
3	11-16 нас	17	27	25
4	17-21 нас	12	5	6
5	22 дээш нас	5	11	11

Холбогдогч нарыг насны бүтцээр нь харуулбал;

Хүснэгт 2.8.

№	Нас	2015 он	2016 он	2017 он
1	0-5 нас	0	0	0
2	6-10 нас	0	0	0
3	11-16 нас	1	4	1
4	17-21 нас	4	82	51
5	22 дээш нас	35	9	12

Дүгнэн үзвэл, судалгааны ажлын хүрээнд 2015-2017 онуудад үйлдэгдсэн Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1, 12.2, 12.5 дугаар зүйл ангид холбогдсон хэрэг дээр хийгдсэн шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээг хийлээ.

Дээрх хэргүүдийн 88 хувь нь хүчиндэх (126.1), (12.1) гэмт хэрэг зүйл эзэлж байна.

Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд эзэлж байгаа ч, насны хувьд бага насны хүүхэд өртөж байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч 44.8 хувь нь 11-16 насны охид эзэлж байна.

Тухайн онуудад нийт 361 хохирогч, холбогдогч хамрагдсанаас сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан 88, үүнээс 58 /65 хувь/ хохирогч нь эмэгтэй байна.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7 хувь нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой байлаа.

Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4 хувь нь 17-21 насны залуус эзэлж байна.

Цаашид сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7% нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой гэснээс үзэхэд “оюуны хомсдол”-той хүмүүсийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгааг харуулж байна. Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх; Мөн хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4% нь 17-21 насны залуус эзэлж байгаа тул өсвөр үе, залуучуудад чиглэсэн хүмүүжил, хууль, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Жич: Дэлгэрэнгүй хүснэгтэн мэдээллийг хавсаргав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГҮҮДИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ҮНДЭСЛЭЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН ХЭМЖЭЭНД)


Зорилго нь: 2015-2017 онуудад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийслэлд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргүүдийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, улмаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг сайжруулах стратеги боловсруулахад оршино.

Судалгааны ажил хийхдээ шинжлэх ухааны судалгааны арга болох анализ, синтез, социологи, математик боловсруулалтын арга хэрэглэв.

3.1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа /2015-2017/

Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн тусгай ангийн /цаашид ЭХТА гэх/ 122 дугаар зүйл буюу 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, 125 дугаар зүйл буюу бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 126 дугаар зүйл буюу хүчиндэх зүйл ангиар зүйлчлэгдсэн нийт 72 хавтас бүхий 66 хэрэг байгаагийн 17 нь Чингэлтэй, 10 нь Хан-Уул, 29 нь Баянзүрх, 10 нь Сүхбаатар дүүрэгт тус тус байна. Эдгээр хэргийг Эрүүгийн хуульд заасан зүйл ангиар нь авч үзвэл:


График 3.1. Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, дүүргээр



1) Чингэлтэй дүүрэгт ЭХТА:

- 122 дугаар зүйлийн 122.1-д /хохирогчийг 16 насанд хүрээгүйг мэдсээр байж хурьцал үйлдэх/ зааснаар зүйлчлэгдсэн хэрэг - 1,
- 125 дугаар зүйлийн 125.1-д /хүсэл зоригийн нь эсрэг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан/ зааснаар зүйлчлэгдсэн хэрэг - 1,
- 126 дугаар зүйлийн 126.1-д /хохирогчид хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан хурьцал үйлдэх/ зааснаар зүйлчлэгдсэн - 10,
- 126 дугаар зүйлийн 126.2.4- гаар /насанд хүрээгүй хүнийг/ - 2,
- 126 дугаар зүйлийн 126.2.6- гаар /бүлэглэж буюу үгсэн тохирсон бүлэг үйлдсэн/ - 3, **нийт 10 хэрэг;**


График 3.2. Чингэлтэй дүүрэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, зүйлээр ангиар



2) Хан-Уул дүүрэгт:

- 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар зүйлчлэгдсэн хэрэг - 2,
- 125 дугаар зүйлийн 125.1 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 1,
- 126 дугаар зүйлийн 126.1 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 6,
- 126 дугаар зүйлийн 126.2.4 - өөр зүйлчлэгдсэн хэрэг - 1, **нийт 10 хэрэг;**


График 3.3. Хан-Уул дүүрэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, зүйлээр ангиар



3) Баянзүрх дүүрэгт:

- 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар зүйлчлэгдсэн хэрэг - 2,
- 125 дугаар зүйлийн 125.1 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 2,
- 126 дугаар зүйлийн 126.1 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 17,
- 126 дугаар зүйлийн 126.2 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 1,
- 126 дугаар зүйлийн 126.2.4 - өөр зүйлчлэгдсэн хэрэг - 5,
- 126 дугаар зүйлийн 126.3 - аар зүйлчлэгдсэн хэрэг - 2, **нийт 29 хэрэг,**


График 3.4. Баянзүрх дүүрэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, зүйлээр ангиар



4) Сүхбаатар дүүрэгт:

- 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар зүйлчлэгдсэн хэрэг - 1,
- 126 дугаар зүйлийн 126.1 - ээр зүйлчлэгдсэн хэрэг - 4,
- 126 дугаар зүйлийн 126.2.6 - аар зүйлчлэгдсэн хэрэг - 4,
- 126 дугаар зүйлийн 126.3 - аар зүйлчлэгдсэн хэрэг - 1, **нийт 10 хэрэг шалгагдаж хэрэгсэхгүй болжээ.**


График 3.5. Сүхбаатар дүүрэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, зүйлээр ангиар



2015 онд 23 хэрэг, 2016 онд 22, 2017 онд 21 хэргийг хэрэгсэхгүй болгосон ба нийт эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдсан хэргээс нийт 5 хэрэг буюу:

- 3 хэргийн эзэн холбогдогч нь тогтоогүй,
- 1 хэргийн эзэн холбогдогч тодорхой ч хаа байгаа нь тодорхойгүй,
- өөр 1 хэргийн мөн л эзэн холбогдогч нь тодорхой ч улсын хил давж явсан нь тогтоогдсон зэргээр шалгаж байгаад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн үндэслэлээр хэргүүдийг хэрэгсэхгүй болгосон байна.

График 3.6. Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, 2015-2017 онд




Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг нийгэм, хүн ам зүйн шинжээр нь тодорхойлбол:

Насны байдал:

0-7 насны -2, 8-13 насны - 4, 14-16 насны - 28, 17-21 насны - 10, 22-27 насны - 13, 28-36 насны - 3, 42-68 насны 8 эмэгтэй байна.


График 3.7. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогч, насны байдлаар



Боловсрол:

- Дээд боловсролтой – 7,
- Бүрэн дунд боловсролтой – 22,
- Бүрэн бус дунд боловсролтой – **23**
- Тусгай дунд боловсролтой – 4,
- Бага боловсролтой – 10
- Боловсролгүй – 2.

График 3.8. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогч, боловсролоор



Ажил эрхлэлт:


Ажилтай – 16, Ажилгүй – 11, Тэтгэвэрт 4, Группэд – 1, Оюутан – 9, сурагч -27 байна. Эдгээр 27 сурагчдыг ангиар нь ялган үзвэл:

- ✓ XII ангийн 2,
- ✓ XI ангийн 7,
- ✓ X ангийн 6,
- ✓ IX ангийн 2,
- ✓ VIII ангийн 4,
- ✓ VII ангийн 4,
- ✓ I ангийн 2 хүүхэд байгаа бол, Их, дээд сургууль, коллежид сурч буй

оюутнуудын тухайд:


- IV дүгээр курсийн оюутан 2,
- III дугаар курсийн оюутан 2,
- II дугаар курсийн оюутан 3,
- I курсийн оюутан 1,
- коллежийн оюутан 1, нийт 9 оюутан байна.

График 3.9. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогч, ажил эрхлэлтээр



Хохирогчдын оршин сууж буй газраар нь авч үзвэл: Нийт хохирогчдын 44 нь буюу 64.7 % нь гэр хороололд, 2 буюу 3 % нь гэр хороолол дахь нийтийн байранд, 3 буюу 4.4 % нь хөдөө, 15 буюу 22 % нь хотын захын байшингуудад, 2 буюу 3 % нь оюутны байр, подвал, зусланд тус тус амьдарч байна.


График 3.10. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогч, оршин сууж буй газраар



Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл:

- Ажлын байранд 5,
- Баар, паб, зочид буудалд 12,
- Такси үйлчилгээнд явдаг хувийн машинд 7,
- Гэр хороолол дахь нийтийн байранд 2,
- Зусланд 2,
- Байшинд 11,
- Гэрт 20,
- Гэр хорооллын гудамж жалгад 3 гэмт хэрэг үйлдэгджээ.

График 3.11. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогч, үйлдэгдсэн газраар



Дээрх үзүүлэлтүүд нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт аль ч насны эмэгтэйчүүд ялангуяа хүүхэд, хөгшид ч өртдөг болохыг илтгэхийн зэрэгцээ улсын нийслэлд хотын захын гэр хороололд амьдардгийнхаа хувьд хувь хүн, нийгмийн тодорхой хэсгийн (хүүхэд, эмэгтэйчүүдийн) эрх ашиг ноцтой зөрчигдөж байдгийг харуулж байна.

3.2. Хэрэгсэхгүй болгосон хэргүүдэд хийсэн дүн шинжилгээ

1) Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн талаар хуулийн байгууллагад мэдээлэл ирүүлж буй байдал:

Судалж байгаа хэргүүдийн материалаас харахад гэмт хэрэг үйлдсэн талаарх мэдээллийг дараах байдлаар өгсөн байна. Энэ нь:

- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 29 хохирогч,
- 13-18 насны хүүхдүүд уг гэмт хэргийн улмаас хохирсон тухай 22 эхчүүд,
- Хохирогчийн хамаатан садан ихэвчлэн, төрсөн болон нагац эгч 11,
- Гүйцэтгэх ажлын шугмаар 1 хэрэг,
- Эмнэлэгийн байгууллага бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч үйлчлүүлсэн тухай 2 мэдээлэл,
- Насанд хүрсэн хүүхэд нь ээжийгээ хүчиндүүлсэн тухай нэг мэдээллийг тус тус Цагдаагийн байгууллагад ирүүлжээ.

Насанд хүрээгүй хохирогчдын хувьд өөрийн хүсэл сонирхолдоо /санхүүгийн хэрэгцээ шаардлага, загвар өмсөгч болох г.м./ хөтлөгдөн бэлгийн харьцаанд ордог байна. Тухайлбал, 15 настай Б нь мэдүүлэхдээ: FB хаягаар танилцсан 27 настай Н-ээс мөнгө өгөөч гуйсан ба Н нь Б-тэй өмнө нь бэлгийн харьцаанд орж байсан, ирээд мөнгө ав гэж хэлээд бэлгийн харьцаанд орчихоод мөнгө өгөөгүй учир Б цагдаагийн

байгууллагад Нөөрийг нь хүчиндсэн хэмээн гомдол гаргажээ. /Эрүүгийн 2014250007495 тоот хэрэг/

Эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ жирэмсэн болсон, эсхүл бэлгийн харьцаанд орсон тухай мэдмэгц болсон асуудлын талаар хүүхдээсээ загнаж асуудгаас хохирогч өөрийгөө буруутгуулахгүй тулд ихэвчлэн үл таних хүнд хүчиндүүлсэн гэж хэлснээр эцэг эх нь хүүхдээ бусдад хүчиндүүлсэн гэж хуулийн байгууллагад мэдээлдэг. Жишээ нь: Эцэг эх нь 2 хоног охин нь байхгүй байхад хуулийн байгууллагад мэдэгдээгүй, зөвхөн найз нөхдөөс нь сурж байсан ба охиныг ирэхэд хаачаад ирэв гэж загнахад охин айсандаа үл таних хүнд хүчиндүүлсэн гэснээр ээж нь ЦБ-д хандсан байна. Харин хохирогч яллагдагч надад таалагддаг хамт баймаар санагдаад 2 хоног хамт байсан гэсэн мэдүүлэг, яллагдагч: А манай аав ээж хөдөө явсан, би чамтай хоноё гэхээр нь дагуулаад ахындаа очиж хоносон. Бид эхний өдөр бэлгийн харьцаанд ороогүй 2 дахь өдөр бэлгийн харьцаанд тохиролцож орсон. 2 дахь өдөр нь би А-г гэр рүү яв аав, ээж чинь санаа нь зовж байгааш дээ гэхэд гайгүй байхаа гэсэн А утсаа унтраасан байсан болохоор нь ядаж утсаа асаа гэхэд миний утас нэг унтрахаараа асдаггүй юм гэсэн. Тэгвэл миний утсаар залга гэхэд яах юм бэ гээд байсан гэсэн мэдүүлэг болон гэрчийн мэдүүлэг зэрэгт үндэслэн гэмт хэрэг үйлдэгдээгүй буюу гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. /Эрүүгийн 201525011496 тоот хэрэг/

Өөр нэг тохиолдолд эмээ нь 15 настай, сурагч охиноо жирэмсэн болохыг мэдээд захаас ураг зулбуулдаг хятад эм худалдан авч уулгаснаар охин цус алдаж эмнэлэгт хүргэгдсэн. Эмнэлэгийн байгууллагад эрт хандаагүй шалтгааныг тодруулахад сургуульд нь мэдэгдэх байх гэж бодоод гэрээрээ зохицуулахыг илүүд үзсэн гэсэн бол, өөр нэг хэрэг дээр ээж нь 15 настай, сурагч охиноо хүчиндүүлээд жирэмсэн болсныг мэдэж ургийг таслан зогсоолгоод мөн л охин онц сурдаг, нэр төрийг нь сэвтүүлмээргүй байна гэсэн, хохирогчийн хувьд 17 настай яллагдагчийг уучилж байна тиймээс хэргийг хааж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураар эвлэрсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. /ЭХ201625011741, ЭХ201625022155/

Бас нэг тохиолдолд 7 дугаар ангийн сурагч охин 2014.12.08-д 15 настай Э-тэй бэлгийн харьцаанд орсон ба 3 хоногийн дараа буюу 2014.12.12-д “Э”, “И” нарт хүчиндүүлсэн гэж хуулийн байгууллагад мэдэгдэн, мэдээллийг шалгаж байх хугацаанд 2014.12.13"-д урьд өдөр нь хүчиндсэн гэх Э-тэй дахин бэлгийн харьцаанд орсон, хохирогч бусдыг онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан худал мэдүүлэг гаргасан нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон боловч эрүүгийн хариуцлага хүлээх насанд

хүрээгүйн улмаас хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. /Эрүүгийн 2015250000360 тоот хэрэг/

Харин насан хүрэгчдийн тухайд ихэнхдээ тухайн гэмт хэргийн улмаас хохирсон тухайгаа хуулийн байгууллагад өөрсдөө мэдэгддэг бол, цөөн тохиолдолд эгч дүүс нь мэдээлдэг байна. Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч нас ахих тусам үр хүүхдээсээ зовсондоо хэргийг хурдан хаалгахыг хүсэмжилдэг байна. Тухайлбал, Жигжидийн зусланд зусаж байсан 74 настай эмэгтэйг 2009.08.03-д 18 цагийн орчим зуслангаас холгүй модон дотор салхилж явахад нь үл таних хүн отвертикээр сүрдүүлэн шоронгоос гарсан гэж айлгаж ээмэг бөгжийг нь аваад, хоолойг нь боож хүчиндсэн. Хохирогч үр хүүхэд мэдэх бий дахин цагдаагийн байгууллагаар явахгүй гэсэн ба гэмт хэрэг үйлдсэн эзэн холбогдогч нь тогтоогдохгүй байсаар 2015.04.13-д хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ. /Эрүүгийн 20941083 тоот хэрэг/

Зарим иргэдийн хувьд бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг мөнгө олох боломж болгосон биш биз гэсэн сэтгэгдэл төрүүлэхээр хэрэг ч байна. Тухайлбал, хохирогч мэдүүлэхдээ: С нь миний гомдлыг барагдуулж 500.000₮ өгч, уучлал гуйсан учраас би гомдол саналгүй. Тухайн үед би их согтсон байсан ухаангүй болж тасарчихсан болохоор С-д зөвшөөрч бэлгийн харьцаанд орсон эсэхээ санахгүй байгаа юм. Одоо гомдолгүй болохоор хэргийг хааж өгнө үү гэсэн бол /Эрүүгийн 201625011442 тоот хэрэг/, өөр нэг хохирогчийн ах, эгч яллагдагчаас 8.000.000₮ авсан байх ба хохирогч надад хэдэн төгрөгний хохирол учирсныг би мэдэхгүй, надад 8 сая төгрөгний хохирол учирсан гэх баримт байхгүй. Яллагдагчийн ар гэрийнхэн ирээд мөнгө өгье гээд байсан, тэгээд л ах эгчийн дансыг өгөөд мөнгийг нь авсан гэсэн мэдүүлэг байх ба яллагдагч нарын хувьд мэдүүлэгтээ хүчиндээгүй тохиролцсон гомдолтой гэсэн байх боловч оюутанууд учраас сургуулиасаа хөөгдөхөөс эмээхдээ хохирогч талын хүссэн мөнгийг төлдөг байна. Энэ төлбөрийг авахдаа мөрдөгчид мэдэгдэлгүй өөр хоорондоо тохиролцож өгч, авалцаад харин мөрдөгчид хохирол өгсөн мөнгөний баримтыг авчирч өгч хэрэгт хавсаргасан байна. Харин прокурор дээрхи хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ. /Эрүүгийн 2014250005206 тоот хэрэг/

2) Гэмт хэргийн хохирогчдын талаар

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн охидын хувьд:

- 8 охин (15 насны 5, 14 насны 2, 13 насны 1) хүчирхийлэгчтэй FB-ээр танилцан харилцаж байсан,

- 3 охин (14 насны 2, 15 насны 1) сагсны талбай дээр тоглож байгаад танилцан найзалж байсан,
- 14 насны 1 охин автобусны буудал дээр танилцан найзалж байсан,
- 12,17 насны 2 охин найз нөхдөөрөө дамжуулан хүчирхийлэгчтэй танилцан найзалж байжээ.

Гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон 12 хохирогчийн (17 насны 1, 15 насны 4, 14 насны 3, 13 насны 1) 9 нь гэмт хэрэг үйлдэгдсэн гэж хуулийн байгууллагад бүртгэгдсэн өдрөөс өмнө нь гэмт этгээдтэй танил төдийгүй 1-2 удаа бэлгийн харьцаанд орсон байсан бол, 14 настай 2, 15 настай 1 хохирогч хүчиндүүлэхээс өмнө бусадтай бэлгийн харьцаанд орсон байсан нь мөрдөн шалгах ажиллагааны явцад шинжээчийн дүгнэлт, өөрсдийнх нь мэдүүлгээр тогтоогдсон байна.

Дүгнэн үзэхэд орчин үед өсвөр үеийнхний бэлгийн бойжилт эрт явагдаж байгаатай холбоотойгоор охид ихэвчлэн 14 наснаас, хөвгүүд 15 наснаас бэлгийн харьцаанд ямар ч эргэлзээ тээнэгэлзээгүйгээр орж байх бөгөөд 10 жилийн сургуулийн охидын хувьд хөвгүүдэд таалагдахын тулд архи уух, бэлгийн харьцаанд ороход бэлэн байх нь элбэг байна.

Иймд эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар зөвлөмж өгч байх шаардлагатай байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдын 4 нь ганц бие ээж, 5 нь нөхөртэй, 2 нь БЗХ тэмбүү өвчтэй байжээ. Насанд хүрсэн залуу эмэгтэйчүүдийн хувьд ихэвчлэн яллагдагчтай гудамж талбай, автобусны буудал дээр танилцсан байдаг бол, нас тогтсон буюу 30-45 насны эмэгтэйчүүдийн хувьд голчлон паб, бааранд танилцсан байдаг байна. Мөн үйлчилгээний байгууллагад ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд ажил нь орой тардагаас нийтийн тээврийн унаа зогссон үед такси үйлчилгээ үзүүлж буй хувийн машинаар үйлчлүүлэх явцад жолооч нар бэлгийн эрх чөлөөнд нь халдах явдал ихэвчлэн гарч байна.


3) Гэмт хэрэг үйлдэгчдийн талаар

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэжигтэн, яллагдагчаар татагдсан 58 этгээдээс 6 хүн урьд нь ял шийтгүүлсний 2 нь 2 удаа ял шийтгүүлж байсан бол 2 нь БЗХ тэмбүү өвчтэй байсан байна.

Насны байдлаар нь авч үзвэл:

14-17 насны – 18 буюу 31 %,	18-24 насны – 14 буюу 24 %,
25-30 насны 13 буюу 22.4 %,	31-36 насны – 8 буюу 14 %,
43-50 насны – 5 буюу 8.6 %	


График 3.12. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, насны байдлаар



Боловсролын байдал:

- Дээд боловсролтой – 7,
- Бүрэн дунд боловсролтой – 25,
- Бүрэн бус дунд боловсролтой -19,
- Тусгай дунд боловсролтой - 4,
- Бага боловсролтой – 3.


График 3.13. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролоор



Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

- Байнгын ажилтай – 23,
- Хувиараа ажил эрхэлдэг – 6,
- Ажилгүй – 11,
- Оюутан – 7,
- Сурагч – 11 байна.

График 3.14. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хөдөлмөр эрхлэлтээр



Дээрх тоо баримтаас харахад энэ төрлийн гэмт хэргийг боловсрол харгалзахгүйгээр үйлдэхийн зэрэгцээ, өсвөр насны хүүхдүүд үйлддэг, бүлэглэн үйлддэг болон үйлдэхийг сонирхож байгаа нь хамгийн аюултай юм.

Ийнхүү хүүхэд, залуус энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаагийн гол шалтгаан нь хийх ажилгүй, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эдийн засгийн боломжгүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна. Учир нь эцэг эх нь ажилдаа өглөө эрт яваад орой ирдэг бол хүүхэд нь хичээл тарснаас хойш эцэг эхээ иртэл хэний ч хараа хяналтгүй байцгааж байна.

4) Гэмт хэргийн хор уршгийн талаар

Хохирогчдоос 14 насны 3, 15 насны 3, 16 насны 1, 17 насны 1, 19 насны 1 хохирогчид гэмт хэргийн улмаас жирэмслэн таслан зогсоох арга хэмжээ авагдсан бол 28 насны хохирогчийн ураг ихэр байснаас хүүхдүүдээ төрүүлэхээр болсон байна.

Дээрх гэмт хэргүүдээс дагавар охиноо хүчиндсэн 2, хүчиндэхийг завдсан 1 гэмт хэрэг үйлдэгдсэн.

Хохирол нөхөн барагдуулалтын тухайд 66 хэргийн хохирогчдоос 9 хохирогч ямар нэг хэмжээгээр нөхөн төлбөр авсан байна. Эдгээр нь:

- 201425005206 дугаартай хэрэг дээр 8.000.000₮,
- 2015260000936 дугаартай хэрэг дээр 400.000₮,
- 201525011364 дугаартай хэрэг дээр 1.055.000₮ нэхэмжилснээс 350.000₮,
- 201525011500 дугаартай хэрэг дээр 1.000.000₮
- 201525040399 дугаартай хэрэг дээр 15.000.000₮,
- 201626030402 дугаартай хэрэг дээр 2.160.000₮,
- 201625010039 дугаартай хэрэг дээр 2.000.000₮,
- 201625011442 дугаартай хэрэг дээр 500.000₮ авсан,

- 201626031435 дугаартай хэрэг дээр хохирогч 1.350.000₮-ий авлагатай байснаа авахаа больсон байна.

Гэмт хэргийн улмаас хохирогчдын дийлэнх нь харилцан зөвшилцөж бэлгийн харьцаанд орсон байдгаас нөхөн төлбөр нэхдэггүй, харин хүсээгүй жирэмслэлт болон БЗХӨ авсан тохиолдолд эмчилгээний зардлаа нөхөн төлүүлэх шаардлага тавьдаг байна. Хүчиндэх гэмт хэргийн хор уршиг мөнгөөр хэмжигдэх боломжгүй байдагтай холбоотойгоор зарим иргэд мөнгө олох боломж гэж үзэж байж ч болох талтай байна.

5) Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгааны талаар:

- Нийслэлийн хэмжээнд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэргүүдтэй танилцах явцад хохирогчдын 25 буюу 36.7 % нь өөрийгөө хянах чадваргүй болтлоо согтсоноос бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Ийнхүү биеэ хянах, хамгаалах чадваргүй болсон эмэгтэйчүүдийн:
 - 7 буюу 28 % нь 14-17 насны сурагч охид,
 - 4 буюу 16 % нь 18-21 насны оюутан ,
 - 7 буюу 28 % нь 27-45 насны ажилгүй эмэгтэйчүүд,
 - 2 буюу 8 % нь 17-31 насны ажилтай эмэгтэйчүүд,
 - 2 буюу 8 % нь 53-58 насны тэтгэврийнхэн хүчиндүүлсэн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн 80 % нь хохирогчийг урьд нь таньдаг эсхүл таниулсан хүн нь хүчирхийлдэг байна. Оюутнуудын хувьд баяр ёслол, амралтын өдрүүдэд нутаг усаараа, ангиараа нийлэн архидан улмаар бэлгийн харьцаанд орж байгаа бол, ажилгүй эмэгтэйчүүдийн хувьд ямар нэг зараар эсхүл гудамжинд танилцсан хүмүүсийг даган баар, буудалд орж архидан биеэ хянах чадваргүй болсон үедээ хүчиндүүлэх, зарим тохиолдолд согтуугаар зөвшилцөж, бэлгийн харьцаанд орчихоод дараа нь хүчиндсэн хэмээн мэдүүлдэг байна.
- Үйлчилгээний байгууллагуудад 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхгүй гэсэн бичиг байрлуулсан боловч ч зөвхөн борлуулалтын хойноос хөөцөлдөж архи, пиво зарж л байвал худалдан авагчийн насны байдлыг огт сонирхдоггүйтэй холбоотойгоор насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд согтууруулах ундаа хэрэглээ болон хэвшсэн байна. Хэргийн материалаас харахад 10 жилийн сурагчид нийлж цугларсан үедээ өөрсдийн гар утас, эд зүйл зэргийг ломбардад тавин авсан мөнгөөрөө архи, олон хүнд хүртээмжтэй байдлаар нь 2-2.5 л пиво

авч хэрэглэх нь түгээмэл буюу эдгээр нь хүүхдийн ундаа болсон шинжтэй байна.

- Харин насанд хүрэгчдийн хувьд уулзаж цуглахдаа ихэвчлэн буудалд тодорхой цагаар болон хоногоор орж архидах, улмаар бусдыг хүчиндэх, хүчиндүүлэх явдал гарч байна.
- Үйлчилгээний байгууллагуудын ажлын онцлогтой холбоотойгоор ажиллагсад нь орой тардаг ч ажиллагсдаа тусгай унаагаар гэр рүү нь дөхүүлж өгдөггүйгээс нийтийн тээврийн хэрэгсэл зогссон үед хувийн таксид сууж, эд зүйлээ дээрэмдүүлэх, хүчиндүүлэх, хүчиндэхийг завдах хэргийн хохирогч болсоор байна.
- Оюутан, сурагчид FB хаягаар загвар өмсөгч болгоно, кино зураг авалтад оруулна, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн реклам, мессежнүүдэд хууртан зальтай этгээдийн хэлсэн бүгдийг хийхэд бэлэн байдаг төдийгүй FB хаяг дээрээ насаа ахиулан тавьсан нь гэмт этгээд хохирогчийн насанд хүрээгүйг мэдээгүй, FB хаяг дээрээ насанд хүрсэн гэж бичсэн байсан гэх мэтээр хариуцлагаас мултрах нэг шалтгаан болж байна.

б) Гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар:

Бидний судалсан нийт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан **ЭБШ хуульд заасан эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлээр авч үзвэл:**

- ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1., 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэг буюу гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдоогүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр нийт хэргийн **48** буюу **72.7 %**-ийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.
- ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1., 24 дүгээр зүйлийн 24.1.1. буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрснөөр 3 хэрэг,
- ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1., 24 дүгээр зүйлийн 24.1.2. буюу яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй ч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар 3 хэрэг,
- ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2. нэмэлт нотлох баримт цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй үндэслэлээр 3 хэрэг, нийт **12** хэрэг буюу **18.2 %** -ийг,

- ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3., 25 дугаар зүйлийн 25.1. буюу яллагдагч, шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан, хохирогч нь яллагдагч шүүгдэгчтэй сайн дураар эвлэрсэн үндэслэлээр 4 хэрэг буюу 6.0 % -ийг тус тус хэрэгсэхгүй болгосон бол, 2 хэргийг Эрүүгийн хуулийн IV хэсэгт заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох Өршөөл буюу уучлал үзүүлж ял эдлэхээс чөлөөлөх тухай 77 дугаар зүйлийн 77.1. буюу “Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох” тухай заалтын дагуу хэрэгсэхгүй болгожээ.

График 3.15. Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэрэг, хэрэгсэхгүй болгосон үндэслэлээр



Хэргийн шийдвэрлэсэн байдлыг Эрүүгийн хуульд заасан зүйл, анги бүрээр авч үзвэл:

1. ЭХТА-ийн 122 дугаар зүйлийн 122.1. /16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх/ дэх хэсгээр нийт 6 хэрэг шийдвэрлэсний 5 нь буюу **83.3 %-ийг** (биеийн хөгжил, өсөлттэй холбоотойгоор биеийн хөгжлийн хувьд илт бага насны хүүхэд гэж харагдаагүй) 16 насанд хүрээгүйг мэдэх боломжгүй байсан үндэслэлээр ЭБШ хуулийн 208.1.1., 24.1.1 дэх хэсгээр,

2. ЭХТА- 125 дугаар зүйлийн 125.1. /бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах/ дэх хэсгээр зүйлчлэгдсэн нийт 3 хэргийг:
 - ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр,
 - ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3., 25 дугаар зүйлийн 25.1-д заасан үндэслэлээр,
 - ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон байна.
3. 125 дугаар зүйлийн 2 дахь /бага насны хүүхдийг/ хэсгээр зүйлчлэгдсэн хэргийг ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.
4. ЭХТА-ийн /хүчиндэх/ 126 дугаар зүйлийн 126.1 дэх хэсгээр зүйлчлэгдсэн 37 хэргийн:
 - 30 буюу 81 % нь ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1.,
 - 4 буюу 10.8 % нь ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2., 24 дугаар зүйлийн 24.1.2.,
 - 3 буюу 8.1 % нь ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3., 25 дугаар зүйлийн 25.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон байна.
5. ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2 дэх хэсгээр зүйлчлэгдсэн 1 хэргийг ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр,
6. ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2.4 дэх хэсгээр зүйлчлэгдсэн 8 хэргийг ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр,
7. ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дэх хэсгээр зүйлчлэгдсэн 7 хэрэг,
8. ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.3 дэх хэсгээр зүйлчлэгдсэн 3 хэргийг ЭБШ хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгожээ.

Мөн хэргийг мөрдөн шалгах явцад 2 яллагдагчид ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2. дахь хэсэгт заасан ялыг сонгосон байсан дээр бэлгийн замын халдварт өвчтэйгөө мэдсээр байж хурьцал үйлдсэн хэрэгт ЭХТА 103 дугаар зүйлийн 103.1. заасан ялыг нэмж сонгосон бол, 1 яллагдагчид урьд сонгосон ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн

126.2.3., 126.3 дахь хэсэгт заасан ялыг хүчингүй болгож шинээр ЭХТА-ийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан ялыг сонгосон байна.

3.3. Зарим бодит кейс

Кейс-1

2017 онд нийслэлийн нэгэн дэн буудалд 3 залуу эмэгтэйг бүлэглэн хүчирхийлж, амь насын хөнөөсөн хэрэг гарчээ. Мөрдөн байцаалтаар хэрэг үйлдсэн этгээдүүд нь Орхон, Сэлэнгэ Төв аймгийн харьяат бүрэн дунд боловсролтой 22-24 насны залуучууд байна.

Хохирогч эмэгтэйг буудалд дагуулан орж архи өгч согтоогоод биеэ хамгаалах чадваргүй болгож ээлжлэн хүчиндэж уг үйлдлээ гар утсаараа зургын авсан онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогчийг ухаангүй болгон согтоож ээлжлэн хүчиндэх үедээ орон дээрээс тархиар нь унагасан бөгөөд маргааш өглөө нь хохирогч бие нь хөрсөн нүүр царай нь хөхөрсөн байх үед нь энэ хүн сонин болчихлоо гэж буудлын ажилтанд хэлж улмаар буудлын ажилтан цагдаагийн байгууллагад мэдэгдснээр мөрдөн байцаалтын ажиллагаа эхэлсэн байна. Хохирогчийн тархинд орон дээрээс унасны улмаас хүнд гэмтэл үүсч улмаар нас барах шалтгаан болжээ.

Хэргийн шалгалтын явцад хохирогч 3 хүүхэдтэй гэр бүлтэй 3 сартай жирэмсэн байсан бөгөөд хэрэг үйлдсэн залуучуудын нэгэнтэй нь 7 сарын өмнө хөдөө барилгын ажил хийж яваад танилцаж улмаар бэлгийн харьцаатай байсан байна.

Хэргийн холбогдогч нар нь Өмнөговь аймагт олон сараар барилгын ажил хийдэг бөгөөд гэрээсээ ажилдаа явлаа гэж нэг хоногийн өмнө гарч гурвуул ажилд явахын өмнө гээд тухайн өдөр хохирогч эмэгтэйг танидаг залуу нь хохирогчийг дуудан ирүүлж уг хэргийг үйлдсэн байна.

Холбогдогч нарын хувийн байдлыг тогтооход эдгээр залуусын нэг нь урд нь эхнэрээ зодож гэр бүлийн хүчирхийллийн хэргээр шийтгэгдэж байсан бол нэг нь бэлэг эрхтэндээ “бөгж” гэх зүйл хийсэн байв.

Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан:

- олон хоногоор хөдөө орон нутагт ажилладаг;
- ёс зүй ухамсрын хувьд доголдолтой;
- ерөнхий боловсролын сургуульд бэлгийн боловсролын талаар ойлголт аваагүй;
- бэлгийн талаар гаж сэтгэлгээтэй.

Хохирогчийн хувьд гэр бүлтэй хэдий ч гэр бүлээс гадуур амьдралтай, жирэмсэн гэдгээ мэдэж байсан. Холбогдогчийн нэгийг таньдаг. Хамтран архи уусан болгоомжлох, сэргийлэх талаар ямар нэгэн боломжийг огт ашиглаагүйгээс харахад хэтэрхий гэнэн итгэмтгий.

Кейс-2

Нийслэл хотын нэгэн дүүрэгт амьдардаг 70 гаран насны эр эм хоёрын эр нь эмэгтэйгээ санаатайгаар амь насын бүрэлгэсэн гэмт хэрэг үйлдэгджээ.

Мөрдөн байцаалтаар уг гэмт хэргийг үйлдсэн эрэгтэй нь урд нь нилээд боллоцооны цалин хангамжтай дарга албан тушаалд ажиллаж байсан нэгэн. Тэтгэвэртээ гарснаас хойш Улаанбаатар хотод хөгшинтэйгээ ирж амьдрах болсон. Хэргийн газрын үзлэг хохирогч холбогдогчийн хувийн байдлыг тогтоосноос үзэхэд гэр нь орон нэвт шээс шивтэр ханхалсан амьдралын хамгийн доод түвшинд амьдардаг. Эхнэр нь хүнд өвчтэй хэвтрийн байсан. Хохирогчийн хүүхдүүд нь эцэгтэй маш гомдолтой мэдүүлэгдээ манай ээжийг энэ хүн л алсан маш хүнд нөхцөлд амьдруулж, байнгын архи дан согтуурдаг гэж мэдүүлсэн бөгөөд хамгийн ноцтой нь хохирогчийн охин нь багадаа эцэгтэй хүчиндүүлж байсан байна. Тухай үед хэнд хандахаа мэдэхгүй айдсын дунд явсаар нас биед хүрч өрх тусгаарлан амьдрсан. Одоо энэ талаар гомдол гаргах уу яах уу гэдэгтээ эргэлзэж байдаг нь тогтоогджээ.

Кейс-3

Хөдөө орон нутагт 50 гаран насны эмэгтэйн гэрт шөнө 2 залуу ирж хонохдоо хүчиндсэн тухай хэрэг шалгагдсан бөгөөд сонирхолтой нь хэргийг үйлдсэн хоёр залуус нь төрсөн ах дүүс байна.

Мөрдөн байцаагч нартай ярилцахад хүчингийн гэмт хэргийн хохирогч нарын дийлэнх нь урд нь бие биенээ таньдаг, ямар нэгэн байдлаар танилын хүрээлэл дунд байдаг хүмүүс байх бөгөөд огт танихгүй хүнийг хүчиндэх нь харьцангуй бага байдаг талаар ярьж байна. Хохирогч нар ихэвчлэн хамтран архи уудаг. Хохирогчийн буруутай үйлдлүүд хэрэг гарахад бас нөлөөлдөг. Бага насны хүүхдүүд хэнд хандахаа мэдэхгүй нуудаг ингээд нуугдмал гэмт хэрэг их байх магадлалтай. Хохирогчийг хүч хэрэглэн зодож биед нь гэмтэл учруулж эд зүйлийн дээрэмдэн авч хүчирхийлэх нь харьцангуй бага байна. Хохирогчийн хүсээгүй үед нь албадан бэлгийн харьцаа хийсэн нь хүчингийн хэрэг түгээмэл байна.

Бага насны болон насанд хүрээгүй хүүхдийн хүчингийн гэмт хэргийн хохирогч нар нь эцэг эхийн хараа хяналт тааруу, гэр орны ахуй нөхцөл муу хоол унд өмсөж зүүхээр ядмагхан, эцэг эх нь хүүхдийнхээ дэргэд архи уудаг хэрүүл зодоон хийдэг, гадуур олон цөөн хоногоор тэнэдэг. Тэнээд ирэхэд нь яав ийв гэж хэлж ярьдаг хүнгүй, олон нийтийн цахим сүлжээнд тавигддаг хүчирхийлэх бэлгийн ёс бус мэдээллийг үздэг үзчихсэн, насанд хүрээгүй хүүхдүүд хоорондоо бэлгийн харьцаанд их орж байна. жирэмсэн болсон тохиолдлууд байдаг.

Уг гэмт хэргийг мөрдөж нотолоход бэрхшшэл тулгардаг. Хүчиндүүл гэх хохирогч нар ихэвчлэн дотуур хувцсаа угаагаад ирдэг. Сүүлийн үед онгон хальс нь цоорогүй төрөлхийн сэтэрхийтэй гэх тохиолдлууд гарч байна. хүчиндүүлсэн гэх боловч онгон хальс нь цоорогүй бага насны хүүхдүүд үнэнээ тэр бүр хэлж ярьж яаддаггүй ээцэг эхийнхээ дэргэд бол юу ч дугарахгүй зэрэг байдлууд байдаг гэв.

Ангийн багш нар сурагшч нартайгаа ойр дотно харьцаа үүсгэж хэн хаагуур яаж яваа талаар төдийлэн хяналт тавьдаггүй. Охидууд хэнд хандахаа мэддээгүй, бэлгийн харьцаа нь хамгийн нандин зүйл юм гэдгийг хэн ч тэдэнд ухааруулдаггүйгээс болж нэгэнт бэлгийн харьцаанд ороод үзчихсэн бол хэн хаана ч ямарч байдлаар бэлгийн харьцаанд ороход бэлэн бэлгийн харьцааг хаа хамаагүй орж байжээ.

3.4. Мөрдөн шалгах ажиллагааны талаар:

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн хэрэгсэхгүй болгосон хэргүүдийг судалж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо:

1. Эдгээр хэргийн 80 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхдээ зөвхөн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, тайлбар зэргийг үндэслэн мөрдөн шалгах ажиллагаа хийлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь өмнөх ЭБШ хуулийн 166 дугаар зүйлийн 166.1. дэх хэсэгт заасан: “Гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байвал эрүүгийн хэрэг үүсгэнэ” гэснийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байна.

Энэ нь энэ төрлийн гэмт хэргийн тоо өсч харагдах, мөрдөгч нарына ачаалал зохиомлоор өсөхөд нөлөөлж байна. Жишээ нь: дээрх хэрэгсэхгүй болгосон хэргийн материалууд нь нэг хэрэг дээр доод тал 50 хуудастай дээд тал нь 250 хуудастай байхад, зарим нэг хэрэг нэг бүр нь 250 хуудас бүхий 2-5 хавтас 1-2 жил мөрдсөн хэрэг ч байна.

Энэ нь нэг талаас алба хаагчдын ур чадварыг харуулах бөгөөд эдийн засаг талаасаа хохиролтой, хэргийн оролцогчдыг залхаах, цаг хугацаа, ахуй амьдралыг нь үрсэн шинжтэй байх ч, нөгөө талаасаа мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны ажлын ачаалал ч нөлөөлж байна гэж үзэх үндэстэй.

Сүүлийн жилүүдэд нийслэл хотод оршин суугчдын тоо нэмэгдсэн, гэмт хэргийн тоо жилээс жилд өсч байгаа энэ үед гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий алба хаагчдын тоо дээрх өсөлтийг гүйцэх хэмжээнд хүрэхгүй байгаа нь нөлөөлж байна гэж үзэж байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3., 25 дугаар зүйлийн 25.1. буюу яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохиролоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлээр хүчиндэх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа буруу практик байна.

Эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангилал хэмээх 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг.

Харин ЭБШ хуулийн 126.1 дэх хэсэгт: “Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалах чадваргүй байдлыг

далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн хэм хэмжээтэй харьцуулан үзэхэд хүчиндэх гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарахгүй.

Нөгөө талаар, хүчиндэх гэмт хэрэг нь хувийн болон төрийн яллах ажиллагааны буюу хосолсон яллах ажиллагааны гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хүчиндэх гэмт хэрэг нь хохирогчийн /насанд хүрсэн/ гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэх боловч, төрийн яллах ажиллагаа нэгэнт эхэлсэн бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг дуустал явуулах учиртай.

Тиймээс байцаан шийтгэх ажиллагаа явагдаж эхэлсэн бол, тухайн хохирогч санал хүсэлтээ илэрхийлж болохоос гомдлоо буцаан татах тухай асуудал байхгүйбөгөөд байцаан шийтгэх ажиллагаа ердийн журмаар явагдана.

3. Процессийн ажиллагааны баримт бичигт тавигддаг шаардлага агуулга, хэлбэрийн хувьд хийгдэхгүй байна. Жишээ нь: Эрүүгийн хэрэг үүсгэх тогтоолын үндэслэлийг тодорхойлон бичихдээ ЭБШ хуулийн зүйл заалтын дагуу хууль зүйн фактыг тодорхойлдоггүй, ттогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн чухам ямар зүйл, заалтаар эрүүгийн хэрэг үүсгэсэн тухай бүрэн гүйцэд бичдэггүй нийтлэг дутагдал байна.

4. Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох тухай зарчмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй хэрэгт эрэн сурвалжлах бодит ажиллагаа зохиохгүй, зөвхөн эрэн сурвалжлах албан бичиг олноор үйлдэх дутагдал оршсоор байна.

Тухайлбал, Зуслангийнхаа ойролцоо модонд салхилж явсан настай эмэгтэйг үл таних хүн хүчиндсэн хэрэг дээр яллагдагчаар татагдвал зохих этгээдийг тогтоогоогүй, гэмт этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа хангалттай, шуурхай явуулалгүйгээр хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар хэрэгсэхгүй болгосон байна. /Эрүүгийн 20941083 тоот хэрэг/

5. Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны чанар муудсан бас нэг шалтгааныг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн боловсон хүчнийг бэлтгэх байгууллага тус тусдаа бие даасантай холбоотойгоор тэдний уялдаа холбоо, хамтын ажиллагаанд доголдол гарсны илрэл гэж үзэж байна.

Иймээс хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд амжилт олох нь дамжиггүй.

6. Хэргийн хохирогчид согтуу буюу өөрийгээ хянах, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан гэмт хэргийг үйлдсэн байхад харилцан зөвшилцсөн гэж үзэж

хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа буруу практик байна.

Ялангуяа хүүхэд хохирсон хэргийг мөрдөн шалгахдаа “Хохирогч, насанд хүрээгүйн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдол” хэмээн үзэж ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүхэд шилжүүлж, шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэх тухай журмыг баримтлах нь зүйтэй.

7. Хүчиндэх гэмт хэргийг эвлэрлийн гэрээ байгуулсан нэрээр /эвлэрсэн гэсэн үндэслэлээр/ хууль бусаар хэрэгсэхгүй болгож байна. Жишээ нь: Эрүүгийн 201525011364 дугаартай хэрэг/

8. Хувь хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаанаас хүмүүжлийн доголдол, хэрцгий догшин авир, бэлгийн эмх замбараагүй амьдрал, хүчээр түрэмгийлэх хандлага зэргийг дурьдаж болохоор байна.

9. Энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй нөхцөл, хүчин зүйлсийн хувьд гудамж талбай, хорооллын гэрэлтүүлэг, камерийн хяналт муу, хувийн такси үйлчилгээ, өсвөр насны хүүхдэд эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нарын зүгээс тавих хяналт сул байгаа байдлуудыг дурьдаж болно.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь гэмт явдлын энгийн нэгэн хэлбэр бус нийгмийн хямралын илрэн гарах нэг хэлбэр болох сөрөг үзэгдэл бөгөөд нийгмийн бусад үзэгдлүүдтэй нягт холбоотойгоор үйлдэгдэг төдийгүй манай улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид ч үйлдэгдэх төлөвтэй байна.

ИЙМД ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ АРГА ХЭМЖЭЭГ ШУУРХАЙ АВАХ ШААРДЛАГАТАЙ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ
БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ 2015 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ БОЛОН
2002 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ (ХАРЬЦУУЛАЛТ)**

12	2015 оны Эрүүгийн хуулийн арван хоёрдугаар бүлэг Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2002 оны Эрүүгийн хуулийн арван долдугаар бүлэг Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	Харьцуулсан тайлбар Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэсэн 2 бүлэгт хуваасан.
12.1	<p>12.1 дүгээр зүйл.Хүчиндэх</p> <p>1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;</p> <p>2.2.бүлэглэж;</p> <p>2.3.гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;</p> <p>2.4.хохирогчийг жирэмсэн болгож;</p> <p>2.5.хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;</p> <p>2.6.хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;</p> <p>2.7.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</p> <p>2.8.харгис хэрцгий аргаар;</p> <p>2.9.бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж;</p> <p>/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>2.10.хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл</p>	<p>126 дугаар зүйл.Хүчиндэх</p> <p>126.1.Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>126.2.Энэ хэргийг:</p> <p>126.2.1.хохирогчийг тохуурхан даажигнаж, зовоон тарчлааж;</p> <p>126.2.2.хүндэвтэр буюу хүнд гэмтэл учруулж;</p> <p>126.2.3.давтан;</p> <p>126.2.4.насанд хүрээгүй хүнийг;</p> <p>126.2.5.албан тушаал, эд хөрөнгийн болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнийг;</p> <p>126.2.6.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>-Уг зүйлд “хохирогчийн хүсэл зоригийн эсрэг” гэж субъектив талын шинжийг шинээр зааж өгсөн.</p> <p>-Хүчиндэх гэмт хэрэг үйлдэх аргыг “<i>хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах</i>” гэж диспозицид дэлгэрэнгүй заасан. Ингэснээр практик энэ төрлийг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.</p> <p>-Бэлгийн харьцаанд орсон; бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон. Ингэснээр зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог олон улсын жишигт нийцүүлсэн.</p> <p>-Энэ гэмт хэргийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; хохирогчийг жирэмсэн болгож; хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж; хоёр, түүнээс дээш хүнийг хүчиндэж; урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; харгис хэрцгий аргаар үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Зөвхөн энэ гэмт хэрэгт: урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдвэл хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Хоёр, түүнээс дээш хүнийг хүчиндсэн бол хүндрүүлэхээр заасан. Одоохоёр ба түүнээс олон</p>

<p>хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийн улмаас <i>ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн</i> бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>4.Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p><i>Тайлбар:-Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.</i></p> <p><i>-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</i></p> <p><i>-“Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.</i></p>	<p>126.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан, эсхүл бага насны, өөрөөр хэлбэл арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.</p>	<p>хүнийг хүчиндэж, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд нь халдсан тохиолдолд нэг хүн хүчиндсэн хүнтэй адил ял шийтгэдэг болсон..</p> <p>-Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан; арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол онц хүндрүүлэхээр заасан.Энэ нь өсвөр насны хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг онцгойлон эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан алхам болсон.</p> <p>-Хуулийн тайлбар хэсэгт:</p> <p>-“Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.” гэж заасан нь хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>-“Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэж заасан нь практикт бага насны хүүхдийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах арга хэрэглэсэн байхыг шаарддаг буруу хандлагыг өөрчилсөн.</p> <p>-“бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж заасан нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан үйлдэл (хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар бэлэг эрхтнийг хөхүүлэх, хохирогчийн ам, суга, цавь, шулуун гэдсэнд дур тавих г.м)-ийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулж, гэмт этгээдэд ял завшуулж байсан буруу тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцсэн алхам болсон.</p> <p>-Үндсэн бүрэлдэхүүнд оногдуулах хорих ялын дээд доод хэмжээг хэвээр үлдээсэн,</p>
--	--	--

			хүндрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулах хорих ялын хэмжээг 5-10 жил байсныг 2-8 жил болгон ялын дээд болон доод хэмжээг бууруулсан, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хорих ялын дээд болон доод хэмжээг хэвээр хадгалсан, цаазын ялыг халсан.
12.2	<p>12.2 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах</p> <p>1.Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>125 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах</p> <p>125.1.Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>125.2.Энэ хэргийг давтан, бүлэглэж үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, эсхүл насанд хүрээгүй, бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>-Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах үйлдлийг шинэчилэн найруулсанЭрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн диспозицид заасан.</p> <p>-Харин бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив талыг хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэж шинээр томъёолсон.</p> <p>Гэмт хэргийн объектив талын нэмэгдэл шинж болох цаг хугацааг зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэрэг болно.</p> <p>-Энэ хэргийг давтан, бүлэглэж үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, эсхүл насанд хүрээгүй, бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүндрүүлэхээр заасныг хассан.</p> <p>-2-5 жилийн хорих ялтай байсныг 6 сараас 2 хүртэл жилийн хорих ялтай болгож хөнгөрүүлсэн.</p>
12.3	<p>12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг</p> <p>1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан</p>		<p>-Энэ гэмт хэргийг үйлдэх аргыг диспозицид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах гэж заасан.</p> <p>-Мөн гэмт хэргийн объектив талыг зорчих эрхийг хязгаарлахгүйгээр гэж тодотгож өгсөн. Ингэснээр энэ гэмт хэргийг</p>

<p><i>оруулсан</i> бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p><i>2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</i></p> <p><i>2.1.арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;</i></p> <p><i>2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</i></p> <p><i>2.3.хохилогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;</i></p> <p><i>2.4.хохилогчийг жирэмсэн болгож;</i></p> <p><i>2.5.хоёр, түүнээс дээш хүний эсрэг;</i></p> <p><i>2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</i></p> <p><i>3.Энэ гэмт хэргийн улмаас</i></p> <p><i>3.1.ураг зулбасан;</i></p> <p><i>3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</i></p> <p><i>4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</i></p> <p><i>4.1.бага насны хүүхдийг албадан оруулж;</i></p> <p><i>4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</i></p> <p>Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>		<p>хууль бусаар хорих, хүн худалдаалах болон бусад төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх гол шинж болсон.</p> <p>-Хүнийг зорчих эрхийг хязгаарлалгүйгээр биеийг нь үнэлүүлж, ашиг олсон этгээдийн үйлдлийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр зүйлчилнэ. Энэ нь Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолын 4.4-д “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай, боолчлогдох шинжтэй бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн тухайд биеэ үнэлж байгаа этгээд гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна” гэж заасан агуулгатай нийцсэн.</p> <p>-Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор үйлдэхдээ арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүүхдийг албадан оруулсан, урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан, хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлсэн; хохирогчийг жирэмсэн болгосон; хоёр, түүнээс дээш хүний эсрэг үйлдсэн; байнга тогтвортой үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан; арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол онц хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор бага насны хүүхдийг албадан оруулсан; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол мөн онц хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Хуулийн тайлбар хэсэгт бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй байхаар заасан. Энэ нь практикт түгээмэл тулгардаг хүүхэд өөрөө сайн дураараа биеэ үнэлэхээр ирсэн, ашиг орлогыг тодорхой хувийг авдаг байсан гэх асуудлыг шийдвэрлэхэд эергээр нөлөөлнө.</p>
--	--	---

12.5	<p>12.5 дугаар зүйл.Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох</p> <p><i>1.Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан; мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол дөрвөн зуун нэгжээс дөрвөн мянга зургаан зуун далан нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</i></p> <p><i>2.Энэ гэмт хэргийн улмаас</i></p> <p><i>2.1.хохилогчийг жирэмсэн болгосон;</i></p> <p><i>2.2.бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</i></p>	<p>122 дугаар зүйл.Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх</p> <p>122.1.Хохирогчийг арван зургаан насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>-Энэ гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх хүний насыг 18 байхаар зааж, халдлагад өртөгч (хохилогч)-ийг 14-16 настай болохыг мэдэх боломжтой, мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Ингэснээр практикт энэ хэргийн зүйлчлэлийн талаар үүсдэг маргааныг шийдвэрлэхэд дөхөм болсон.</p> <p>-14 хүртэлх насны буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн шинжид хуульчилсан. Ингэж энэ гэмт хэргийн хохирогчийн насыг тодорхой зааж өгсөн нь ач холбогдолтой.</p> <p>-Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийг жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол хүндрүүлэхээр заасан.</p> <p>-Үндсэн бүрэлдэхүүний хувьд зорчих эрхийг хязгаарлах ялын төрлийг нэмсэн, хорих ялын доод, дээд хэмжээ багассан.</p> <p>-Ялын хувьд 12.2 – 36 сая төгрөгөөр торгох ялыг 400 000 – 4.6 сая төгрөг болгон бууруулсан, 251-300 цаг хүртэл албадан ажил хийлгэх ялыг хассан, 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмсэн, 3 жил хүртэл хугацаагаар хорих ялыг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял болгож бууруулсан.</p> <p>Хүндрүүлэх бүрэлдэхүүнийг шинээр нэмсэн бөгөөд энэ хэсгийн шийтгэлийг 2002 оны Эрүүгийн хуулийн үндсэн бүрэлдэхүүний ялтай ижил хэмжээнд тусгасан.</p>
	<p>Зөрчлийн тухай хууль /2017 он/</p> <p>6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих</p> <p>7.Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>124 дүгээр зүйл.Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах</p> <p>124.1.Бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл</p>	<p>Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг Эрүүгийн хуулиас хасч зөрчилд тооцсон.</p> <p>Эрүүгийн хуулийн 12.3-д заасан арга хэрэглээгүй, сайн дураараа биеэ үнэлж байгаа 14-өөс дээш насны хүнийг өөрийн байр, газарт биеийг үнэлүүлсэн, зуучилсан бол зөрчил үйлдсэн гэж үзэж шийтгэл оногдуулахаар заасан.</p> <p>Харин бага насны хүүхдийн биеийг үнэлүүлсэн бол бэлгийн</p>

		<p>хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>124.2.Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>124.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>мөлжлөгийн гэмт хэрэг болно. Учир нь Эрүүгийн хуулийн 12.3-ийн хууль тогтоогчийн тайлбарт хуульд заасан хүч хэрэглэсэн байхыг шаардахгүй гэжээ.</p> <p>Биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах үйлдэлд хүлээлгэх ялын бодлогыг эрс хөнгөрүүлж, зөрчилд торгох шийтгэл оногдуулахаар хуульчилсан.</p>
--	--	--	--

Дэд дүгнэлт

- Хүчиндэх гэмт хэрэг **үйлдэх аргыг** “*хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах*” гэж диспозицид дэлгэрэнгүй зааж, **“хохилогчийн хүсэл зоригийн эсрэг”** гэж субъектив талын шинжийг шинээр зааж өгсөн нь практикт энэ төрлийг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.

Зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог болсон, хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болохоор тусгасан зэрэг нь олон улсын жишигт нийцсэн.

Мөн **“бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл”** гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж заасан нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан үйлдэл (хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар бэлэг эрхтнийг хөхүүлэх, хохирогчийн ам, суга,

цавь, шулуун гэдсэнд дур тавих г.м)-ийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулж, гэмт этгээдэд ял завшуулж байсан буруу тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцсэн алхам болсон.

- **“Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй”** гэж заасан нь практикт бага насны хүүхдийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах арга хэрэглэсэн байхыг шаарддаг буруу хандлагыг өөрчилсөн.

Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан; арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол онц хүндрүүлэхээр заасан нь өсвөр насны хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг онцгойлон эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан алхам болсон.

- **Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив талыг хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ** хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэж шинээр томъёолохдоо объектив талын нэмэгдэл шинж болох цаг хугацааг зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэрэг болохоор заагласан байна.

- **Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох** гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх хүний насыг 18 байхаар зааж, халдлагад өртөгч (хохирогч)-ийг 14-16 настай болохыг мэдэх боломжтой, мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь практикт энэ хэргийн зүйлчлэлийн талаар үүсдэг маргааныг шийдвэрлэхэд дөхөм болсон. 14 хүртэлх насны буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн шинжид хуульчилсан. Ингэж энэ гэмт хэргийн хохирогчийн насыг тодорхой зааж өгсөн нь нэг мөр ойлголт өгсөн ач холбогдолтой болсон байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛС ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Гадаадын зарим улс орнуудын бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эрүүгийн хуульд хэрхэн тусгасан судалгааг Америк, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн хийв.

АНУ-ЫН ТЕХАС МУЖИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Хэсэг 9. Нийгмийн дэг журам ба ёс суртахууны эсрэг гэмт халдлага

Бүлэг 43. Олон нийтэд зохимжгүй зан үйл

Дэд бүлэг А. Бие үнэлэх

Зүйл 43.02. Бие үнэлэх

(а) Этгээд санаатайгаар дараах үйлдлийг хийсэн бол гэмт халдлага үйлдсэн гэж үзнэ:

(1) шан хөлстэйгээр бэлгийн зан үйл санал болгох буюу хийхийг зөвшөөрсөн буюу хийсэн бол; буюу

(2) Олон нийтийн газар байхдаа хөлстэйгээр бэлгийн зан үйл хийхийн тулд өөрийгөө санал болгосон.

(b) (a) (1) заасан гэмт халдлага нь үйлдэгчээс шан харамж өгсөн буюу авсан эсэхээс үл хамааран үйлдэгдсэнд тооцогдоно. (a) (2), хэсэгт заасан гэмт халдлага нь хөлсөөр өөрийгөө санал болгосон буюу хөлслөх тухай саналыг хүлээн авсан эсэхээс үл хамааран үйлдэгдсэнд тооцогдоно.

(c) Энэхүү зүйлд заасан гэмт халдлага нь В ангилалын мисдиминор мөн; хэрэв үйлдэгч нь урд өмнө энэхүү зүйлд заасан гэмт халдлага үйлдэж нэг буюу хоёр удаа шийтгүүлсэн бол энэ нь А зэрэглэлийн мисдиминор болно. Хэрэв үйлдэгч нь урд өмнө энэхүү зүйлд заасан гэмт халдлага үйлдэж гурав буюу түүнээс дээш удаа шийтгүүлсэн бол муж улсын шоронд хорих ял шийтгэх фелони болно.

Зүйл 43.03. Бие үнэлэхэд хамтран оролцох

(а) Этгээд бие үнэлэх үйлчилгээг биечлэн үзүүлсний төлөө шан хөлс авч буй биеэ үнэлэгчийн хувьд тийм үйлдэл хийгээгүй боловч дараах үйлдлийг санаатай үйлдсэн бол гэмт халдлага хийсэнд тооцно:

(1) Бие үнэлэхээс олж байгаа, орлогынх нь хэсэгт оролцох тухай хэлцлийн дагуу мөнгө болон бусад эд зүйл авсан; буюу

(2) Бусдад бусад этгээдтэй бэлгийн зан үйлд шан хөлстэйгээр оролцохыг санал болгосон.

(b) Энэхүү зүйлд заасан гэмт халдлага нь А зэрэглэлийн мисдиминор мөн.

Зүйл 43.04. Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бие үнэлэхэд хамтран оролцох

(а) Хоёр буюу түүнээс илүү бие үнэлэгчийг ашиглан бие үнэлэх үйлчилгээний байгууллагыг санаатайгаар эзэмшсэн, хөрөнгө оруулсан, санхүүжүүлсэн, хяналт тавих буюу удирдсан бол гэмт халдлага үйлдсэн гэж үзнэ.

(b) Энэхүү зүйлд заасан гэмт халдлага нь гуравдугаар зэргийн филоми мөн.

Зүйл 43.05. Бие үнэлэхэд албадах

(а) Этгээд дараах үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол гэмт халдлага гэж үзнэ:

(1) Бусдыг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хууран мэхлэх замаар бие үнэлэхээр албадсан бол; буюу

(2) Ямар ч замаар 17 наснаас залуу этгээдийг бие үнэлэхээр албадсан бол.

(b) Энэхүү зүйлд заасан гэмт халдлага нь хоёрдугаар зэргийн фелони мөн¹².

Товч дүгнэхэд трэфик болон түүнтэй холбоотой үйлдлийг гэмт хэрэгт тооцсон америкийн хууль тогтоомж нь ерөнхийдөө хамгийн дэвшилттэй хэмээн тооцогдож байгаа юм. Энэ хууль тогтоомж нь олон улсын эрх зүй, түүний дотор Хүн худалдаалахын эсрэг 2000 оны НҮБ-ын протоколд бусад улс орнуудын үндэсний хууль тогтоомжоос ч илүүтэйгээр нийцэж байгаа нь бодит нөхцөл байдалд тохируулан хууль зүйн конструкцийг цаг үетэйгээ тохируулан ашигласныг гэрчилж байна. Энд хүчирхийллийн хохирогчийг хамгаалахад чиглэсэн 1998 оны хуульд үндэслэн гарсан Protection Act-ын уламжлал, залгамж шинж энд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэж болно.

Хүний наймаанд зориулагдсан америкийн эрх зүйн зохих үндэслэлд дүн шинжилгээ хийж, үр дүнтэй ашиглах нь монгол улсын хууль тогтоогчид эрүүгийн эрх зүйн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээг загварчлах, АНУ-ын гаргаж засаж залруулж байсан алдааг давтахгүй байх цаашдаа Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санааг хэрэгжүүлэх, эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгоход цаг хугацаа хэмнэх боломж олгоно.

¹² Уголовный кодекс штата Техас. ред. И.Д. Козочкин. “Юрид.центр Пресс”, 2006.

ДАНИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Бүлэг 24: Бэлгэсийн гэмт хэрэг

§223а.

18 нас хүрээгүй этгээдтэй үйлчлүүлэгчийн хувьд бэлгийн харьцаанд орсон ямар ч этгээд болон биеэ үнэлэх замаар амьдралын эх үүсвэрээ бүрэн буюу хэсэгчлэн хангаж байгаа этгээдийг торгох буюу энгийнээр баривчлах буюу хоёр жилээс хэтрүүлэхгүйгээр ямар ч хугацаагаар хорих ял шийтгэнэ.

§228.

(1) Аливаа этгээд:

1) бусдыг зүй бусаар бусад этгээдтэй бэлгийн харилцаанд орж орлого олоход уруу татсан буюу

2) ашиг олох зорилгоор бусад этгээдийг гуравдагч этгээдтэй зүй бусаар бэлгийн харьцаанд оруулахаар шилжүүлсэн буюу өөр этгээдтэй бэлгийн зүй бус (ёс суртахуунгүй) харьцаанд орсон этгээдийг энэ үйл ажиллагаагаа орхих боломж олгоогүй буюу

3) бордель (бие үнэлэх байр) ажиллуулсан (агуулсан);

Бие үнэлэхэд уруу татсан гэм буруутай этгээдийг дөрвөн жилээс дээшгүй альч хугацаагаар гянданд хорино.

(2) Мөн 21 нас хүрээгүй этгээдэд бэлгийн зүй бус харьцааг мэргэжлийн үйл ажиллагааны хувьд эрхлэхэд уруу татсан буюу тусалсан буюу 21 нас хүрээгүй буюу энэ талаар мэдээгүй байсан этгээдийг хилийн цаана бэлгийн ёс бус харьцааг мэргэжлийн үйл ажиллагааны хувьд эрхлүүлэх зорилгоор эх орноо орхихыг ятгасан этгээдэд ял шийтгэнэ.

§229.

(1) Ашиг олох зорилгоор буюу зуучлагчаар бэлгийн ёс бус харьцаанд байнга давтан оролцсон буюу мэргэжлийн үйл ажиллагааны хувьд бэлгийн ёс бус харьцаанд ордог ямар ч этгээдийн үйл ажиллагаанаас орлого олдог аливаа этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар хорих буюу хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол энгийнээр хорих буюу торгрх ял шийтгэнэ.

(2) Мэргэжлийн үйл ажиллагааны хувьд бие үнэлэхийг эрхлэх зорилгоор зочид буудал буюу дэн буудалд өрөө гаргаж өгсөн этгээдэд энгийнээр хорих (баривчлах) буюу нэг жил хэтрүүлэхгүйгээр хорих буюу хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол торгох ял шийтгэнэ.

ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Арван гуравдахь хэсэг. Бэлгийн хувьд хараат бус байх (өөрийгөө тодорхойлох)-ын эсрэг гэмт хэрэг

§180а. Бие үнэлэхэд хамтран оролцох

(1) Хэн нэгэн аж ахуйн нэгж хэлбэрээр байгууллага бий болгох буюу түүний үйл ажиллагааг удирдаж, түүнд дараах байдлаар бие үнэлэх ажиллагаа явуулсан бол:

1. эрхшээлдээ байгаа этгээдийн хувийн болон эд хөрөнгийн хараат байдлыг ашигласан буюу

2. өрөө байр буюу оршин суух болон хүрэлцэн ирэх өөр бусад байр гаргаж өгөх, эдгээртэй үүнтэй холбоотой нэмэгдэл үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авах байдлаар бие үнэлэх ажиллагаанд хамтран оролцсон бол гурван жил хүртэл хорих буюу мөнгөн торгуулиар шийтгэнэ.

(2) Мөн хэн нэгэн:

1. Арван найман насанд хүрээгүй этгээдэд бие үнэлэх зориулалтаар байр, амьдрах орон сууцыг үйлчилгээний хэлбэрээр гаргах өгөх буюу оршин суух газар үйлчилгээний хэлбэрээр гаргаж өгсөн, буюу

2. Бие үнэлэхийн тулд байр гаргаж өгсөн этгээдбусдыг бие үнэлэхийг албадах буюу үүнтэй хобоотойгоор мөлжсөн бол мөн адил шийтгэнэ.

§180б. Хүн худалдаалах

(1) Хэн нэгэн ашиг олох зорилгоор түүний аргагүй байдлыг мэдсээр байж энэ этгээдийг бие үнэлэхэд буюу түүнийгээ үргэлжлүүлэхэд уруу татахаар нөлөөлсөн бол таван жил хүртэл хорих буюу мөнгөн торгууль оногдуулна. Мөн хэн нэгэн ашиг олох зорилгоор энэ этгээдийг харь оронд оршин суухтай холбоотойгоор түүний тусламж авах боломжгүй байдлыг мэдсээр байж гуравдагч этгээдтэй бэлгийн харьцаанд оруулахаар орхих буюу энэхүү үйлдлийг гуравдагч этгээд үйлдэх боломж олгохын тулд түүнийг албадсан бол мөн адил шийтгэнэ.

(2) Зургаан сараас арван жил хүртэл хорих ялыг дараах үйлдэл хийсэн этгээдийг шийтгэнэ:

1. Энэхүү этгээдийг харь оронд ирсэнтэй нь холбогдуулан түүний тусламж авах боломжгүй байдлын тухай мэдсээр байж;

2. хорин нэгэн нас хүрээгүй этгээдийг бие үнэлэхэд буюу түүнийг үргэлжлүүлэхэд уруу татсан буюу энэхүү этгээдийг биеэ эхэлж буюу цаашид үргэлжлүүлэн үнэлэх байдалд хүргэхийн тулд нөлөөлсөн;

(3) 2 заасан хэсэгт тохиолдолд завдсан бол шийтгэнэ.

§ 181a. Сутенер (Бэлгийн мөлжлөг)

(1) зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ялыг дараах үйлдэл хийсэн этгээдийг шийтгэнэ:

1. шунахайн зорилгоор бусад этгээдийг бие үнэлэхэд ашигласан буюу

2. бусад этгээдийн бие үнэлэхээс эд хөрөнгийн ашиг олсон, бие үнэлэх орон байр, цаг хугацаа, үргэлжлэх байдал болон бусад нөхцөл байдлыг тогтоох буюу бусад этгээдээс бие үнэлэх ажиллагааг үргэлжлүүлэх арга хэмжээ авсан буюу зөвхөн тэднийг ганц тохиолдлыг гэрчлэх байдлаар бусад этгээдтэй харилцах харилцааг дэмжсэн.

(3) өөрийн эхнэр/ нөхрийн хувьд 1, № 1 и 2 заасан үйлдэл хийсэн буюу 2 хэсэгт зааснаар нөлөөлсөн бол 1 и 2 хэсгээр тогтоосон хэм хэмжээгээр шийтгэнэ.

§184a. Бие үнэлэх хориглосон ажиллагаа эрхлэх

Хэн нэгэн тодорхой орон зай буюу хоногийн тодорхой хугацаанд бие үнэлэхийг хориглосон эрх зүйн заалтыг ноцтой зөрчсөн бол зургаан сар хүртэл хорих буюу нэг зуун наян хоног хүртэл өдрийн цалингийн хэмжээгээр торгох ял шийтгэнэ.

§184b. Залуучуудын ёс суртахуунд аюул учруулсан бие үнэлэх ажиллагаа эрхлэх

Хэн нэгэн нь бие үнэлэхдээ:

1. сургуулийн ойлголцоо буюу арван найман нас хүрээгүй этгээд ороход зориулагдсан бусад газар;

2. арван найман нас хүрээгүй этгээд амьдардаг газар бие үнэлж залуучуудын ёс суртахуунд шэм хор учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөн торгууль оногдуулах ял шийтгэнэ.

§184c. ойлголтын тодорхойлолт

Энэхүү хуулийн агуулгаар:

1. Бэлгийн үйлдэл гэж зөвхөн эрх зүйн хамгаалагдаж байгаа үнэт зүйлсийн ач холбогдол бүхий тэр үйлдэл гэж ойлгоно;

2. бусад этгээдийн харилцаан дахь бэлгийн үйлдэл гэж зөвхөн өнгөрсөн явдлыг сэргээн санах чадвартай этгээдийн хувьд үйлдэгдсэн тийм үйлдэл гэж ойлгоно.

ИСПАНИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Хэсэг VIII. Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг

Бүлэг VI. Бие үнэлэхтэй холбоотой гэмт хэрэг

Зүйл 187.

1. Хэн нэгэн арван найман насанд хүрээгүй буюу мэдрэлийн хямралаар өвдөж байгаа этгээдийг бие үнэлэхэд албадсан, ятгасан буюу хамтарсан бол нэг жилээс

дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах ба арван хоёроос хорин дөрвөн сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр торгох ял шийтгэнэ.

2. Түүнээс гадна эрхийг нь зургаагаас арван хоёр жил туйлаар хязгаарлах (поражение) төрлийн ялыг өөрийн нийгмийн болон албаны байдлаа ашиглан дээр дурдсан үйлдэл хийсэн этгээдэд оногдуулна.

Зүйл 188.

1. Хэн нэгэн хүч, хэрэгцээний (мөнгө эд зүйлс болон бусад хэрэгцээт зүйлийн дутагдал) байдал буюу өөрийн байдлаа ашиглан арван наймаас дээш насны этгээдийг бие үнэлэхэд хүргэсэн буюу энэ байдалд түүний хүсэл зоргиос гадуур байлгасан бол хоёроос дөрвөн жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах ба арван хоёроос хорин дөрвөн сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр торгоно.

2. Түүнээс гадна эрхийг нь зургаагаас арван хоёр жил туйлаар хязгаарлах (поражение) төрлийн ялыг өөрийн нийгмийн болон албаны байдлаа ашиглан өмнөх хэсэгт тодорхойлсон үйлдэл хийсэн этгээдэд оногдуулна.

3. Хэрэв энэхүү үйлдэл нь арван найман насанд хүрээгүй буюу сэтгэц мэдрэлийн өвчтэй этгээдийн хувьд үйлдсэн бол түүний дээд хэмжээнд ойр ял шийтгэнэ.

Зүйл 189.

1. Хэн нэгэн арван найман насанд хүрээгүй этгээдийг эзсгибиционист буюу порнографийн үзүүлбэрт ашигласан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хасах ял шийтгэнэ.

2. Өөрийн асрамж, хамгаалалт болон нөлөөнд (покровительство) байгаа, арван найман насанд хүрээгүй буюучадамжгүй гэж тооцогдсон этгээд нь бие үнэлэдэг тухай мэдсэн боловч энэхүү тохироог зогсоохын төлөө боломжтой зүйл хийгээгүй буюу түүнийг хамгаалах арга хэрэгсэл дутагдсан бол засагт хандаагүй этгээдийг гурваас арван сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр торгох ял шийтгэнэ.

3. Прокурорын байгууллага өмнөх хэсэгт заасан үйлдэл хийсэн этгээдийн эцэг эх байх, асрах, хамгаалах буюу гэр бүлийн хүрээнд байлгах эрхийг хасах тухай санал гаргана¹³.

¹³ Уголовный кодекс Испании. Москва. Зерцало., 1998.

САНМАРИНО УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Бүлэг III. Нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг

Санаатай гэмт хэрэг

Зүйл 268. Бие үнэлэхийн тулд амьд бараа худалдаалах

Хилийн цаана бие үнэлэх ажиллагаа¹⁴ эрхлэхийн тулд бусдыг ашиглах зорилгоор амьд бараа худалдсан аливаа этгээдэд гянданд хорих хэлбэрээр ба сонгуулийн ба улс төрийн эрх хасах хэлбэрээр ба дөрөвдүгээр зэргээр тодорхой мэргэжил эрхлэхийг хориглох хэлбэрээр ял оногдуулна.

Хэрэв гэмт хэрэгтэн дараах байдлаар үйлдсэн бол гянданд хорихыг нэг зэргээр нэмэгдүүлнэ:

1) хилийн цаана, янз бүрийн улс орнуудад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудтай зөвшилцөн үйлдсэн;

2) хүч хэрэглэх, заналхийлэх буюу хуурч мэхлэх зэргийг ашиглан, эсхүл хүнийг хүч хэрэглэн хулгайлан үйлдсэн.

Зүйл 269. Бие үнэлэх ажиллагаа эрхлэхийг ятгах

Бусад этгээдийг бие үнэлэх ажиллагаанд ятгаж итгүүлсэн аливаа этгээдэд гянданд хорих, улс төрийн эрх, сонгуулийн эрх хасах хэлбэрээр ба гуравдугаар зэргээр мэргэжил хориглох хэлбэрээр ял оногдуулна. Хэрэв энэ үйлдэл дараах байдлаар үйлдэгдсэн бол гянданд хорих ял нэг зэргээр нэмэгдэнэ:

1) хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх буюу хууран мэхлэн;

2) арван найман насанд хүрээгүй этгээдэд, эсхүл өвчтэй буюу сэтгэл мэдрэлийн хямралд байгаа этгээдэд гэм хор учруулан;

3) дээшээ, доошоо ба шулуун шугамын төрөл төрөгсөд, үрчлүүлсэн, үрчлэн авсан, эхнэр нөхөр, ах, эгч нарт хор хохирол учруулан.

Зүйл 270. Бие үнэлэх явдалд зориулж байр ажиллуулах

Бие үнэлэх явдал эрхлэх байр эзэмшиж байгаа буюу энэхүү зорилгоор үл хөдлөх хөрөнгө гаргаж өгсөн аливаа этгээдэд гянданд хорих, улс төрийн эрх, сонгуулийн эрх хасах хэлбэрээр ба мэргэжил хориглох хэлбэрээр ял оногдуулна.

Бие үнэлэх явдал эрхлэх байр удирдсан, хамтын үйл ажиллагаа явуулсан, эсхүл энэ салбарт үйлчилгээ үзүүлсэн этгээдэд хоёрдугаар зэргээр гянданд хорих ял шийтгэнэ.

Зүйл 271. Бие үнэлэгчийг мөлжих

¹⁴ Янхлах//

Бусад этгээдийг бие үнэлүүлж удаа дараа мөлжсөн аливаа этгээдэд хоёрдугаар зэргээр гянданд хорих, гуравдугаар зэргээр улс төрийн эрх, сонгуулийн эрх хасах ба мэргэжил хориглох хэлбэрээр ял оногдуулна.

Хэрэв гэмт хэрэгтэн бие үнэлэхэд хамтран оролцсон бол гуравдугаар зэргээр гянданд хорих ял шийтгэнэ.

Зүйл 272. Бие үнэлэхэд хамтран оролцох

Бусад этгээдийн бэлгийн дур хүслийг хангах зорилгоор бие үнэлэхэд ямар нэгэн байдлаар хамтран оролцсон буюу дэмжлэг үзүүлсэн этгээдэд нэгдүгээр зэргээр гянданд хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн зөрчил

Зүйл 278. Сутенер¹⁵, шаардаж бие үнэлэх үйлдэл:

Хэрэв аливаа этгээд нь дараах үйлдэл хийсэн бол хоёрдугаар зэргээр баривчлах хэлбэрээр буюу гуравдугаар зэргээр нэмэгдүүлсэн торгууль оногдуулах хэлбэрээр ял оногдуулна:

1) Олон нийтийн газар, олон нийтэд ил газар буюу хүмүүс олноор цугларсан өөр газар шаардах замаар (санал тавих, бэлэг өгөх эсхүл зан үйлээрээ буюу өдөөн хоргоосон дохиогоор) бусад этгээдийг бэлгийн ажил хийхийг санал болгосон;

2) Олон нийтийн харилцааны хэрэгслийг ашиглан бие үнэлэх байдлаарөөрийн үйлчилгээг, эсхүл бусад этгээдийн үйлчилгээг санал болгох буюу бие үнэлэгч этгээдтэй холбоо тогтоохыг санал болгосон бол;

3) Өөртөө үйлчлүүлэгч олох эсхүл түүнтэй учрахын тулд олон нийтийн газар, эсхүл олон нийтэд ил газар өөрийгөө харуулж сурталчилсан бол;

4) Өөрийн орон сууцанд бие үнэлж хамт амьдарч байгаа хүмүүстэйгээ, эсхүл хөрштэйгээ хэрүүл маргаан дэгдээсэн.

Зүйл 279. Олон нийтийн газар бие үнэлэх ердийн зөрчил (хүлцэл)

Орон сууц, тавилга бүхий байр, дотуур байр, дарсны мухлаг, бүжгийн байр клуб, олон нийтэд харагдахуйц байр эсхүл олон нийтэд нээлттэй бусад тасалгаа эзэмшиж байгаа аливаа этгээд нь эдгээр байр болон түүний туслах байранд нэг буюу хэд хэдэн бие үнэлэгчийг ердийн байдлаар орогнуулсан бол нэгдүгээр зэргээр худалдаа хийх эрхийг хориглох буюу төрийн болон бусад зохих зөвшөөрлийг хүчингүй болгох ял шийтгэнэ¹⁶.

¹⁵ Сутенёр (souteneur - фр) – бие үнэлэгчийг мөлжиж амьдрах

¹⁶ Уголовный Кодекс Республики Сан-Марино. "Юридический центр Пресс", 2003.

ФРАНЦ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Хэсэг II. Хувь хүний эсрэг гэмт халдлагын тухай

БүлэгV. – Хүний нэр төрийн эсрэг гэмт халдлагын тухай

Дэд хэсэг II. – Зуучлах болон түүнтэй төстэй гэмт үйлдлийн тухай

Зүйл. 225-5. – Зуучлах гэж аливаа этгээдээс дараах аль нэг хэлбэрээр үйлдсэн гэмт үйлдийг хэлнэ:

дэд зүйл. 1. Бусад этгээд бие үнэлэхэд тусалсан, хамтарсан буюу урамшуулсан;

дэд зүйл.2. бусад этгээд бие үнэлснээс ашиг олсон, энэхүү үйл ажиллагаанаас олсон орлогыг хувиарлахад оролцсон буюу бие байнга үнэлсэн этгээдээс төлбөр авсан;

дэд зүйл.3. Бие үнэлэхэд татан лолцуулсан, бие үнэлэхийн тулд хөлсөлсөн буюу уруу татсан, эсхүл бие үнэлэхийг буюу цаашид үүнийг үргэлжлүүлэхийг албадах зорилгоор дарамт шахалт үзүүлсэн.

Зуучлахад таван жил гянданд хорих ба 1000000 франкийн хэмжээгээр торгох ял шийтгэнэ.

Зүйл. 225-6. – 225-5 зүйлд заасан шийтгэлийг аливаа этгээдийн зуучлахтай төстэй дараах хэлбэрээр илэрхийлэгдсэн үйлдэлд шийтгэнэ:

дэд зүйл.1. Аль нэг нь бие үнэлдэг, нөгөө нь бусад этгээдийн биеэ үнэлэхийг ашгладаг буюу төлбөр төлдөг хоёр этгээдийн хооронд зуучилсан бол;

дэд бүлэг.2. Бие үнэлэгчийг мөлжигчийн орлогын хуурмаг (фиктив) эх үүсвэрийг ил хууль ёсны болгохыг хөнгөвчилсэн;

дэд бүлэг.3. Хэрэв энэхүү этгээд нь биеэ байнга үнэлдэг этгээдтэй хамт амьдардаг буюу бие үнэлэдэг нэг буюу хэд хэдэн этгээдтэй байнга харилцаатай боловч, амьдралын энэ хэв маягтай холбоотойгоор өөрөөр орлогын эх сурвалж бий болгох чадваргүй бол;

дэд хэсэг.4. Бие үнэлж байгаа буюу бие үнэлэх заналхийлэлд байгаа этгээдийн хувьд урьдчилан сэргийлэх, хяналт тавих, туслах буюу дахин хүмүүжүүлэх талаар эрх бүхий байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагаанд саад хийсэн.

Зүйл. 225-7. – Зуучлах гэмт хэргийг дараах байдлаар үйлдсэн бол арван жил гянданд хорих ба 10 000 000 хэмжээний франкаар торгох ял шийтгэнэ:

дэд зүйл.1. насанд хүрээгүй хүүхдийг;

дэд хэсэг.2. нас, өвчин, бэртэл, бие махбодийн буюу сэтгэцийн бэрхшээл, эсхүл жирэмсэн зэрэг нь онцгой эмзэг байдлыг нь гүйцэтгэгч этгээд мэдэж байсан буюу түүнд энэ байдал нь илэрхий мэдэгдэж байсан этгээдийг;

дэд зүйл.3. Хэд хэдэн этгээдийг;

дэд зүйл.4. БНУ-ын гадна, эсхүл БНУ-ын нутаг дэвсгэр дээр ирсэнтэй нь холбоотойгоор биеийг үнэлэхийг албадсан этгээдэд;

дэд зүйл.5. Бие үнэлэгч этгээдийн босоо шугамын хууль ёсны, жам ёсны буюу үрчлэн авсан төрөл төрөгсөд буюу тэдний хууль ёсны засгийн эрх мэдэл бүхий этгээд, буюу түүнд олгосон эрх хэмжээтэйгээр холбоотойгоор олгосон засгийн эрхээ урвуулан ашигласан этгээдэд;

дэд хэсэг.6. Бие үнэлэхтэй тэмцэх, эрүүл мэнд хамгаалах буюу нийгмийн хэв журам сахиулахаар өөрт олгогдсон эрх хэмжээтэй холбоотойгоор оролцсон этгээдэд;

дэд зүйл.7. Зэвсэглэсэн этгээдэд;

дэд зүйл.8. Албадах, хүч хэрэглэх үйлдэл ашигласан буюу хууран мэхэлсэн;

дэд зүйл.9. Зохион байгуулалттай бүлэг байгуулаагүй боловч гүйцэтгэгч буюу хамтран оролцогчийн хувьд үйл ажиллагаа явуулсан хэд хэдэн этгээдэд;

дэд зүйл.10. Тодорхой бус этгээдүүдэд зориулж мэдээлэл дамжуулах зорилгоор харилцаа холбооны сүлжээг ашиглан үйлдсэн.

Зүйл. 225-8. – 225-7 зүйлд заасан зуучлалыг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол хорин жил эрүүгийн журмаар хорих ялаар шийтгэх ба 20 000 000 франкийн хэмжээний торгох ял шийтгэнэ.

Зүйл. 225-9. – Зодох буюу харгис хэрцгий үйлдэж зуучилсан бол бүх насаар нь эрүүгийн журмаар хорих буюу 30 000 000 франкийн хэмжээний ял торгох шийтгэнэ.

Зүйл. 225-10. – Аливаа этгээдээс зуучлагчийн шууд буюу түүгээр дамжуулан дараах байдлаар үйлдсэн үйлдэлд арван жил хорих буюу 5 000 000 франкийн хэмжээний торгох ял шийтгэнэ:

дэд зүйл.1. Бие үнэлэхэд зориулалт бүхий байгууллага агуулсан, удирдсан, ашигласан, чиг үүргийг хангасан, санхүүжүүлсэн буюу санхүүжүүлэхэд оролцсон;

дэд зүйл.2. Бие үнэлэхэд зориулалт бүхий байгууллага агуулсан, удирдсан, ашигласан, чиг үүргийг хангасан, санхүүжүүлсэн буюу санхүүжүүлсэн этгээдийн удаа дараагийн зөвшөөрлөөр буюу өөгшүүлэлтээр олон нийтэд болон түүний ашиглагчид нээлттэйгээр тухайн байгууллага байгууллага буюу түүний зарим хэсгийг нэг буюу хэд хэдэн этгээд биеэ үнэлэх буюу үйлчлүүлэгчээ татахад ашиглуулсан бол;

дэд зүйл.3. Хэдийгээр байр буюу тасалгааг бие үнэлэхэд зориулж ашиглахыг мэдэж басйан боловч нийтээр ашиглахгүй байр буюу тасалгааг нэг буюу хэд хэдэн этгээдэд өгсөн буюу дамжуулан өгсөн бол.

Дэд хэсэг III. – Хүний нэр төрд үл тохирох хөдөлмөрлөх ба амьдрах нөхцлийн тухай

Зүйл. 225-13. – Эмзэг байдал буюу албан тушаалын хараат байдлыг нь урвуулан ашиглах замаар үнэгүй үйлчилгээ буюу тухайн ажлын үнэлэмжтэй илт үл тохирох хөлсөөр үйлчилгээ авсан бол хоёр жил хүртэл хугацаагаар гянданд хорих буюу 5 00 000 франкийн хэмжээний торгох ял шийтгэнэ.

Зүйл. 225-14. – Эмзэг байдал буюу албан тушаалын хараат байдлыг нь урвуулан ашиглах замаар хүний нэр төрд үл тохирох ажлын буюу амьдрах нөхцөлд байлгасан бол хоёр жил хүртэл хугацаагаар гянданд хорих буюу 5 00 000 франкийн хэмжээний торгох ял шийтгэнэ.

Зүйл. 225-15. – 225-13 ба 225-14 зүйлүүдэд заасан гэмт үйлдлийг хэд хэдэн этгээдийн хувьд үйлдсэн бол таван жилийн хугацаагаар гянданд хорих буюу 10 00 000 франкийн хэмжээний торгох ял шийтгэнэ¹⁷.

ЭСТОНИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Арван нэгдүгээр бүлэг. Нийгмийн аюулгүй байдал ба нийгмийн дэг журмын эсрэг гэмт хэрэг

Зүйл 202. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт үйл ажиллагаа буюу бие үнэлэхэд татан оролцуулах

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт үйл ажиллагаа буюу бие үнэлэхэд татан оролцуулах, мөн адил насанд хүрээгүй хүүхдийг бие үнэлэхэд ашигласан бол хоёроос таван жил хорих ял шийтгэнэ.

Зүйл 202.6. Бие үнэлэх ажиллагаа эрхлэхэд уруу татах буюу бие үнэлэхэд зуучлах

(1) Этгээдийг бие үнэлэх ажиллагаанд уруу татсан буюу бие үнэлэхэд зуучилсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(2) 18 наснаас 21 насны этгээдийг бие үнэлэхэд уруу татсан буюу тэднийг биеэ үнэлэхэд зуучилсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(3) бие үнэлэхэд уруу татсан буюу тэднийг биеэ үнэлэхэд зуучилсан нь:

1) хүч буюу бусад албадлага хэрэглэсэн буюу

2) насанд хүрээгүй хүний хувьд буюу

3) хоёр ба түүнээс дээш хүнийг хувьд буюу

4) энэхүү үйлдэл хийсний улмаас урьд өмнө шийтгэгдэж басйан этгээд үйлдсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

¹⁷ Уголовный кодекс Франции. Под ред. Л.В. Головки, Н.Е. Крылова. М., 2002.

БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Бүлэг XVI. Ёс суртахуун болон бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт үйлдэл

Зүйл 163. Бие үнэлэхийг хязгаарласан журам зөрчих

Бие үнэлэхийг хязгаарласан журмыг нэг жилийн хугацаанд давтан зөрчсөн бол их баривчлах буюу албадан ажил хийлгэх буюу сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн хүртэл торгох ял шийтгэнэ.

Зүйл 164. Бие үнэлэхийг албадах

(1) Бие үнэлэхийг албадасан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу баривчлах, буюу сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жар дахин нэмэгдүүлсэн хүртэл мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(2) Аливаа этгээдийг итгэл эвдэх буюу хууран мэхлэх замаар буюу гэм буруутай этгээдээс хараат байдал буюу түүний тусламж авах боломжгүй байдлыг ашиглаж бие үнэлэхэд татан оролцуулсан бол таван жилийн хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу сарын хөдөлмөрийн доод хэмжээг зуун хорь дахин нэмэгдүүлсэн хүртэл мөнгөөр торгох ял шийтгэнэ.

Зүйл 165. Бэлгийн мөлжлөг (Сутенерство)

(1) биеэ үнэлсэн этгээдийг баяжих зорилгоор ашигласан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр дөрвөн жил хүртэл хорих (эрх чөлөөг хязгаарлах) ял шийтгэнэ.

(2) энэхүү үйлдлийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд буюу насанд хүрээгүй хүүхдийн хувьд үйлсэн бол эд хөрөнгө хурааж долоон жил хүртэл хорих ял шийтгэнэ¹⁸.

ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Тавдугаар хэсэг: Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

3. Бэлгийн үйлдэл ашиглах

Зүйл 195. Бие үнэлэх ажиллагаанд хамтран оролцох

Насанд хүрээгүй этгээдийг бие үнэлэхэд уруу татсан,

этгээдийн хараат байдал буюу эд хөрөнгийн ашиг хонжоо харж бусдыг бие үнэлэхэд татан оролцуулсан,

бие үнэлэх ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн чөлөөт үйлдлийг ашиглаж, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж, бие үнэлэх ажиллагаа эрхлэх орон байр, цаг хугацаа, цар хүрээ буюу бусад нөхцөл байдлыг тодорхойлон түүний ашиг сонирхлыг зөрчсөн,

¹⁸ Уголовный кодекс Латвийской Республики. ред., Лукашов А.И., Саркисова Э.А. СПб.:Юридический центр-пресс., 2001

этгээдээс бие үргэлжлүүлэн үнэлэхийг шахаж шаардсан этгээдийг цөллөгийн шоронд арван жил хорих буюу гянданд хорих ялаар шийтгэнэ.

Зүйл 196. Хүн худалдаалах

Хэн нэгэн бусад хүний садар самуун үйлдэлд хамжих, дэмжихийн тулд хүн худалдаалсан бол зургаан сараас багагүй хугацаагаар цөллөгийн шорон буюу гянданд хорих ял шийтгэнэ.

Хэн нэгэн хүн худалдаалах байгууллага байгуулсан бол таван жил хүртэл цөллөгийн шоронд хорих буюу гянданд хорих ял шийтгэнэ.

Аль ч тохиолдолд мөн торгох ял оногдуулж болно.

5. Бэлгийн халдашгүй байдлыг зөрчих

Зүйл 199. Зөвшөөрөлгүйгээр бие үнэлэх ажиллагаа эрхлэх

Хэн нэгэн бие үнэлэх орон зай, цаг хугацаа буюу төрлийн тухай болон бие үнэлэх ажиллагааг дагалдсан үйлдлийг урьдчилан сэргийлэх тухай кантоны (хуулийн) заалтыг зөрчсөн бол баривчлах буюу торгох ял шийтгэнэ¹⁹.

ШВЕДУЛС

Бие үнэлэх явдалтай эрс шийдэмгий тэмцэж байгаа улс гэж ихэвчлэн Швед орныг тооцдог. 1999 онд скандианавын энэ оронд “Эмэгтэйчүүдийн эрх чөлөөний тухай” (Kvinnofridsstadstifritngen) гэсэн багц хууль батлагдан гарчээ. Тэр үед 48 хувь нь эмэгтэйчүүдээс бүрдсэн парламент бэлгийн шинж чанартай гэмт хэргүүд, түүний дотор сексийн үйлчилгээ авах оролдлого хийсэн бол гэмт хэрэгт тооцож, 6 сар хүртэл хорих ял ногдуулахаар болсон байна. Харин бие үнэлэх зорилгоор “мөлжигдсэн эмэгтэйчүүд”-ийг эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхаар тогтоосон байна.

Хууль санаачлагчдын логигоор(учир зүйгээр) бол бие үнэлэх нь эмэгтэйчүүдэд хандсан эрчүүдийн хүчирхийллийн нэг төрөл гэж үзжээ. Мөн эрчүүд л эмэгтэйчүүдийг эд бараа мэт үзэж, жам ёсны эрхийг нь зөрчөөгүй бол бие үнэлэх үзэгдэл байхгүй байсан гэж үзэж байна. “Эрчүүдийн дунд эмэгтэйчүүд, охидын эрэлт хэрэгцээ их байгаа нь бие үнэлэх, хүн худалдаалах урьдчилсан нөхцөл” гэж үзжээ. Энэхүү хууль батлагдсанаар Швед улсад бие үнэлэх явдал 25 хувь цөөрсөн боловч үүнийг дагаад бас сөрөг үзэгдэл ажиглагдах болжээ. Бие үнэлэлт нь гудамжаас “далд”, тэр ч бүү хэл интернетэд шилжсэн гэж зарим судлаачид үзэж байна. Мөн швед бүсгүйчүүдийг Орос, Дорнод Европ болон Балти орчмын улсуудад ажиллуулах нэрээр худалдах явдал эрс

¹⁹ Уголовный кодекс Швейцарии. Перевод с немецкого / Науч. ред.: Серебрянникова А.В. (Пер., предисл.) - С.-Пб.: Юрид. центр Пресс, 2002.

нэмэгдсэн байна. Жишээ нь дээрхи улс орнуудад 400-500 эмэгтэй жил бүр хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж байна гэсэн баримт бий.

1998 онд Швед улс эмэгтэй хүний хувийн бүрэн бүтэн байдлыг ноцтойгоор зөрчих” гэсэн шинэ төрлийн гэмт хэргийг тодорхойлсон “Эмэгтэйчүүдэд хүч хэрэглэхтэй тэмцэх тухай” хууль баталжээ. Биеийг нь үнэлүүлэхийг эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн нэг хэлбэр гэж үзсэн байна. 1999 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс “бэлгийн үйлчилгээ авах”-ийг хориглож, торгох буюу 6 сар хүртэл хугацаагаар хорих шийтгэл оногдуулахаар болжээ. Шведийн засгийн газар энэхүү арга хэмжээ нь биеийг нь үнэлүүлэхийг “нийгмийн гаж үзэгдэл”, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж үзэж байгаагийн илэрхийлэл болно гэдэгт итгэлтэй байна. Эмэгтэйчүүдийн хувь хүний бүрэн бүтэн байдалд халдах гэмт хэргийг шинээр бий болгож, бэлгийн үйлчилгээ авахыг хориглосон нь эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хэрэгжүүлэхэд саад болж байгаа хүчирхийллийн хэлбэрүүдийг устгахад чиглэж байгаа юм. Шведийн хандлага нь бэлгийн мөлжлөгийн нөхцөлд эмэгтэйчүүдэд учирсан гэм хорыг хүлээн зөвшөөрч байгаа юм. Энэ хандлага нь эмэгтэйчүүд өөрийн нэр төр, тэгш эрх, бүрэн бүтэн байдалд байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс эхтэй юм. Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн энэхүү хууль нь эрэгтэйчүүдийг гэм буруутайд тооцсоноор, биеийг нь үнэлүүлэх буюу биеэ үнэлж байгаа эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээг хязгаарлахад чиглэж байгаа юм. Норвегт улс эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа мэдээ байна.

Швед Улсын Эрүүгийн хууль

Хоёрдугаар хэсэг. Гэмт хэргийн тухай

Бүлэг 6. Бэлгэсийн гэмт хэргийн тухай

Зүйл 3

Бусдын (эр ба эм хүний) хараат байдлыг хүндээр урвуулан ашиглах замаар бэлгийн харьцаанд орохыг уруу татсан этгээдэд бэлгийн мөлжлөгийн төлөө хоёр жилээс илүүгүй хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ. Энэхүү үндэслэлийг тусламж авах боломжгүй буюу түүнтэй адилтгах чадамжгүй байдалд байгаа буюу сэтгэцийн хямралтай байдлыг ашиглан бусад этгээдтэй бэлгийн харьцаанд орсон этгээдэд хэрэглэнэ.

Хэрэв яллагдагч онцгой харгис хэрцгий байдал үзүүлсэн буюу хэрэв гэмт хэрэг өөр шалтгаанаар хүнд байвал тэр бэлгийн хүнд мөлжлөгийн төлөө зургаан сараас багагүй, зургаан жилээс илүүгүй хугацаагаар шоронд хорих ял шийтгэнэ.

Зүйл 4

Түүний үр удам болох буюу түүний хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн буюу засгийн байгууллагын шийдвэрээр түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих хариуцлага хүлээсэн этгээд (эр ба эм) арван найман насанд хүрээгүй хэн нэгэнтэй бэлгийн харьцаанд орсон бол насанд хүрээгүй хүнийг бэлгээр мөлжсөний төлөө дөрвөн жил илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэхүү үндэслэлийг Энэхүү бүлгэгт урд тэмдэглэсэн бусад нөхцөл байдал бүхий болон арван таван нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон этгээдэд мөн хэрэглэнэ.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд насанд хүрээгүй этгээдийг харж хандах үүргээ онцгой умартсан буюу хэрэв гэмт хэрэг нь насанд хүрээгүй этгээдийн бага балчир настай холбоотой буюу өөр шалтгаанаар хүнд бол насанд хүрээгүй хүнийг хүндрүүлэх нөхцөлтэйгээр бэлгээр мөлжсөний төлөө хоёр жилээс багагүй, найман жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зүйл 8

Бусдыг төлбөртэйгээр байнгын бус байдлаар бэлгийн харьцаанд орохыг дэмжих буюу хууль бусаар санхүүгийн хувьд мөлжиж байсан этгээдийг зуучласны төлөө дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Байр эзэмших эрхтэй болон бусдад түүнийгээ амиглуулах эрх бүхий этгээд нь тухайн байр бүтнээрээ буюу түүний нэг хэсэг нь төлбөртэйгээр бэлгийн байнгын бус харьцаанд ашиглагдаж байгааг мэдсээр байж, мөн шилжүүлсэн эрхийг зогсоох талаар шаардлагатай ухаалаг үйлдэл хийгээгүй бол хэрэв энэхүү үйлдэл нь тухайн байранд цаашид үргэлжилсэн буюу сэргээгдсэн бол энэхүү үйл ажиллагааг дэмжсэн гэж үзэж нэгдүгээр заалтын нэгэн адил шийтгэнэ.

Зүйл 9

Хэрэв зүйл 8 заасан гэмт хэрэг нь хүнд бол хүнд нөхцөл байдалтайгаар зуучилсан гэж үзэж хоёроос багагүй зургаагаас илүүлгүй жилийн хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

Гэмт хэрэг хүнд эсэхийг тодорхойлох явцад яллагдагч бэлгийн түр харьцааг төлбөртэйгээр хийхийг урамшуулсан буюу бусдыг хайр найргүй мөлжсөн зэргийг тусгайлан тогтоох нь зүйтэй²⁰.

Мөн Шведийн хөгжлийн талаарх Олон улсын хамтын ажиллагааны (SIDC) хүн худалдаалахтай тэмцэх стратегийн хүрээнд энэ улсын ГЯЯ-наас хүн худалдаалахтай тэмцэх 10 чиглэлийг тодорхойлсон байна.

²⁰ Уголовный кодекс Швеции / Науч. ред.: Беляев С.С., Кузнецова Н.Ф. - С.-Пб.: Изд-во "Юрид. центр Пресс", Изд-во Моск. гос. ун-та, 2001.

Хүн худалдаалахтай тэмцэх арван чиглэл

1. Хүн худалдаалах асуудлыг өргөн утгаар нь ядуурал, бэлгийн эрх тэгш бус байдал гэж өргөн утгаар нь ойлгох хэрэгтэй. Хүн худалдаалахтай тэмцэх арга хэмжээнүүд нь өнөөгийн ядууралтай тэмцэх хөтөлбөр болон Төв болон Дорнод Европын улс орнуудад хөгжил, аюулгүй байдлыг бэхжүүлэх, ардчилал, эдийн засаг, нийгэмийн хангамжийн хөтөлбөрүүдэд үндэслэгдэх ёстой.

2. Хүн худалдаалахын хохирогч болох аюул заналаас хамгаалуулах хүн нэг бүрийн эрхийг онцгойлон тэмдэглэж, хүүхэд, эмэгтэйчүүд найдвартай хамгаалалтад байх ёстой.

3. Хүн худалдаалахын бүх төрлийн хэлбэртэй тэмцэх салбарт хамгийн гол анхаарал, ажлаа төвлөрүүлэх ёстой. Өнөө үед хамгийн гол тулгарч байгаа асуудал бол хүн худалдаалах дараах хэлбэрүүд, тухайлбал: хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор худалдах хэлбэр болж байна. Дээрхи хэлбэрүүдээс албадан хөдөлмөрлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих зэрэг үзэгдэл нийгэмд ноцтой аюул занал учруулж байна.

4. Хүн худалдаалахын эсрэг урт хугацааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамгийн чухлаар тавигдах ёстой, түүнчлэн хүн худалдаалахын хохирогчдыг нөхөн сэргээх нөхцлийг сайжруулах, тэднийг хэвийн амьдралд нь эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг идэвхтэй боловсруулах шаардлагатай.

5. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд:

- Залуучуудыг, ялангуяа охид бүсгүйчүүдийг ажлаар хангах хөтөлбөр хөгжүүлэх;
- Энэ салбар дахь хөдөлмөрийн нөхцөл, эрх зүйн тулгуур суурийг сайжруулах;
- Охид бүсгүйчүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрийн хөгжил;
- Хүйсийн тэгш эрхийн ухуулга суртал нэвтрүүлэг;
- Залуучуудын бэлгийн талаарх эрүүл ахуйн суртал нэвтрүүлэг;
- Засгийн байгууллагуудаас хүүхэд залуучуудын санал хүсэлтийг харгалзах, тооцох;
- Нийгмийн баримжаатай байгууллагын сүлжээг, ялангуяа ядуурал хямралын үед байгуулж, хөгжлийг нь дэмжих;
- Хүүхэд эмэгтэйчүүдийг бие үнэлэх болон бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт татан оролцуулахтай болон уруу татахтай тэмцэх;
- Үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй нийцүүлэх, ижилтгэхэд дэмжлэг үзүүлэх;

- Олон улсын гэрээ хэлцлийн нөхцлийн биелэлтэд хараат бус мониторинг, хараат бус илтгэлээр дамжуулан хяналт тавих.

6. Хүн худалдаалахын үр дагаварыг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнд:

- Хүмүүсээс хүн худалдаалсан тухай тохиолдлыг мэдээлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Хүн худалдаалахын хохиргчтой зохих ёсоор харьцах, тэднийг гутаан доромжилж, ялгаварлан харьцахгүй байх; хүн худалдаалахын хохирогчид цаг алдахгүйгээр үзүүлэх хууль зүйн, эмнэлэгийн, нийгмийн болон эдийн засгийн тусламжид хяналт тавих;
- Нийгмийн халамжийн байгууллага, бүтэц, институцийн урт хугацааны хөгжлийн дэмжлэг;
- Хууль хамгаалах болон хүний эрхийг хамгаалах бусад байгууллагын ажилтнуудад хүндэтгэн харьцах түвшинг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн ур чадварыг дэмжих;
- НКО-гийн нийгмийн үйлчилгээний хөгжлийг дэмжих, тэдний хамтын ажиллагаа болон төрийн байгууллагатай хоршин ажиллахыг дэмжих;
- Гадаадын улс орнуудыг хүн худалдаалахын эсрэг олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэлд нэгдэн орох хэрэгцээ шаардлагад итгүүлэх;
- Асуудлын талаар , ялангуяа хүн амд төдийлөн хүртээмжтэй биш, эсхүл маргаантай байгаа тухайн асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэх түвшинг нэмэгдүүлэхэд туслах.

7. Асуудал, түүний мөн чанар, шалтгаан, үр дагаварыг гүнзгий ойлгох түвшинд хүрэхийн тулд тухайн асуудлын талаар болон түүний шинжилгээний талаар мэдээлэл тараахад туслах; Туршлага солилцох болон хэтийн төлөвлөгөө, хөтөлбөр, төслүүдийн үр нөлөө, үр дүнг байнга үнэлж байх;

8. Хүн худалдаалахын эсрэг салбар дундын хөтөлбөрийг оролцуулан, мөн нэгэн зэрэг ядууралтай тэмцэх хөтөлбөрийн хүрээн дэх хоёр талын арга хэмжээг авахын хамт олон талт хамтын ажиллагаанд онцгой ач холбогдол өгөх; НКО болон тэдний нэгдлүүдийн хамтын ажиллагаа, харилцан туслалцаа онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

9. Олон улсын болон бүс нутгийн түвшинд олон улсын хэм хэмжээ болон улс төрийн шийдлийг амьдралд шууд хэрэгжүүлж байгаа субъектуудын хоорондын уялдаа холбоог хөгжүүлэх;

10. Хүн худалдаалахтай бүх нийтээр тэмцэхэд эрх зүйн асуудал, хүйсийн тэгш эрх, нийгмийн хангамж ба шилжилт хөдөлгөөн зэрэг Шведийн бодлогын бусад

салбартай уялдуулан зохицуулах ач холбогдол, гүйцэтгэх үүргийг үнэлэх; Улс төрийн бодлогын янз бүрийн салбарыг төгөлдөржүүлэх арга замыг тэдний түгээмэл ашиг сонирхлыг тодорхойлох, тэдний уялдаа холбоог дэмжих, тэдний хамтын ажиллагааны боломжийг боловсруулах замаар эрж хайх. ГЯЯ-ны ажлын бүх түвшинд хүн худалдаалахын эсрэг нэгдэх. Энэ салбарт санаачлага гаргах, үр дүнг тооцох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий салбар нэгжийг байгуулах” гэжээ.

Эцэст нь тэмдэглэхэд биеэ үнэлэх, биеийг нь үнэлүүлэхийн хувьд эрх зүйн бүхий л боломжийн тогтолцоо, практик бий. Зарим улс орнуудад хориг (биеэ үнэлэхийг хориглож, үйлчлүүлэгчийг шийтгэх), нөгөө хэсэгт нь ил болгох буюу зохицуулах (насанд хүрсэн хүнийг биеэ үнэлэх, үнэлүүлсэний төлөө ял шийтгэхгүй байх) буюу аболиционизмын тогтолцоог (биеэ үнэлэх нь гэмт хэрэг биш боловч, түүнийг ашиглах нь зөрчил мөн) ашиглаж байна. Энэ эрс ялгаа нь олон улсын түвшинд ихээхэн маргаан дэгдээж байгаа бөгөөд янз бүрийн байр суурь бүхий улс орнууд өөр өөр үзэл санаа баримталж, зөвшилцөлд хүрэхэд хүнд байгаа юм. Дээр дурдсан зөвлөмжүүд нь хохирогчийг хамгаалах тухай асуудлыг анхаарлын төвд дэвшүүлэн тавьж урьдчилан сэргийлэх болон туслах шинжтэй арга хэмжээнүүд илүү чухал гэж тайлбарлаж байгаа боловч зохих хууль тогтоомжгүй, түүний хэрэглээ болон хууль зүйн хамтын ажиллагаагүйгээр хүн худалдаалахтай тэмцэх асуудал үр нөлөө байхгүй. Энэ асуудал дээр Европын Зөвлөлийн оролцогч-улс орнуудын хууль тогтоомжийн ялгаа хэвээр байгаа боловч энэхүү үзэгдэл нь Европ тивээс халин гарч байгаа нь мэдээжийн хэрэг юм.

Тодорхой чиглэл зорилготой хэтийн төлөв бүхий урт удаан хугацааны үйлчлэл нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх арга хэрэгслийн хувьд өвчлөөгүй байгаа хүнийг урьдчилан сэргийлэх эм, вакцин мэт хэрэгтэй, өөрөөр хэлбэл энэхүү үзэгдийн шалтгааныг бүр эхнээс нь илрүүлж, урьдчилан сэргийлэх хэрэгтэй байгаа юм. Ийм учраас “Хүнийг бэлгээр ашиглах зорилгоор хүн худалдаалах тухай” R(2000) зөвлөмжийн хүрээнд урт удаан хугацааны үйлчлэл нь хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн хувьд эрх тэгш биш байдалтай холоотой учраас хүн худалдаалахын шалтгаан нөхцлийн эсрэг ялангуяа эмэгтэйчүүдийн нийгмийн байдал, түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах замаар тэмцэхийг зөвлөж байгаа юм²¹.

²¹ Sokvk skatot Eiropas Padomes Ministru komitejas “Ministru Komitejas Rekomendācija dalībvalstīm R(2000)11 Par cilvēku tirdzniecības seksuālās izmantošanas nolūkā.” (IV daļa 23—25.punkts), ko Ministru komiteja pieņēmusi 2000.gada 19.maijā ministru vietnieku sanāksmē

СОЛОНГОС УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Солонгос улсын эрүүгийн хуулийн “Бэлгийн ёс суртахуунд хамаарах гэмт хэрэг” гэсэн XXII бүлэгт нийгмийн ёс суртахууныг зөрчсөн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг заажээ.

Зүйл 241 (Завхайрах)

(1) Гэрлэсэн этгээд шалигласан (завхайрсан) бол хоёр жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийх ял шийтгэнэ. Энэхүү шийтгэлийг шалигласан бусад этгээдэд мөн хэрэглэнэ.

(2) Өмнөх зүйлд заасан гэмт хэргийг хохирогч-ханийн зүгээс гомдол гаргасан тохиолдолд шүүхийн журмаар хэлэлцэнэ. Хэрэв хохирогч-хань шалигласан явдлыг өршөөсөн бол цаашид яллахаас татгалзана.

Зүйл 242 (Бие үнэлэхэд уруу татах)

Орлого олох зорилгоор насанд хүрээгүй охид буюу ёс суртахуулаг эмэгтэйчүүдийг бэлгийн харьцаанд оруулсан этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийлгэх буюу арван таван сая воноос илүүгүй хэмжээгээр торгох ял шийтгэнэ (1995 оны арван хоёрдугаар сарын 29-ний өдрийн № 5057 хуулиар нэмсэн).

Бүлэг XXXI. Хүн хулгайлахтай холбоотой гэмт хэрэг

Зүйл 287 (Насанд хүрээгүй хүүхэд хулгайлах)

Насанд хүрээгүй этгээдийг зүй бус зорилгоор хүчээр буюу хууран мэхэлж хулгайлсан бол арваас илүүгүй жил цөллөгийн ажил хийх ял шийтгэнэ.

Зүйл 288 (Хүн хулгайлах ба орлого олох зорилгоор худалдах)

(1) Бусад хүнийг ёс зүйгүй буюу бэлгийн үйлдэйн буюу орлого олох зорилгоор хүчээр буюу хууран мэхэлж хулгайлсан бол нэг жилээс багагүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(2) Өмнөх зүйлийг бие үнэлүүлэхээр эмэгтэйчүүдийг худалдах буюу худалдан авахад мөн хэрэглэнэ.

(3) Өмнөх хоёр зүйлд заасан гэмт үйлдлийг байнга үйлдсэн этгээдэд хоёроос илүүгүй жил цөллөгийн ажил хийх ял шийтгэнэ.

Зүйл 289 (Хүн хулгайлах ба түүнийг гадаад улсад худалдахын тулд тээвэрлэх)

(1) Бусдыг Солонгос улсын зөөвөрлөхийн тулд хүчээр буюу хууран мэхэлж хулгайлсан буюу худалдсан буюу өөр этгээдэд худалдсан этгээдийг гурван жилээс багагүй хугацаагаар цөллөгийн ажил хийх ялаар шийтгэнэ.

(2) Өмнөх зүйлийг хулгайлагдсан буюу худалдагдсан хүнийг Солонгос улсаас тээвэрлэсэн этгээдэд хэрэглэнэ.

(3) Өмнөх хоёр зүйлд заасан гэмт хэргийг байнга үйлдсэн бол таван жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зүйл 290 (Бэлтгэх, үгсэн тохирох)

Өмнөх зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор бэлтгэсэн буюу үгсэн тохиролцсон этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийлгэх ял шийтгэнэ.

Зүйл 291 (Гэрлэх зорилгоор хүн хулгайлах)

Гэрлэх зорилгоор хүчээр буюу хууран мэхэлж бусдыг хулгайлсан бол таван жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийх ялаар шийтгэнэ.

Зүйл 292(Хулгайлагдсан хүнийг нуух буюу нууцлах)

(1) 288 буюу 289 зүйлд зааснаар хулгайлагдсан, худалдагдсан буюу худалдан авагдсан этгээдийг нуусан буюу нууцалсан бол долоон жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийх ял шийтгэнэ.

(2) 287 буюу 292 зүйлд зааснаар хулгайлагдсан хүнийг нуусан буюу нууцалсан этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар цөллөгийн ажил хийх ял шийтгэнэ.

Зүйл 293 (Байнга үйлдэх)

(1) дээрхи зүйлд заасан үйлдлийг байнга үйлдсэн бол хоёроос арван жил хүртэл хугацаагаар цөллөгийн ажил хийлгэх ял шийтгэнэ.

(2) Өмнөх зүйлийг мөн өмнөх зүйлд заасан үйлдлийг зүй бус буюу бэлгийн үйлдэлд буюу орлого олох зорилгоор үйлдсэн этгээдэд хэрэглэнэ.

Зүйл 294 (Завдах)

287-289 ба 291-293 зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээр завдсан бол шийтгэлтэй.

Зүйл 295-2 (Ял хөнгөлөх)

Хэрэв энэхүү бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хулгайлагдсан, уруу татагдсан, худалдаалагдсан буюу зөөвөрлөгдсөн хүнийг чөлөөлсөн, аюулгүй газар байрлуулсан бол ялыг нь хөнгөлж болно²².

Солонгос улсад 2000 оны зургадугаар сарын 1-ний өдрөөс тодорхой төрлийн гэмт хэргийн гэрчийг хамгаалах тухай хуулийг баталж хэрэгжүүлж эхэлжээ. Үүнд: зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бусаар мансууруулах бодис худалдаалах, зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалахад чиглэсэн байна.Энэ хууль нь гэрчийг хамгаалах америкийн хөтөлбөрийн нэгэн адил мөрдөн мөшгөх, шүүн таслах ажлын явцад нууцлалыг бүрэн хадгалах, гэрч хохирогч нарын унааны зардал болон өөр ажилд шилжихэд шаардагдах хөрөнгө, мөн хувийн болон эд хөрөнгийн аюулгүй

²² Уголовный кодекс республики Корея.С изменениями и дополнениями на 1 октября 2003 г. Под.ред. А. И. Коробеева. Санкт-Петербург., 2003. С 103-104.

байдлыг хангах бусад арга хэмжээг тусгажээ²³. Энэхүү хуулийг хэрэгжүүлж, хамгийн их саад болж байсан гэрч хохирогч нарын тухай мэдээллийг нууцласнаар зохион байгуулалттай гэмт явдлыг мөрдөн байцааж нотлох ажиллагаанд ахиц дэвшил гарсан байна.

ИЗРАИЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Бүлэг “йюд”: Бие үнэлэх ба порнографи

Зүйл 199. Сутенер (бэлгийн мөлжлөг)

(алеф). Гянданд таван жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ:

(1). биеэ үнэлж байгаа этгээдийн орлогоор бүрэн буюу хэсэглчлэн, байнга буюу ямар нэгэн тодорхой цаг хугацаанд амьдарч байгаа этгээдэд;

(2). Аливаа этгээдийн бэлгийн харьцаагаар олсон (бий болгосон) зүйлээс бүрэн буюу хэсэгчилсэн төлбөрийг зориуд санаатайгаар авсан этгээдэд;

(бет). Энэхүү зүйлд заасан гэмт хэргийг өөрийн эхнэр, нөхөр, хүүхэд, үрчилж авсан хүүхэд, мөн түүнтэй нэгэн адил хэн нэгнийг тухайн этгээдийн эрхшээлд болон хараат байдалд байгаа, эсхүл асран хамгаалагч буюу харгалзан дэмжих байдалд байгааг ашиглан үйлдсэн этгээдэд долоон жил хорих ял шийтгэнэ.

(гимел). Энэхүү зүйлийг хэрэглэхэд ямар нэгэн ач холбогдолгүй:

(1). гэмт хэрэгтэн мөнгө, мөнгөтэй тэнцэх эд зүйл, үйлчилгээ буюу бусад ашиг авч байсан эсэх;

(2). бие үнэлж байсан этгээдээс шууд буюу өөр этгээдээс төлбөр авч байсан эсэх;

(3). гэмт хэрэгтэн төлбөр буюу өөр шан харамж авч байсан эсэх.

Зүйл 200. Бэлгийн мөлжлөгийн (сутенер) презумпци

Хэрэв эр хүн бие үнэлэгчтэй хамтран амьдарч байсан эсхүл түүнийг байнга дагадаг (хамт дагалддаг) байсан, мөн түүнтэй адил түүнийг хянадаг эсхүл түүнтэй хамтрах буюу бие үнэлэхэд хүргэхийн тулд өөрийн нөлөө үзүүлж байсан бол тухайн эрэгтэй нь түүнийгээ эсрэгээр нотолж чадахгүй бол түүнийг бие үнэлэх орлогоор амьдарч байсан гэсэн презумпци үйлчилнэ.

Зүйл 201. Бэлгийн төлбөртэй харьцаанд татан оруулах

Хэн нэгнийг бусадтай бэлгийн төлбөртэй харьцаанд татан оруулсан этгээдийг таван жил хорих ялаар шийтгэнэ.

Зүйл 202. Биеэ үнэлэхэд татан оролцуулах

²³ Хайонам Мун. Современная ситуация по организованной преступности в корее//www.crime.vl.ru

Хэн нэгнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан этгээдийг долоон жил хорих ялаар шийтгэнэ.

Зүйл 203. Хүндрүүлэх нөхцөл байдал

(алеф). 201 буюу 202 зүйлд заасан гэмт хэргийг эрхшээлдээ эсхүл хараат байгаа, эсхүл харгалзан дэмжих буюу хяналтад нь байгааг ашиглан, мөн нэгэн адил санхүүгийн хүндрэл эсхүл сэтгэцийн асуудалтай байгааг ашиглан бэлгийн төлбөртэй харьцаанд оруулах, эсхүл бие үнэлэхэд татан оролцуулсан бол арван жилийн хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

(бет). 201 буюу 202 зүйлд заасан гэмт хэргийг дараах нөхцөл байдалд үйлдсэн бол:

(1). Хүч хэрэглэсэн, эсхүл бусад төрлийн дарамт үзүүлсэн, нэгэн адил тэднийг хэрэглэхээр заналхийлсэн нь бэлгийн төлбөртэй харьцаа, эсхүл бие үнэлэхэд татагдан оролцсон этгээдийн, эсхүл бусад этгээдийн хувьд хэрэглэсэн нь ямар нэгэн ач холбогдолгүй;

(2). бэлгийн төлбөртэй харьцаанд, эсхүл бие үнэлэхэд татагдан оролцсон этгээдийн эсэргүүцэлд саад болсон тохироог ашиглан, нэгэн адил уг этгээд сэтгэл мэдрэлийн өвчтэй байсан, эсхүл оюуны хомсдолыг ашиглан;

(3). бэлгийн төлбөртэй харьцаанд, эсхүл бие үнэлэхэд татагдан оролцсон этгээдийг хуурч мэхлэх замаар зөвшөөрүүлсэн бол арван зургаан жил хорих ял шийтгэнэ.

Зүйл 203 алеф. Бие үнэлүүлэхийн тулд хүн худалдаалах

(алеф). Хэн нэгэн бие үнэлэхэд татан оролцуулах зорилгоор хүнийг худалдсан буюу худалдан авсан, нэгэн адил хэн нэгэн бол тухайн худалдаанд зуучлагчаар оролцсон бол арван зургаан жил хорих ял шийтгэнэ; энэхүү зүйлийн “худалдах буюу худалдан авах” гэдэгт мөнгө, мөнгөтэй тэнцэх эд зүйлс, үйлчилгээ болон бусад орлогын төлөө гэж ойлгоно.

(бет). Хэн нэгэн бусад этгээдийг хилийн цаана бие үнэлэх зорилгоор өөрийн оршин сууж байгаа орныг орхихыг уруу татсан бол арван жил хорих ял шийтгэнэ.

(гимел). Энэхүү зүйлээр гэм буруутай гэж тогтоогдсон этгээдэд хэрэв шүүх ял хөнгөрүүлэх онцгой шалтгааныг бичгээр тогтоосноос бусад тохиолдолд энэхүү зүйлээр тогтоосон хамгийн дээд хугацааны дөрөвний нэгээс багагүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(далет). Энэхүү зүйлийн (гимел) хэсэгт заасан гянданд хорих ял ямар нэгэн онцгой шалтгаангүй байж болохгүй, бүрэн нөхцөлтэй байна.

Зүйл 203 бет. Бие үнэлэхэд насанд хүрээгүйчүүдийг ашиглах

(алеф). 199, 201, 202, 203 буюу 203 алеф зүйлүүдэд заасан гэмт хэргийг арван дөрвөн насанд хүрсэн этгээдийн хувьд үйлдсэн бол уг этгээдийг дараах ял шийтгэнэ:

(1). Гэмт хэрэг үйлдсэний төлөө гянданд таван жил хорих – гянданд долоон жил хорих;

(2). Гэмт хэрэг үйлдсэний төлөө гянданд долоон жил хорих – гянданд арван жил хорих;

(3). Гэмт хэрэг үйлдсэний төлөө гянданд арван жил хорих – гянданд арван таван жил хорих;

(4). Гэмт хэрэг үйлдсэний төлөө гянданд арван зургаан жил хорих – гянданд хорин жил хорих;

(бет). 199, 201, 202, 203 буюу 203 алеф зүйлүүдэд заасан гэмт хэргийг арван дөрвөн насанд хүрээгүй этгээдийн хувьд үйлдсэн, үүнтэй адил насанд хүрээгүй хүний төлөө хариуцлага хүлээж байгаа этгээд арван дөрвөн насанд хүрсэн этгээдийн хувьд үйлдсэн бол тухайн зүйлүүдэд заасан ял шийтгэлийг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхээр шийтгэх ба энэ тохиолдолд хорин жилээс дээш нэмэгдүүлж болохгүй.

(гимел). Энэхүү зүйлийн “насанд хүрээгүй хүний төлөө хариуцлага хүлээх этгээд” гэж 368 алеф зүйлд зааснаар ойлгоно.

Зүйл 203 гимел. Насанд хүрээгүй этгээдээр үйлчлүүлэгчийн хариуцлага

Хэн нэгэн насанд хүрээгүй этгээдийн үйлчилгээг түүнтэй бэлгийн төлбөртэй харьцаанд орох байдлаар авсан бол гурван жил хорих ял шийтгэнэ.

Статья 203 далет. Нотлох үүрэг

Энэхүү бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдийн насыг мэдээгүй гэж мэдүүлж байгаа хэн нэгэн нотлох үүргээ өөрөө хүлээнэ. Энэхүү үндэслэлийн үйлчлэл 214 (бет3) зүйлд үл хамаарна.

Зүйл 204. Бие үнэлэх байр бэлдэх (эзэмших)

Хэн нэгэн бие үнэлэх зорилгоор авто тээвэр болон усан тээврийг оролцуулаад байр эзэмшиж байсан буюу удирдаж байсан бол таван жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зүйл 205. Бие үнэлэх байр гаргаж өгөх

Хэн нэгэн энэхүү байр нь бэлгийн төлбөртэй харьцаанд ашиглагдаж баайсан болон ашиглагдахыг мэдсээр байж, авто тээвэр болон усан тээврийг оролцуулаад тийм байр гаргаж өгсөн буюу гаргаж өгч байснаа сэргээсэн бол зургаан сар гянданд хорих ял шийтгэнэ. Бас уг байрыг дээр дурдсан зорилгоор ашиглаж байгааг мэдсэний дараа,

хэдийгээр тэр байрыг суллахыг шаардах, гаргаж өгөхийг зогсоох эрхтэй боловч байр өгөхийг зогсоогоогүй этгээдийг мөн адил шийтгэнэ.

Зүйл 205 алеф. Насанд хүрээгүйчүүдийн бие үнэлэх тухай материал тараах ба мэдээлэл дамжуулахыг хориглох

Хэн нэгэн насанд хүрээгүй этгээдийг төлбөртэйгээр бэлгийн харьцаанд оруулах хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх тухай мэдээлэл дамжуулсан буюу материал тараасан бол таван жил хорих ял шийтгэнэ. Энэ зүйлд заасан гэмт хэргийн хувьд энэхүү бэлгийн (секс) үйлчилгээг Израилд эсхүл Израилын гадна санал болгосон, дээр дурдсан мэдээлэл нь насанд хүрээгүй тодорхой этгээдэд хамаарах болон үл хамаарах эсэх, тараагдсан материалд секс үйлчилгээ үзүүлэх этгээд нь насанд хүрээгүй этгээд байгаа эсэх нь ямар нэгэн ач холбогдолгүй.

Зүйл 205 бет. Секс үйлчилгээ үзүүлэх (санал болгох) тухай материалд насанд хүрээгүй этгээдийн нас заахыг хориглох

Хэн нэгэн насанд хүрээгүй этгээдийн секс үйлчилгээ үзүүлэх тухай материал тараасан боловч, хэрэг дээрээ энэ нь этгээд нь насанд хүрээгүй этгээд биш байсан бол гянданд зургаан сар хорих ял шийтгэнэ.

Зүйл 205 гимел. Насанд хүрээгүйчүүдийн бие үнэлэх тухай материал дэлгэрүүлэх тараахыг хориглох

(алеф). Хэн нэгэн насанд хүрээгүй этгээдийн секс үйлчилгээ үзүүлэхийг санал болгосон материал тараасан бол гянданд зургаан сар хорих ял шийтгэнэ.

(бет). Энэхүү зүйлийн заалт (алеф) –ын үндэслэл дараах нөхцөл байдлуудад секс үйлчилгээ санал болгосон материалд үл хамаарна:

(1). түүнд зөвхөн секс үйлчилгээ үзүүлэх тухай яригдаж байгаа бол;

(2). бусад материалаас тусдаа тараагдсан бол;

(3). түүнийг зөвхөн өөрийнх нь хүсэлтээр өгсөн бол

(4). Түүнд зорилго нь секс үйлчилгээ тараах зорилгыг тодорхой байдлаар онцолсон бол.

(гимел). Хууль зүйн сайд энэхүү зүйлийг биелүүлэх талаар захирамжыг Хууль тогтоомж болон шүүн таслах ажиллагааны Кнессетын комисс батлагдсаны дараа гаргах эрхтэй.

Зүйл 208. Насанд хүрээгүй этгээдийг притонд амьдрахыг зөвшөөрөх

Хэн нэгэн өөрийн хяналтанд байгаа буюу асран хамгаалалтанд байгаа хоёроос арван долоон насны хүүхдийг притонд амьдруулах, эсхүл түүнд байнга очих боломж олгосон бол гянданд гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Бүлэг 6. Нийгмийн удирдлагын журмын эсрэг гэмт хэрэг

§ 8. Бие үнэлэх явдлыг зохион байгуулах, албадах, уруу татах, энэ зорилгоор байр гаргаж өгөх болон зуучлахтай холбоотой гэмт хэрэг

Зүйл 358

Гуравдагч этгээдийн бие үнэлэх явдлыг зохион байгуулах буюу гуравдагч этгээдийг бие үнэлэх явдалд татан оролцуулсан бол 5-10 жилийн хугацаагаар хорих буюу мөн торгох ял шийтгэнэ; энэхүү үйлдэл нь дор дурдсан аль нэг нөхцөл байдалтай бол 10 жилээс дээш жил буюу хугацаагүй хорих ялаар, мөн торгууль буюу эд хөрөнгө хураах ялаар шийтгэнэ:

1) Гуравдагч этгээдийн бие үнэлэх явдлыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зохион байгуулсан;

2) бие үнэлэх явдалд 14 нас хүрээгүй охидыг албадсан;

3) бие үнэлэх явдалд олон тооны гуравдагч этгээдийг буюу гуравдагч этгээдийг олон удаа албадсан;

4) хүчиндсэний дараа бие үнэлэх явдалд албадсан;

5) бие үнэлэх явдалд этгээдийн биед бие махбодийн гэмтэл учруулсан, эсхүл үхэх буюу өөр хүнд үр дагаварт хүргэсэн үйлдэл хийсэн.

Дурдсан үйлдлийн аль нэгийг онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол хугацаагүй хорих буюу цаазаар авах, мөн түүнчлэн хөрөнгө хураах ял шийтгэнэ.

Бие үнэлэх явдалд гуравдагч этгээдийг зохион байгуулахад хатарч оролцсон этгээдийг 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу богино хугацаагаар баривчлах, мөн түүнчлэн торгох ял шийтгэнэ; хүндрүүлэх нөхцөл байдалд 5-10 жил хорих ба торгох ял шийтгэнэ.

Зүйл 359

Бие үнэлэх явдалд гуравдагч этгээдийг уруу татсан, үүний тулд байр гаргаж өгсөн, сводничество бол 5 жил хүртэл хугацаагаар хорих, богино хугацаагаар баривчлах буюу хяналт тавих, мөн түүнчлэн торгох ял шийтгэнэ; хүндрүүлэх нөхцөл байдалтай бол – таваас дээш жил хорих ба торгох ял шийтгэнэ.

Бие үнэлэх явдалд 14 нас хүрээгүй охидыг уруу татсан бол 5-аас дээш жил хорих буюу торгох ялаар шийтгэнэ.

Зүйл 360

Өөрийгөө тэмбүү, заг хүйтэн болон бэлгийн замын бусад өвчтэйг мэдсээр байж бие үнэлэх явдал болон садар самуун үйл эрхэлсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу богино хугацаагаар баривчлах буюу хяналт тавих, мөн торгох ялаар шийтгэнэ.

14 насанд хүрээгүй охидтой садар самуун үйлд хийсэн бол 5 жилээс дээш хугацаагаар хорих буюу торгох ял шийтгэнэ.

Зүйл 361

Зочид буудлын ажилчид, нийтийн хоолны үйлчлэгч ажилчид, соёл-амралтын байгууллагын болон такси-үйлчилгээний компаниудын, болон бусад байгууллагын ажилтнууд дурдсан байгууллагын нөхцлийг ашиглан гуравдагч этгээдийг бие үнэлэх явдалд уруу татсан, зохион байгуулсан, албадсан, үүний тулд байр гаргаж өгсөн, эрхэлсэн бол энэ хуулийн 358 ба 359 зүйлд зааснаар ял шийтгэнэ.

Энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн дээр дурдсан байгууллага, албан газрын удирдах ажилтнуудыг энэхүү зүйлд заасан хамгийн хүнд ялаар шийтгэнэ²⁴.

ДЭД ДҮГНЭЛТ

Монгол Улсад бие үнэлэхтэй тэмцэх асуудал захиргааны аргаас хэтрэхгүй байна. Харин үүнд өөр зохицуулалт шаардагдаж байна. Янхлах²⁵ (prostitution) үзэгдлийг Монгол Улсын Эрүүгийн хуульд “Биеэ үнэлэх” гэсэн хууль зүйн нэр томъёогоор илэрхийлсэн байна. Гэхдээ өөрөө биеэ үнэлэх нь Эрүүгийн гэмт хэрэг биш гэж тооцогдох учраас биеэ үнэлэхийг хүлээн зөвшөөрсөн улсад багтаж байгаа юм. Гэтэл гадаад улс орнуудад сайн дураар биеэ үнэлэх, хүсэл зоргийн эсрэг гадуур хүчээр биеийг нь үнэлүүлэх (үнэлэх) асуудлыг ялгаатай авч үзэж, зарим улс орнуудад биеэ үнэлэхийг хүлээн зөвшөөрч, биеийг нь хүчээр үнэлүүлэх, тэдний орлогоор амь зуух, биеэ үнэлэгчийг мөлжих, байр сав бэлдэхийг эрүүжүүлж (криминализаци), гэмт хэрэгт тооцож ялтай (пенализаци) болгожээ.

Үүнээс үзэхэд манай улсад хүн худалдаалах, бэлгээр мөлжих гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдээгүй гэж үзэж болно. Хүн худалдаалах, тэднийг бэлгийн мөлжлөгт татан оролцуулах гэмт явдал гарахад ядуурал, ажилгүйдэл өсч, үүнтэй холбоотойгоор хүмүүс гадаад улс оронд шилжих хөдөлгөөн, гэр бүлийн хямрал, хүчирхийлэл, хууль тогтоомжийн хийдэл, боловсронгуй бус байдал болон бусад олон хүчин зүйл нөлөөлж байна.

²⁴ Уголовный кодекс Китайской Народной Республики 1997 г //www.legal-way.ru

²⁵ И. Дамбажав нар., Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг.УБ., 2006. II боть. 1219 дэх тал.

Гадаад улс орнуудын хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн хэм хэмжээг хуульд тусгах илэрхийлэх байдал, түүнийг гэмт хэрэгт тооцсон онцлог, бүрэлдэхүүн, зүйлчлэх асуудлын талаас нь авч үзье.

Хүний худалдааг бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, цус эд эрхтэнг авах, цэргийн болон зэвсэгт бүлэглэлд алба хаалгах, гэмт хэрэгт татан оролцуулах, гуйлга гуйлгуулах, өрийн барьцаанд авах, хүчээр гэрлүүлэх, хүүхдийг үрчлэх болон бусад олон хэлбэрээр хийж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн бэлгийн болон албадан хөдөлмөрлүүлэх зэрэг хүнийг мөлжих хэлбэрээр үйлдэгдэж байна.

Гадаад улс орнуудын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжоос үзэхэд мөлжлөгийн үндсэн нэр төрлийн хувьд бэлгийн мөлжлөг нь дараах хэлбэрээр оршиж байна гэж үзэж болно:

- Биеийг нь үнэлүүлэхээр тулган шаардах болон мансууруулах, согтууруулах зэрэг нөлөөллийн бодис хэрэглэн сайн дураар биеэ үнэлэхэд хүргэх;
 - Порнографын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцохыг тулган шаардах буюу дээр дурдсан нөлөөллийн хэрэгслийг ашиглан порнографын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд сайн дураар оролцуулан мөлжих;
 - Бэлгийн боолчлол (жишээлбэл, хохирогчийг “гэрийн эзэгтэй” хэлбэрээр болон цэргийн анги салбарт бэлгийн мөлжлөгт оруулах)
 - Хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу садар самуунд уруу татах (педофиль²⁶)
- Эдгээр хэлбэр бүр өөрийн дэд хэлбэртэй байна.

Жишээлбэл: хүүхдийн бэлгийн мөлжлөг нь:

- Хүүхдийг биеийг нь үнэлүүлэх;
- Хүүхдийн порнограф;
- Сексийн зорилгоор ашиглах зорилготой хүүхдийн треффик;
- Хүүхдийг ашиглах зорилготой секс туризм;
- Эрт гэрлүүлэх гэх зэрэг.

Товчоор тодорхойлбол, бэлгийн мөлжлөг гэж бусад этгээдээс бэлгийн шинжтэй үйлдэл, түүний дотор биеийг нь үнэлүүлэх болон биеэ үнэлэх зэргээс ашиг хонжоо олохыг хэлнэ.

Иймд энэ үзэгдлийн төрөл хэлбэрийг нарийвчлан тодорхойлох шаардлага байгаа юм. Энэ үзэгдлийн урьдчилан танин мэдэж, манай улсад аль үзэгдэл нь давамгайлах хандлага байгааг тодорхойлж, эцэст нь урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг нийгэмшүүлэх арга хэмжээг тодорхойлох боломжтой юм.

²⁶ Хүүхдэд дурлах гэсэн утгатай грек гаралтай үг бөгөөд хүүхэдтэй хурьцах дон// зох

Бэлгийн хүчирхийлэл гэж аливаа хүний хүсэл зоригоос гадуур, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх замаар бэлгийн харьцаанд ямар нэгэн хэлбэрээр орохыг тулган шаардсан буюу оруулсан гэмт үйлдэл. Бэлгийн хүчирхийллийн зорилго сэдэлт нь шунахай (бэлгийн мөлжлөгт оруулах), өш хонзон, атаархал, танхай гэх зэрэг байж болно.

Бие үнэлэх нь бэлгийн хүчирхийллийн нэг үндсэн хэлбэр мөн. Энэ үзэгдэл нь: биеэ үнэлэх, биеийг нь үнэлүүлэх гэсэн үндсэн хоёр дэд хэлбэртэй байна. Биеийг нь үнэлүүлэх гэж аливаа хүний хүсэл зоригоос гадуур, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхийг заналхийлж, тодорхой төлбөртэйгээр бэлгийн харьцаанд оруулах, цаашид үргэлжлүүлэн бие үнэлүүлэхийн тулд албадсан үйлдэл. Биеэ үнэлэх нь тухайн хүн өөрийн бие эд эрхтэн, мэдээллээ бэлгийн зорилгоор бусдад төлбөртэйгээр сайн дураар (хүсэл зоргийн дагуу) ашиглуулж байгаа хэлбэр мөн.

Орчин үеийн нийгэмд бие үнэлэх асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн хандлага байна. Тэдний нэг нь биеэ худалдах нь ёс суртахуунгүй усгаж арилгавал зохих үзэгдэл учраас бие үнэлэгч болон тэдний үйлчлүүлэгчийн эсрэг хатуу санкцаар тэмцэх ёстой гэж үзэж байна. Ингэж АНУ-ын ихэнх нутаг, мусульманы орнууд үзэж байна.

Бусад зарим улс орнуудад бие үнэлэх асуудлыг зайлшгүй байх гаж үзэгдэл гэж нэрлэж түүнийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо больж, бүрэн зөвшөөрөх замаар гэмт явдлын нөлөөнөөс секс-индустрид шилжүүлэхийг оролдож байна. Нидерланд, Герман зэрэг улс оронд амжилттай туршиж байна.

Гэвч зарим газар (жишээ нь Их Британи болон Франц гэх зэрэг) бие үнэлэхийг нийгмийн мөнхийн гаж дагуул гэж үзэж байгаа боловч түүнийг нэг их дэмжихийг хүсэхгүй байгаа юм. Эдгээр улс оронд биеэ худалдахыг зөвшөөрөх боловч харин бэлгийн мөлжлөгийг, өөрөөр хэлбэл бие үнэлэхийг бусдын амьдрахуйн эх үүсвэр болгох (паразит) асуудлыг гэмт хэрэгт тооцож байна. Энэ категорийн улс орнуудад манай орныг хамааруулж болох юм.

Эцэст нь бие үнэлэхэд зөвхөн үйлчлүүлэгч буруутай гэсэн өөр байр суурь бий. Ийм ч учраас бие үнэлэгчийг биш, харин үйлчлүүлэгчийг хуулийн дагуу мөрдөн мөшгөх болсон байна. Энэхүү хандлага нь одоогоор Шведэд туршигдаж байна.

Секс-индустри ил хууль ёсны болох нь эрэлт хэрэгцээг улам нэмэгдүүлж байна. Секс-индустри-хөгжсөн, бие үнэлэх явдлыг зөвшөөрсөн эсхүл ил болгосон (Голланд, Герман гэх зэрэг) улс орнууд нь худалдаалагдсан эмэгтэйчүүдийг хүлээн авах гол цэг болж байна. Ийм ч учраас биеэ үнэлэхийг хорьсон, хагас хорьсон улс орнуудаас ил болгосон улс оронд хүн худалдаалагдах урсгал эрс нэмэгдэж байна.

Голланд улс нь хүн худалдаалах гэмт хэргийн хүрээнд 16 нас хүрээгүй хүүхдийг (зүйл 250) худалдаалсан бол онц хүндрүүлэхээр заахын хамт өөрийн улс орны онцлогоос хамаарч боол тээвэрлэсэн хөлөг онгоцны ахмадыг хатуу шийтгэхээр (зүйл 275) заажээ. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2.5-д насанд хүрээгүй хүнийг худалдсан бол ял хүндрүүлж, 5-10 жил хорих ял ногдуулахаар заажээ.

Хүн худалдаалах, тэднийг бэлгийн мөлжлөгт татан оролцуулах гэмт явдал гарахад ядуурал, ажилгүйдэл өсч, үүнтэй холбоотойгоор хүмүүс гадаад улс оронд шилжих хөдөлгөөн, гэр бүлийн хямрал, хүчирхийлэл, хууль тогтоомжийн хийдэл, боловсронгуй бус байдал болон бусад олон хүчин зүйл нөлөөлж байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХООС АЙХ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

а) Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймгийн иргэд болон Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Багахангай, Сүхбаатар, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх зэрэг 8 дүүргийн иргэдийг оролцуулан нийт 1449 иргэнээс авсанаас 916 буюу 63.2 хувь орон нутгаас, 533 буюу 36.8 хувь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын 660 буюу 45.5 хувь эрэгтэй, 789 буюу 54.5 хувь нь эмэгтэй байна.

Дээрх иргэдийг насны байдлаар нь авч үзвэл, 21 хувь нь 18-25 нас, 37 хувь нь 26-35 нас, 24 хувь нь 36-45 нас, 12 хувь нь 46-55 насны иргэд байна²⁷.

б) Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл

Нуугдмал гэмт хэргийн түвшинг хэмжих өөр нэг аргачлал нь гэмт хэргээс түгших, айх явдал. Гадаадын зарим оронд явуулсан гэмт хэрэгт хохирох эрсдлийн судалгааны дүнгээс үзэхэд тодорхой төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй гэж айдас нэмэгдэх тусам тухайн нийгэм дэх нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр гэж үздэг. Өөрөөр хэлбэл, иргэд гэмт хэргээс айх, түгших хандлага өндөр байх нь хууль сахиулах байгууллага гэмт хэргийг бүрэн хяналтандаа авч чадаагүйгээс гэмт хэрэг нуугдмал шинжтэй болж, цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй байгааг илэрхийлдэг. Нөгөө талаар нийгэмд түгээмэл үйлдэгддэг хэдий ч цагдаагийн байгууллага бүрэн хяналтандаа авч чадаж байвал гэмт хэргээс иргэд түгших хандлага бага байдаг.

Энэ асуудлыг тодорхойлох зорилгоор тодорхой төрлийн 8 гэмт хэргээс түгших хандлагыг дараах асуултаар шалгасан болно. Хүснэгт №3-т үзүүлсэн дүнгээс үзвэл *“Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ”* гэхээс айдаг гэсэн асуултанд хариулсан байдлын дундаж нь 3.18 бол дараагийн дугаарт *“Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна”* гэхээс айдаг гэсэн асуултын дундаж хариулт 3.14 гэсэн үзүүлэлттэй байна.

Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн төрөлд бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.94 гэсэн дундаж үзүүлэлтээр орж байгаа бол хууль бусаар мөрдөх гэмт хэргийн 2.96 гэсэн үзүүлэлттэй байна. Бусад гэмт хэргийн дундаж үзүүлэлт 3.60 байгаа нь тийм ч сайн үзүүлэлт биш.

²⁷ Доктор (Ph.D) Б.Энхболд. “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа-2017”, УБ., 2018, 45-48 дахь тал

Тодорхой төрлийн гэмт хэргийн айдас						
[7] Хүн бүр гэмт хэргийн хохирогч болохоос айдаг. Тиймээс дараах асуултууд нь таны өдөр тутмын амьдрал дахь гэмт хэргийн айдсын төрлийг илэрхийлнэ.						
	Огт айдасгүй байдаг	Айдасгүй байдаг	Тодорхой бус	Айдастай байдаг	Их айдастай байдаг	Дундаж
Миний амь нас, эрүүл мэндэд хэн нэгэн халдаж хохироож болзошгүй гэж	6.4%	22.5%	37.4%	30.4%	3.3%	3,0168
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт зүйлсийг хүч хэрэглэж авна гэхээс	5.7%	23.8%	34.9%	32.2%	3.5%	3,0412
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна гэхээс	5.5%	20.8%	32.6%	36.1%	5.1%	3,1462
Хэн нэгэн миний эд хөрөнгийг залилан мэхлэж авна гэхээс	5.2%	22%	38.7%	30.2%	3.8%	3,0552
Хэн нэгний бэлгийн халдлагад өртөгдөнө гэхээс	8.7%	24.6%	36.1%	25.1%	5.4%	2,9401
Хэн нэгэн миний эд хөрөнгийг санаатай устгаж, гэмтээж болзошгүй гэхээс	3.7%	22.4%	39%	30%	4.9%	3,0992
Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ гэхээс	3.8%	21.1%	33.7%	35.4%	6%	3,1865
Хэн нэгэн намайг мөрдөж сэтгэл санааны дарамтад оруулна гэхээс	6.5%	26%	36.6%	26.3%	4.5%	2,9624
Тодорхой төрлийн гэмт хэргийн айдас улсын хэмжээнд 3.0559 коэффициентийг илэрхийлж байна.						

в) Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 15 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн шинжилгээ хийсэн болно. Эх олонлогоос түүвэрлэлт хийх замаар судалгаанд оролцогчдыг сонгож авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын нөхцөл байдлыг илэрхийлэх чадвартай гэж үзсэн болно.

Хүснэгт №4-т гэмт хэргийн улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмблэн харуулав. Судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 389 буюу 26.9 хувь нь ямар нэгэн байдлаар хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авах замаар хохирсон гэж тус тус хариулжээ.

Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байгаа нь өмнөх асуулгын үр дүнтэй нийцэж байна.

Хүснэгт 6.2. Гэмт хэрэгт шууд хохирсон байдал

№	Гэмт хэргийн төрөл	Тийм	Үгүй
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	32.0%	68.0%
2	Хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авч	26.9%	73.1%
3	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	17.8%	82.2%
4	Гүтгэгдэж, доромжлогдож	16.3%	83.7%
5	Зам тээврийн осолд өртөж	15.1%	84.9%
6	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	14.5%	85.5%
7	Бусдын халдлагад өртөж	14.3%	85.7%
8	Эд хөрөнгөө булаалгаж	11.8%	88.2%
9	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	10.1%	89.9%
10	Цахим гэмт хэрэгт өртөж	8.0%	92.0%
11	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж	6.5%	93.5%
12	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	6.3%	93.7%
13	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	5.4%	94.6%
14	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	4.8%	95.2%
15	Хууль бус мөрдлөгийн улмаас	4.7%	95.3%

7.1. НИЙГМИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ (INCOME INEQUALITY)

Давхраажил гэсэн нэр томъёо нь үе, давхраа, давхраажил, үелэл гэсэн утга бүхий *strata* гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд социологийн ухаанд нийгмийн шатлан захирах тогтолцоонд эд баялаг, нэр хүндийг хүртэх боломжоороо ялгардаг бүлгүүдийн зэрэг шатлалыг тэмдэглэдэг.

2030 онд тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхээр зорьж буй өнөө үед эдийн засаг, нийгмийн тэгш бус байдлыг шийдэх хэрэгтэй юм. Улс орнуудын дунд эдийн засгийн ялгаатай байдал ерөнхийдөө багасч байгаа ч хөгжиж буй олон оронд баян хоосны ялгаа ихсэж, нийгмийг тогтворгүйжүүлэн, хөгжил дэвшилд саад учруулж болзошгүй байна. Монголд бараг гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна. Тэгш бус байдал бол дан ганц хөрөнгө мөнгө, орлогын тухай асуудал бус энэ нь эдийн засгийн тэгш бус байдлаас үүдэн харилцан бие биедээ нөлөөлдөг эрх мэдэл, хүний эрх, боломжтой холбоотой асуудлууд юм.

Нийгэмд хөдөлмөрийн хуваарь гарч, хүмүүсийн амьдрах орчин, эрхлэх аж ахуй, нийгмийн баялгаас хүртэх боломж харилцан адилгүй болсноос ялгарал гарчээ. Чухамхүү энэ ялгаралд эд хөрөнгийн, эрх мэдлийн, зэрэг зиндааны, боловсролын, мөн хүйсийн зэрэг нийгмийн тэгш бус байдлыг бий болгоно. Давхраажилт (*stratification*–англиар, стратификация–оросоор) геологийн шинжлэх ухаанаас социологид орж ирсэн, *stratum*-давхраа: *fasio*-хийж байна гэсэн латин үгнээс бүтсэн ойлголт юм. Иймд давхраажилтын хэмжигдэхүүнийг жендерийн эрх тэгш байдлын хэмжигдэхүүн талаас нь авч үзье.

Жендер бол түүхэн явцад хувьсах шинжтэй нийгэм-соёлын ойлголт учраас жендер нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаанаас улбаалан соёл, түүхийн хэлхээсэнд тодорхойлогдож буй нийгмийн ойлголт юм. Тэгвэл жендер /*gender is a social construction*/ гэдэг нь эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн харилцаанд зохицсон, нийгмийн бүтэц, соёлын хэм хэмжээг илэрхийлэн гаргасан цогц шинж чанар мөн.

Үүнээс үзэхэд жендер гэж улс төр, эдийн засаг, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар тогтсон, түүхэн явцад хөгжин өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага юм.

Жендерийн эрх тэгш байдал гэж хүйсийн шинжээр ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоосны үр дүнд эрэгтэй, эмэгтэй хүн нийгмийн амьдралын бүхий л хүрээний үйл ажиллагаанд эрх тэгш оролцож, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын үр шимээс тэгш хүртэж, үүрэг хариуцлагыг тэгш хүлээх явдал, нөгөө талаас эрэгтэй, эмэгтэй хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэднийг эрх тэгш үнэ цэнэтэй байлгах гэж тодорхойлж болно.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглалын (1993) 1-р зүйлд “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийг тодорхойлохдоо “нийгмийн болон хувийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийг махбодын, бэлгийн болон сэтгэл зүйн зовиур шаналгаа амсахад хүргэж болзошгүй жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг, түүний дотор үйлдэхээр заналхийлэх, эрх чөлөөг нь хасах буюу хасахаар заналхийлэх явдлыг хэлнэ”²⁸ гэж заасан. ЖСХ-ийн дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байдгаас энэ нь нийгэмд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж нэрлэгдэж байна.

Гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын чанар, эрүүл мэндийн асуудлыг жендерийн өнцгөөс авч үзэх шаардлагатай байна. 2017 онд гэр бүлийн хүчирхийлэлд 1120 иргэн өртөсний 92.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн амиа хорлолт эмэгтэйчүүдийнхээс 5.5 дахин, хүчирхийлэл үйлдэх хандлага 3.6 дахин, зам тээврийн осолд өртөх тохиолдол 3.4 дахин өндөр байна²⁹.

Германы эрдэмтэн Макс Веберийн үзэл санаанд тулгуурлан эд баялаг, нэр хүнд, эрх мэдэл гурвыг нийгмийн давхраажилтын гурван хэмжигдэхүүн гэж үздэг.

Монгол Улсын жендерийн эрх мэдлийн хэмжүүр 0.42 байгаа нь эдийн засаг, улс төрийн хүрээ болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.

7.2. ЭД БАЯЛАГ БА ОРЛОГО

Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн эсвэл ядуурлын түвшин нь хүмүүсийн эрүүл мэнд, насжилт, нийгэм дэхь эмх замбараагүй байдал, гэмт хэргийн өсөлт зэрэгтэй шууд хамааралгүй бөгөөд нэг хүнд ноогдох орлого нь их байлаа гээд тэр нийгэм асуудалгүй, амар тайван, баян чинээлэг байх албагүй гэж Richard Английн Richard G. Wilkinson тэргүүтэй судлаачдын судалгаагаар аль хэдийн батлагдаад байна.

²⁸ Жендерийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ 2013 он

²⁹ Чинзориг С.: Жендерийн тэгш байдлыг хангах нь хөгжлийн үндсэн түлхүүр//<http://www.mlsp.gov.mn/nnews/242>

Өөрөөр хэлбэл нийгмийн баялаг нийт иргэдэд хэр хүртээмжтэй хуваарилагдаж байна тэр чинээгээрээ асуудлууд бага, харин баян хоосны ялгаа, тэгш бус байдал гүнзгий байх тусмаа гэмт хэрэг, стресснээс үүдэлтэй өвчлөл гээд нийгмийг бүхэлд нь хамрах олон асуудлууд тулгамдана. Эд баялаг орлогын тэгш байдлын гол хэмжигдэхүүн нь нийгмийн баялгийн шударга хувиарлалт гэж ойлгож болно.

2017 оны Үндэсний статистикийн хорооны судалгаагаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын хэмжээнд 955.9 мянган төгрөг, үүнээс эмэгтэйчүүдийнх 846.1 мянган төгрөг, эрэгтэйчүүдийнх 1 сая 67.9 мянган төгрөг, цалингийн зөрүү 221.8 мянган төгрөг болжээ. Энэ зөрүү нь цалингийн хэмжээнээс хамааралтай тэтгэвэр, тэтгэмжид нөлөөлж байна. Тухайлбал, 2016 оны байдлаар эмэгтэйчүүдийн өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдийнхээс 68.4 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар бага байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2018 оны 3 дугаар улиралд нийт 40.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 651.1 мянган ажиллагчид хамрагдсан байна. Шимтгэл төлж буй ААНБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.1 (5.4%) мянгаар, өмнөх улирлаас 0.4 (1.0%) мянгаар өссөн бол ажиллагчид өмнөх оны мөн үеэс 44.8 (7.4%) мянгаар, өмнөх улирлаас 14.6 (2.3%) мянгаар тус тус нэмэгджээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан эдгээр ажиллагчдын 48.3 (7.4%) мянга нь 240000 төгрөг хүртэлх цалинтай, 138.8 (21.4%) мянга нь 240001-500000 төгрөгийн цалинтай, 226.5 (34.7%) мянга нь 500001-900000 төгрөгийн цалинтай, 116.6 (17.9%) мянга нь 900001-1300000 төгрөгийн цалинтай, 30.5 (4.7%) мянга нь 1300001-1500000 төгрөгийн цалинтай, 90.3 (13.9%) мянга нь 1500001 төгрөгөөс дээш цалинтай байна.

Цалингийн ялгаа эдийн засгийн салбарын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн статус, зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжсөн, цалин хөлс өндөртэй уул уурхай, барилга, аж үйлдвэр, эрчим хүч, тээвэр ба агуулахын үйлчилгээ, мэдээлэл холбоо зэрэг салбарт эрэгтэйчүүд голлож, бөөний худалдаа, орон сууц, нийтийн аж ахуй, эрүүл мэнд боловсролын үйлчилгээ, хүнсний салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн голлон ажиллаж байгаа бөөний болон жижиглэнгийн худалдаа, хүнсний салбар нь жижиг аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэлт ихтэй учир нийгмийн хамгааллын асуудлууд нь доголдолтой байгаа юм. Хөдөлмөрийн зах зээл дээрх жендэрийн тэгш бус байдлыг арилган эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр, нийгэмд олон төрлийн эерэг

үзүүлэлтүүд гардаг байна. Хүүхэд болон ахмад настэнуудыг харах үйлчилгээ дутмаг байдгаас эмэгтэйчүүдийн ихэнх нь хөдөлмөр эрхлэх боломжгүй байна. Эмэгтэйчүүд ажил хөдөлмөр эрхлээгүйн улмаас санхүүгийн болон сэтгэл зүйн дарамттай байдаг гэсэн судалгаа гарсан.

Ядуу гэр бүлийн эд хөрөнгө, хоол тэжээлийн хомсдолтой байдал тэдний эрүүл мэндийг доройтуулдаг. Сургуульд суралцах боломж хомс дээрээ эрүүл мэндийн доройтол сурах чадварыг нь ч хумина. Ингээд тэдний боловсролын түвшин доогуур, үүнээсээ болоод ажил олох магадлал муу болно. Ажилгүй болохоор орлого нь хангалттай биш байж өнөө л ядуурлын гинжин хэлхээнээсээ гарч чаддаггүй байна. Үүнийг ядуурлын цикл гэдэг юм. Өлөн хоосон ард түмний сэтгэл баян байж яагаад ч чаддаггүй байна л даа. Ходоод шигээ хоосон болдог байна. Энэ тохиолдолд төр нь ялгаагүй хоосон, хуурмаг бодлого явуулж эхэлдэг. Үүнийг популизм гэнэ. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр өнгөрсөн 2017 оны эхний гурван улирлын дунджаар жини коэффициентийн³⁰ үзүүлэлт 0.343 болжээ. Энэ итгэлцүүр 2016 онд 0.332 болсон нь сүүлийн найман жилийн хамгийн сайн үзүүлэлт байсан юм. Тэгвэл энэ үзүүлэлт жилийн хугацаанд 0.1-ээр дээшлэв. Дөрвөн жил тасралтгүй саарсан эдийн засаг үл ялиг сэргэж эхэлсэн мөчлөгтэй жини коэффициентийн өсөлт давхацсан нь анхаарал татаж байна. Генетические–ухудшение генетического потенциала нации в результате алкоголизма, наркомании, ухудшения экологии; увеличение числа новорожденных с серьезными генетическими аномалиями.

Социально-медицинские–разрушение бесплатной и общедоступной системы медицинской помощи, несвоевременное выявление соматических и психических заболеваний, увеличение доли лиц, перенесших черепно-мозговые травмы.

Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-с гаргасан нэгэн тайланд Монголын уул уурхайн эздийн орлого хамгийн орлого багатай иргэдийн хооронд 250 дахин их зөрөө гарчээ. Ер нь бол энд тоон үзүүлэлт энтэр гэлтгүй бодит байдал дээрх гэр хороолол хотын төвийн иргэдийн амьрал аж байдалд хийсэн ажиглалтаар энэ бүрэн дүүрэн нотлогдоно.

Монголын Улсын хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн дундаж цалин 955 мянган төгрөгт хүрсэн. Гэвч нийт хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 70 хувь нь дунджаас бага

³⁰ Жини коэффициентийн аргачлалыг Италийн социологич, статистикч Коррадо Жини 1912 онд гаргасан гэдэг. Тэртээ 100 гаруй жилийн өмнөөс энэ коэффициент баян, ядуугийн ялгааг илэрхийлэх гол хэмжүүр болсоор ирсэн. Тиймээс улс орон бүр л энэ хэмжүүрээр баян, ядуугийн ялгаагаа “дэнсэлж”, төрийн бодлого хэрэгжүүлэхдээ ашиглаж байна. Коэффициентийг 0-1 хүртэл тоогоор илэрхийлдэг. Коэффициент 0 рүү дөхөх тусам хүн амд нийгмийн баялаг, улс орны орлого жигд хуваарилагдаж байгааг заадаг.

цалинтай. Банкин дахь хадгаламжийн 90 хувийг нийт хадгаламж эзэмшигчийн нэг хүрэхгүй хувь нь эзэмшдэг. Эдгээр статистик орлогын ялгаа талийж өгснийг харуулна. Уул уурхайн баялгийг иргэдэд тэгш хуваарилахгүй, нийгмийн орлого ихтэй хэсэгт чадал тэнхээнд нь тохируулсан ачаа үүрүүлэхгүй бол жини коэффициент нэмэгдсээр байх болно.

Нийгэм дэхь тэгш бус байдлын гүнзгийрэл, баян хоосны ялгаа их байх тусам хувь хүмүүсийн дунд хий хөөрөгдсөн хэрэглээ нэг үгээр хэлбэл хэт “брендсэг үзэл” газар авч нийгэм мөнгөтэй, мөнгөгүй хэсэгт ялгаа ихсэх тусам ихэнхи хүмүүс өөрийнхөө байр суурь хүмүүст хэрхэн үнэлэгдэх, яаж харагдах зэрэгт хэт санаа зовж эхэлдэг байна. Харин баян хэсэг мөнгөтэй нэр нөлөөтэй хүн гэдгээ бусдад харуулж өөрийгөө үнэлүүлэх унасан машин өмссөн зүүснээрээ нэрийн хуудсаа тодорхойлох гэж оролдоно. Энэ давлагаанд нь олон ч хүн чирэгдэж нийгэм даяараа их хэрэглээ, шуналаас үүдэлтэй стресс уур бухимдлаар дүүрч, нийгэм дэхь баян хоосны ялгаа улам гүнзгийрч нийгмийн бүх бүлэгт ямар нэг байдлаар сөргөөр нөлөөлж, нийгмийн эмх замбараагүй байдал, гэмт хэрэгт хөтлөнө.

Дэлхийн зах зээлд манай улсын экспортын гол түүхий эд болох алт, зэс, нүүрсний үнэ өссөн нь эдийн засгийг бага боловч сэргээсэн. Түүхий эд экспортлон олж буй орлого тэгш хуваарилагддаггүй. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй томоохон компани, түүний эздийн халаасанд ордог. Товчхондоо, уул уурхайн компанийн эздийн ашиг өссөн нь нийгэмд орлогын тэгш бус хуваарилалт бий болгосон хэрэг.

Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай улс орон бүрийн баян, ядуугийн ялгаа холддог зовлонтой. Статистикаас жин коэффициентийн хэмжүүр 2010 онд 0.36, 2011 онд 0.37, 2012 онд 0.362 байсныг харж болно. Уул уурхайн өсөлт баян, хоосны ялгааг тэлдгийн баталгаа энэ юм. Эргэн санавал, Монголд энэ жилүүдэд уул уурхайн “тэсрэлт” болж, үүний хүчээр эдийн засаг хоёр оронтой тооноос дээш, бүр 17.3 хувиар өсөж байв. Уул уурхайн орлогыг хүн амд тэгш хуваарилах нэг арга нь эрдэс баялгийг ашиглаж буй компанийн хувьцааг иргэддээ тэгш хүртээх юм. Үүний нэг жишээгээр “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааг иргэн бүрт тараасныг нэрлэж болно. Гэхдээ улстөрчдийн бодлогын алдаанаас шалтгаалаад энэ компанийн хувьцаа эдийн засгийн эргэлтэд орж, иргэдэд үр өгөөжөө өгч эхлээгүй учраас орлогыг тэгш хуваарилахад нөлөөлөхгүй байна.

7.3. БОЛОВСРОЛ МЭРГЭЖИЛ

Бүх шатны сургуульд суралцагчид 2017/2018 оны хичээлийн жилийн эхэнд 1.0 саяд хүрч, өмнөх оноос 27.9 (2.8%) мянгаар нэмэгдэв.

Улсын хэмжээнд 2017/2018 оны хичээлийн жилд 1416 цэцэрлэгт 256.7 мянган хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оноос цэцэрлэгийн тоо 62 (4.6%)-оор, хүүхдийн тоо 13.3 (5.5%) мянгаар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын 798 сургуульд 2017/2018 оны хичээлийн жилд 572.8 мянган сурагч өдрөөр суралцаж байгаа нь өмнөх оноос сургуулийн тоо 20 (2.6%)-оор, суралцагчид 20.8 (3.8%) мянгаар нэмэгдэв.

Их, дээд сургууль, коллежид 155.2 мянган оюутан суралцаж байгаа нь өмнөх оноос 1.9 (1.2%) мянгаар буурсан байна.

Хүн амын бага орлоготой 20 хувийн хүүхдүүд өндөр орлоготой бүлгийн хүүхдийг бодвол ерөнхий боловсролын мэдлэг эзэмших нь 5 дахин бага, дээд сургуульд элсэн суралцах нь бүр 20 дахин бага байна. Хүний хөгжлийн боломж, боловсрол болон эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын энэ харилцан адилгүй байдал тэгш бус байдлыг өсгөж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2018 оны 11 дүгээр сарын эцэст 49.7 хувийг бүрэн дунд, 29.0 хувийг дипломын болон бакалаврын дээд, 6.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 6.0 хувийг суурь, 4.8 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.1 хувийг бага, 1.2 хувийг боловсролгүй, 1.2 хувийг магистр, доктор зэрэгтэй иргэд эзэлж байна.

Ази, Номхон Далайн бүс нутгийн ихэнх улс орнуудтай харьцуулахад Монгол Улс дахь жендэрийн тэгш бус байдал харьцангуй бага байдаг.

Гэсэн хэдий ч жендэрийн тэгш бус байдал байсаар байна. Жендэрийн эрх тэгш байдлын дээрх зөрүүтэй байдал нь дээд боловсрол эзэмшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр, эмэгтэйчүүдийн дийлэнх нь гэрийн дотоод ажил, хүүхэд асрах зэрэг ажлыг хийж байгаа, эмэгтэйчүүд эрчүүдээс өмнө тэтгэвэрт гардаг зэрэг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн нөлөөллөөс болсон гэж үзжээ.

Тухайлбал, эдийн засгийн боломжын хүртээмж, цалин хөлс, бүтээмжийн ялгаатай байдал байгааг зарим судалгаануудаар баримтжуулсан байдаг. Дэлхийн банкны мэдээгээр “Монгол Улс жендэрийн тэгш бус байдлаар дэлхийд 159 орноос 53-т жагсаж байгаа ч олон эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх, ажилд орох боломж нөхцөлүүдийг хязгаарласан саад бэрхшээлтэй тулгарсаар байна”³¹ хэмээн тэмдэглэжээ.

³¹ Perceptions of precariousness : a qualitative study of constraints underlying gender disparities in Mongolia's labor market// <http://documents.worldbank.org/curated/en>

Хөдөлмөрийн зах зээлд оршиж буй жендэрийн тэгш бус байдал нь ажиллах хүчний оролцооны түвшин янз бүр, тэгш бус цалин хөлс, эмэгтэйчүүдэд баталгаагүй албан бус ажил хөдөлмөр эрхлэх хандлага өндөр байгаа зэргээр илэрч байна. Манай улсад эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд боловсролын түвшин илүү байгаа ч эмэгтэйчүүд боловсролоо ашиглаж хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжоор харьцангуй дутмаг байна.

Нийт ажиллагчдын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнхээс 6 пунктээр илүү болсон. Энэ харьцаа цаашид хадгалагдах төлөвтэй. Харин эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч эрэгтэйчүүдийнхээс 1.7 пунктээр доогуур болсон. Гэсэн ч эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж цалингийн ялгаа багасахгүй байна.

2017 оны Үндэсний статистикийн хорооны судалгаагаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын хэмжээнд 955.9 мянган төгрөг, үүнээс эмэгтэйчүүдийнх 846.1 мянган төгрөг, эрэгтэйчүүдийнх 1 сая 67.9 мянган төгрөг, цалингийн зөрүү 221.8 мянган төгрөг болжээ. Энэ зөрүү нь цалингийн хэмжээнээс хамааралтай тэтгэвэр, тэтгэмжид нөлөөлж байна. Тухайлбал, 2016 оны байдлаар эмэгтэйчүүдийн өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдийнхээс 68.4 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар бага байна³².

Цалингийн ялгаа эдийн засгийн салбарын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн статус, зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжсөн, цалин хөлс өндөртэй уул уурхай, барилга, аж үйлдвэр, эрчим хүч, тээвэр ба агуулахын үйлчилгээ, мэдээлэл холбоо зэрэг салбарт эрэгтэйчүүд голлож, бөөний худалдаа, орон сууц, нийтийн аж ахуй, эрүүл мэнд боловсролын үйлчилгээ, хүнсний салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн голлон ажиллаж байгаа бөөний болон жижиглэнгийн худалдаа, хүнсний салбар нь жижиг аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэлт ихтэй учир нийгмийн хамгааллын асуудлууд нь доголдолтой байгаа юм.

“Ганц ч болов гайгүй ажилтан олоод авчих юмсан”. Компанийн захирлууд, хүний нөөцийн мэргэжилтэн, удирдах ажилтан гээд жаахан ч болов юм хийдэг, урагш хардаг хүмүүсийн хүсэл мөрөөдөл, ярианы гол сэдэв энэ. Хүний эрэлд гарсан тэд бие биетэйгээ уулзаж, утасдаж эрэлд хатна. Тэгэхдээ сайн мэргэжилтний эрэлд. Үгүй юм аа гэхэд зөв сэтгэлтэй, шударга нэгний эрэлд гарна. Тэр нь ер олдохгүй. Монголоор дүүрэн их, дээд сургууль. Жилийн жилд төгсгөөд л байдаг. Торго дурдан, костюм зангиа болж, мөнгө

³² Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. 2017 онд

цацаж, хонхны баярыг лонхны баяр болгосон хүмүүс оюутны ширээг орхицгооно. Харин дараа нь Монголоор дүүрэн ажилгүй “дээд мэргэжилтэн”. Өнөөдөр Монгол Улсад 170 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж, тэнд 142411 оюутан сурч байна. Хаврын хаварт тэдний гуравны нэг орчим нь дээд мэргэжлийн диплом өвөртөлдөг. Гэтэл ажил олгогчид яагаад ажилтан хайгаад байна вэ.

Нэгэн сэтгүүлчийн тэмдэглэсэнчлэн боловсролын тогтолцоо гажуудаж, чанаргүй их, дээд сургуулийн тоо хэтэрснээс ажил хийх чадваргүй, дарга болохын хэнээ туссан залуус Монголоор дүүрчээ. Тэр: “Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй гэдэг үгийн биелэл улс орныг авч явах гол хүчин, хүний нөөцийн гүн хямралаар ийнхүү илэрч байна. Хүн болгон дарга болохыг, зүгээр сууж байгаад баяжихын дон шүглэсэн нь өнөөдрийн дүр зураг. Ажил хийж чаддаггүй юм аа гэхэд зөв сэтгэлтэй, эвдэрч, хүнээ байчихаагүй, итгэж болох хүнийг эрээд ч олохгүй болсон нь Монголын эмгэнэл. Бид хүний нөөцийн хямралын дүр зургийг гаргахын тулд олон ч хүнтэй уулзаж, олон ч газраар орсон. Ингэж явахад Монголын топ гэгдэх том компаниуд хүний нөөцийн асуудлаа бүрэн шийдэж чадсандаа, бүх зүйл нь “ОК” болсондоо ингэж томорчихсон юм биш, авилгын хүчээр аливаа тендрийг авч, төрийн машинийг өөрийн компанийн эрх ашгийн төлөө ажиллуулж чаддаг тулдаа “томорчихсон” мэт харагдаж байгаа юм гэх хүн олон таарч байлаа”³³ гэжээ.

Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн албанд гэхэд гурван жилийн хугацаанд 62 мянган хүн хандаж, ажилд орох болон авах тухай мэдээлэл лавлагаа авсан байна. Тэдний есөн мянга нь ажилд орохыг хүсч байгаагаа анкетаар мэдэгдсэн гэнэ. Зөвхөн энэ албанд долоо хоногтоо 70-80 хүн ажил хайж ханддаг ч мөн л дээрх ажлын чадвар, туршлагагүй байдлаасаа болж ажил олгогч нарт гологдох нь их юм байна.

5.4. ЭРХ МЭДЭЛ, НЭР ХҮНДИЙН ЯЛГАА

Эрх мэдэл эрчүүдийн гарт төвлөрч эд баялаг тэдний эрх мэдлийг бэхжүүлэхийн төлөө үйлчилдэг улс оронд эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах бичигдээгүй хууль үйлчилдэг. Эмэгтэйчүүдийн бие даасан байдал, шийдвэр гаргах, сонгох эрх мэдэл эрчүүдтэй эн тэнцүү байх, түүнчлэн өрх гэрт эмэгтэйчүүдийн оруулж буй орлого нэмэгдэх зэрэг нь тухайн улсын хүүхэд багачууд, боловсролын салбарт давхар хөрөнгө оруулалт болох төдийгүй цалин өссөнөөр эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал

³³ Мөнхтуяа Ё. Хүний нөөцийн хямрал// <http://tsagtur.mn/>. 2009-09-01-04-10-31

нэмэгдэж, нийгэм дэх хүйсийн тэнцвэргүй байдал буурахад нөлөөлдөг байна. Түүнчлэн технологи хурдацтай хөгжсөнөөр эмэгтэйчүүдийн үнэ төлбөргүй хийдэг /гэрийн ажил/ олон ажлыг орлох болжээ.

2017 оны Монголын Эмэгтэйчүүдийн сангаас хийсэн судалгаанд “Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл”-ээс Монгол Улсын нийт хүн амын 51.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа тухай судалгаа танилцуулав. Тус байгууллагаас ажлын байрны бэлгийн дарамтын талаар 705 эмэгтэйн дунд судалгаа явуулахад 79.6 хувь нь “ажлын байрны бэлгийн дарамт их байдаг” гэжээ. ТББ-ууд бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцох тухай заалтыг оруулахаар нөлөөллийн ажил хийсэн ч шинэ Эрүүгийн хуульд энэ нь тусгалаа олоогүй. Зүй бусаар биеэ авч явах гэж чухам юуг хэлэх талаар нийгэмд нэгдсэн ойлголт байхгүй байгаагаас уг асуудлын бодит цар хүрээг тогтооход бэрхшээл үүсгэж байна гэж ТББ-ууд үзэж байна³⁴.

Эрчүүдийн хувьд эмэгтэйчүүдийг эрх тэгш субъект гэж үзэхээсээ илүү хэрэглээ гэж үзэх хандлага хэвээр хадгалагдсаар байна. Монголын Эмэгтэйчүүдийн сангаас Хөдөлмөрийн тухай хуульд ажлын байрны бэлгийн дарамтыг хориглох, хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон заалт оруулах, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн эмэгтэйг хамгаалах, хохирол барагдуулах талаар нэгдсэн дүрэм, журамтай болох хэрэгтэй гэсэн дүгнэлт гаргасан байна³⁵.

Гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын чанар, эрүүл мэндийн асуудлыг жендэрийн өнцгөөс авч үзэх шаардлагатай байна. 2017 онд гэр бүлийн хүчирхийлэлд 1120 иргэн өртөсний 92.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн амиа хорлолт эмэгтэйчүүдийнхээс 5.5 дахин, хүчирхийлэл үйлдэх хандлага 3.6 дахин, зам тээврийн осолд өртөх тохиолдол 3.4 дахин өндөр байна³⁶.

7.5. УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

“Таны хүссэн бүхнийг хангаж чадахуйц томорсон төр таньд байгаа үнэтэй бүхнийг булааж чадахаар хүчтэй болдог” хэмээн АНУ-ын Ерөнхийлөгч Томас Жефферсон 200-гаад жилийн өмнө хариулсан байдаг. Юунаас ч сольшгүй үнэтэй тэр зүйл бол эрх чөлөө юм. Эрх, эрх чөлөөний зөрчлийн ард шударга ёс алдагдаж байдаг. Шударга ёсыг хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагын ил тод байдал, засаглалыг сайжруулах шаардлага гардаг.

³⁴ Монгол Улсын 2017 оны Хүний Эрхийн Тайлан

³⁵ <http://www.olloo.mn/n/49403.html>

³⁶ Чинзориг С., Жендэрийн тэгш байдлыг хангах нь хөгжлийн үндсэн түлхүүр//<http://www.mlsp.gov.mn/nnews/242>

Монгол Улс ардчиллын чиг баримжааг сонгосон цагаас эхлэн УИХ-ын 7 удаа, орон нутгийн сонгууль болон ерөнхийлөгчийн сонгуулийг 6 удаа амжилттай зохион байгуулаад байна. Манай улсад 2016 оны 3 дугаар сард 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо 11 байсан бөгөөд энэхүү үзүүлэлтээрээ дэлхийд 95-д жагсаж байв. Харин 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь парламентын гишүүдийн 17 хувийг эзэлж байна.

Монгол Улс нь Үндсэн хууль болон бусад салбар хуулиуд, үндэсний хэмжээний хөтөлбөрүүд зэрэг баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах талаар тодорхой алхамуудыг авч чадсан сайн талтай.

Сүүлийн хоёр сонгуулийн статистикийг харвал 2008 онд 356 нэр дэвшигчийн 66 нь эмэгтэй байж 3 нь, 2012 онд 544 нэр дэвшигчийн 174 нь эмэгтэй байж үүнээс 11 нь сонгогдож байсан. Харин саяхан болж өнгөрсөн УИХ-ын сонгуульд 498 хүн нэр дэвшиж өрсөлдсөнөөс 129 нь эмэгтэй нэр дэвшигч байлаа. Сонгуулийн болон бусад хуулинд жендэрийн квот тогтоож өгсөн нь (“Сонгуулийн хуулийн 126.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.”) үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг мэдэгдэхүйц түвшинд нэмэгдүүлж, богино хугацаанд хэрхэн хурдтай ажиллаж, үр дүнд хүрч болохыг харуулсан үйл явдал болсон юм.

Олон улсын байгууллагын өөр эх сурвалжийн үзсэнээр дээрх хурдан хугацаанд үр дүн авчрах бодлогоос гадна өндөр дээд түвшинд төрийн алба хашиж байгаа эрэгтэй удирдлагууд авилга, хээл хахуулын хэрэгт холбогдох нь ихсэж, иргэдийн итгэл найдварыг алдах болсон нь найдвартай, зарчимч, эмэгтэй удирдагч, улс төрчдөд итгэх нөхцөлийг бүрдүүлж, сонгуулиар дээр дурдсан эерэг үр дүнг авчирсан байна.

Гэсэн ч үзэл баримтлалын³⁷ хямралд орсон, зөвхөн сонгогчдод таалагдсан, эсхүл өөрсдийнхөө төлөө “сонгуулийн шархаа нөхөх” бодлого баримталж буй “төрийн түшээд” эмэгтэйчүүдийн улс төрийн гүйцэтгэх үүрэгт саад болох төдийгүй, тэднийг энээндээ нэгтгэн авах бодлого нь амжилттай хэрэгжиж байна.

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд төр засгийн эрх мэдэл ард түмний гарт бүрэн шилжинэ, төр засаг нь нийтийн сонирхлыг илэрхийлсэн шийдвэрүүд гаргаж, эдийн засаг зах зээлийн механизмаар ажиллах ардчилсан нийгмийг бий болно гэж ард түмэн итгэж байлаа.

Гэтэл сонгуулиас сонгуульд эрх мэдлийн хуваарилалт тэгш бус болсоор төрийн эрх мэдэл иргэдийн биш, улс төрийн намуудын удирдлагын гарт төвлөрсөөр

³⁷ Тодорхой үзэл санаа, түүний зарчим, үнэт зүйлсийг системтэй мэдлэг болгосныг үзэл баримтлал (Concept) гэнэ.

байна. Эдүгээ сонгуульд ялсан улс төрийн намын дарга улс төрийн хэмжээлшгүй их эрх мэдэлтэй болов.

Тэр хүн төр засгийн бүх эрх мэдлийг өөрийн намыг санхүүжүүлсэн, сонгуулийн зардлыг төлсөн бизнесийн бүлэглэлд үйлчлэхэд чиглүүлж, төр засгийн бараг бүх албан тушаал, төсвийн санхүүжилттэй төслүүдийг хэрэгжүүлэх, төр засгийн худалдан авалтыг арилжааны хэлбэрт шилжүүлээд байна.

Клиентализм гэдэг нь энгийнээр бол төр нийгэмтэй үйлчлэгч үйлчлүүлэгчийн харилцаа үүсгэхээ болиод эдийн засгийн гол тоглогчидтой харилцан үйлчлүүлэгчийн шинжтэй харилцаатай болохыг хэлдэг. Тодруулбал намуудыг сонгуульд ялалт байгуулж, цар хүрээгээ тэлэхэд бизнесийнхэн далд маягаар бизнесийн дэмжлэг үзүүлж, хариуд нь өөрсөддөө ашигтай шийдвэр гаргах, хууль батлуулах зэргээр “харилцан ашигтай” наймаа хийдэг байна. Логикийн дагуу үүсч буй эхний гаргалгаа бол нийгэмд үйлчлэх субъект үгүй болж, нийгмийн ашиг сонирхол орхигдож эхэлнэ. Хоёрдугаарт, улс төрийн нам бизнесийн бүлэглэлүүдтэй харилцан түншийн чиг үүрэгтэй харилцсанаар үндсэн чиг үүргээсээ хазайж, өвөрмөц бизнесийн байгууллага болон хувирч байна.

Клиентализм амжилт олсон шалтгаан бол социалист орнуудад том хэмжээтэй нэг намын тогтолцоо, соёл тухайн нийгэмд хүчтэй төлөвшсөн байдагтай холбоотой. Улс орон даяар нам хэмээх байгууллагыг олон гишүүнтэй байх ёстой, гишүүд нь төрийн алба хашдаг гэсэн хэвшмэл ойлголттой байдаг. Энэ нь улс төрийн намуудыг массын шинжтэй, төрийн албыг нүсэр хэмжээтэй байлгахад хөшүүрэг болно. Нам олон гишүүнтэй байх тусам сонгуульд ялах магадлал нь ихэсч, тэр хэрээрээ “хувьчлагдах аюул” нэртэй завшаанд өртөх нь түгээмэл аж. Санхүүгийн далд эх сурвалжууд намын удирдлагыг дээрээс нь хувьчилж, доороос нь гишүүдээ ажлын байраар хангах, цалинжуулах замаар колоничилно. Ийм үед иргэний нийгмийн байгууллагууд ажиллах боломж байтугай сонгууль шударга явагдах аргагүй. Тогтвортой орлогын эх үүсвэрээр “тэжээдэг” гишүүдийн тоогоороо саналын олонхийг авах хүчин чадал сайтай байгууллагууд л сонгуульд ялалт байгуулж, төрийн эрх мэдлийг авах, цаашлаад өөрсдийн бий болгосон нүсэр төрийн албыг орон тоогоор нь хангах чадамжтай байна .

Төрийн эрх баригчид, томоохон бизнес эрхлэгчдийн хоорондын холбоо нягтрахын хэрээр Монголын нийгмийн бүхий л харилцаа бурангуй, ялзарсан зарчмаар явагдах нь ихэсч, нийгмийн дундаж давхарга хавчигдсаар, ядуусын эгнээ эрчимтэй тэлж, улс төрд популизм, хэт үндсэрхэг үзэл зэрэг сөрөг үзэгдэл газар авч байна.

Ерөнхий сайд Хүрэлсүх: “Ард түмнийхээ хүсэл бодол, итгэл үнэмшил, хүлээлтийг сонсож мэдэрч, тэрэнд нь тохирсон арга хэмжээ авч чаддаггүй улс төрийн хүчин мухардалд ордог. Олон өөрчлөлтийг цаг алдалгүй хийхгүй бол бидэнд цаашид цаг, хугацаа алга. Хөрөнгөтэй, мөнгөтэй, бяртай, чадалтай хүмүүс энэ намын удирдлагын толгойд гарчихсан байна” гэж үүнийг хүлээн зөвшөөрсөн . Тэрбээр: “Ерөнхий сайд Хүрэлсүх: “Манай нам олигархжсан байна. Манай нам мафижсан байна. Манай нам сүүлийн үед компаничлагдсан байна. Хөрөнгөтэй, мөнгөтэй, бяртай, чадалтай хүмүүс энэ намын толгойд гарч, цаашилбал улсыг удирдах, газрын хэвлийн охь баялгийг хэдэн гэр бүлээр дамжуулан цөлмөж авах, түүгээрээ улбаалан Монгол төрийн толгойд залрах гэсэн оролдлогууд хийгдэж, хэрэгжиж байна. Тиймээс Монголын ард түмэн тэднийг МАНАН гэж ярьж байна. Би намын дарга, Ерөнхий сайдаар томилогдсон цагаасаа хойш МАНАН үнэхээр бодитой байдаг юм байна гэдгийг нүдээрээ харж, биеэрээ мэдэрсэн.. Тиймээс бид МАНАН-г таслан зогсоох ёстой. Тэрхүү шударга бусын хонгил, ард түмний нэрлээд байгаа хонгилыг бид эвдэж, нураах цаг нь болсон. Ардын нам ард түмэн дотроо байдаг, ард түмнийхээ хүсэл, бодол, тэмүүлэл, мөрөөдлийг сонсдог, түүнд нь тохирсон үйл ажиллагаа явуулдаг нам байх ёстой. Тэгэхгүй бол манай нам цөөн хэдэн нам дамжсан бүлэглэлийн гарт орсон, ийм улс төрийн хүчин болох гэж байна. Үүнийг таслан зогсоох ёстой” гэжээ.

Ерөнхий сайд асан Бямбасүрэн гуай: “Улс орны ахуй амьдралын гол асуудал болсон 2019 оны Улсын төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэх явцад УИХ-ын гишүүд төсвийн хөрөнгийг хувааж халааслах төсөл хийж, тусгай зориулалттай /ЖДҮД/ сангийн хөрөнгөд олон эрх мэдэлтэн гар дүрсэн асуудал сөхөгдсөн нь төрийн албыг 60 тэрбумаар наймаалсан зэрэг нийгмийн сэтгэлийг эмзэглүүлсэн бусармаг явдлууд хуримтлагдсан нүглийн савыг дүүргэжээ” гэжээ.

Манай орон олон намын тогтолцоо бүхий хүмүүнлэг ардчилсан нийгэмд шилжээд 27 жил болж байгаа боловч орчин үеийн улс төрийн намын шалгуурыг хангах хэмжээнд төлөвшиж чадаагүй л байна. Гэтэл орчин үед намын уламжлалт хэлбэрүүд үеэ өнгөрөөх болж оронд нь “өргөн хүрээний” нам (catch-all party), “картель” (cartel party) буюу хоршсон намын хэлбэр идэвхтэй гарч ирэн, “намуудын хувьд бүгдийг хамарсан буюу “catch all” юмуу хоршсон намын хэлбэр болох картел загварт шилжих шилжилт эрчимтэй явагдаж байна³⁸

Картель загварын намууд зарчмын асуудлуудаар үгсэн тохирч нэгдсэн байр суурьтай байдаг ч улс төрийн бялууны төлөө хоорондоо өрсөлддөг байна. “Улс төрийн

³⁸ Баасансүрэн Д., Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт//

тавцанд хамтран оршин тогтнох нэгдмэл сонирхолтой гэдгээ хүлээн зөвшөөрдөг боловч эрх мэдлээс ахиухан хүртэхийг эрмэлзэн өрсөлддөг” гэжээ³⁹.

Монгол Улсад төр засгийн эрх мэдлийг хоёр нам (МАНАН) эвсэн болон ээлжлэн эрх барьсан он жилүүдэд энэ хоёр намыг дагасан, тэднийг санхүүжүүлдэг бүх компаниуд хөнгөлттэй зээл авч, хямд өртгөөр бизнесээ явуулах болсноор эдийн засгийн чөлөөт өрсөлдөөний үзэл санааг үндсэнд нь устгаад байна. Иргэд бүхий л чадлаа бизнес хийж өрсөлдөхийн оронд төрийн албанд орж “бялуу” хуваалтаас хүртэхийг чармайдаг болсон.

Эрх мэдлийн төлөө их хэмжээний хөрөнгө, мөнгө зарцуулж гарч ирсэн бол эргээд зарцуулсан хөрөнгөө хэд дахин үржүүлэн олж авахын төлөө бизнесийн компани аж ахуйн нэгжид ашигтай хууль, шийдвэр гаргах, ийм шийдвэр гаргуулахаар лоббидох, үүнтэй холбоотойгоор улс төрийн хямрал нүүрлэж байна.

Сүүлийн жилүүдэд сонгуулийн явц харьцангуй ил тод болсноор, санал тоолох үед булхай хийх боломж эрс багасаж, улмаар улс төрийн намуудад ард түмэн хариуцлага тооцох боломж олдож байгаа ч шударга бус үйлдэл улам гаарч байна.

Манайд улс төрийн системийн хямрал даамжирч улмаар системийн задрал болон хувирч байгааг хүн болгон мэдэж, мэдэрч байгаа. Энэ нь Үндсэн Хуулийн суурь зарчим алдагдаж Парламент нэрийн төдий болсон, засгийн эрх цөөн хүний мэдэлд бүрэн орсон, улс төрийн намуудын нийгмийн үүрэг суларч задрал эхэлсэн, төрийн болон нийгмийн удирдлага алдагдсан, үндэсний аюулгүй байдал алдарсан зэрэг олон гажуудлаар илэрч байна.

Шударга бус үйлдэл ямар ч шийтгэлгүй өнгөрч, гэмт хэрэгтнүүд олноор өршөөгдөх, ял завших болсноор иргэд төр засаг шударга ёсыг тогтоож чадна гэдэгт улам бүр итгэл алдарч байна. Хууль бус орчин нөхцөл газар авч, шүүх засаглал шударга ёсыг сахин хамгаалж чадна гэдэгт иргэд эргэлзэх боллоо гэж зарим судлаачид⁴⁰ үзэж байна.

Засгийн газар ч гэсэн гадаад, дотоодод бонд гаргаж өр зээл тавихдаа, эргэн төлөлтийг дараагийн засаг нь хариуцахаар тооцдог болжээ. Төр засгийн бүхий л үйл ажиллагааг сонгуулийн дөрвөн жилээс цааш хэтрэн харахаа больжээ.

Энэ бүхэн нь нийгмийн тодорхой бүлэг, давхрагын эрх ашгийг илэрхийлэн хамгаалах улс төрийн намуудын үүрэг XXI зуунд гээгддэг бодит хандлага ажиглагдаж байна. Нийгмийн янз бүрийн бүлэг давхрагын ашиг сонирхлыг илэрхийлэгч иргэний

³⁹Үзнэ үү.: Katz, R. Canding Models of Party Organization and Party Democracy: The Emergence of Cartel Party/ R.Katz, P.Mair // Party Politics.-1995.-Vol.1, №1.-P.5-28

⁴⁰ Жаргалсайхан Д., Монголын нийгмийн бас нэг сорилт: улс төр//<http://jargaldefacto.com/article/>

нийгмийн байгууллагууд улс төрийн намуудын уламжлалт үүргүүдийн орон гүйцэтгэх болсон нь шинэ зууны шинэ хандлага болж байна.

Улс төрийн соёл гэж олон түмний зүгээс улс төрийн үзэгдэл үйл явцын талаар өгч байгаа үнэлэмж, дүгнэлт, төрийн албан тушаалтны үйл ажиллагааны талаарх байр суурь, санаа бодол, итгэл үнэмшил, хүмүүсийн эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс зэргийн нийлбэр цогц, нийт үндэстний соёлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

Улстөрч хүний эзэмших ёстой нэг чухал чанар болсон улс төрийн соёл. Уучлалт гуйчихдаг, өөрийнхөө бурууг ойлгодог, сандал суудалтай зууралдах бус ард түмний төөөлөл гэдгээ ухамсарладаг байх чадвар манай улс төрчдөд үгүйлэгдэж байна. Ардчиллын хамгийн бодитой хэмжүүр нь улс төрийн соёлын төлөвшил мөн.

Авлигын үзүүлэлтээр манай орон дэлхийн 176 орноос 88-р байр эзлэн, 100 онооноос 39 дээр гацаад 4 жил болж байна. Төр засгийн хамгийн чухал албан тушаал дээр намдаа хамгийн их мөнгө тушаасан хүмүүс очдог болж, улмаар өөрийн хамаатан садан, анд нөхөд, нутгийн найз нараараа очсон байгууллагаа дүүргэж байна. Жишээ нь Гадаад харилцааны яам бөгөөд гадаадад байгаа элчин сайдын яам, консул төлөөлөгчийн газруудад ажиллуулахаар, төр солигдмогц явуулж буй хүмүүс бол монголын авлигын жинхэнэ толь нь юм. Энэ яаманд ажилчин, ажилтнуудын боловсрол, мэргэжил чадвар нь биш, аль даргын “шахаа” нь чухал болсон жишиг тогтоод удаж байна.

Авлигал бол улс төрийн эрх мэдлийн хамгийн том саад бэрхшээл бөгөөд хөгжиж буй орнууд энэ бэрхшээлийг даван туулж чадахгүй байгаа учраас улс оронд нь тогтворгүй байдал бий болж, иргэд нь талцан, авлигачдын хараат хэвлэл мэдээллийн турхиралтаас үүдэлтэй эмх замбараагүй байдал үүсэн, хөгжил нь зогсож, улс орон нь ядуурдаг ажээ.

Авлига нь нийгмийн системийн баялаг, мэдлэг үйлдвэрлэх, хуваарилах бүтцийн доголдол гарснаас бий болдог. Авлигыг хазаарлаж, зогсоож чадахгүй байгаа нь манай нийгмийн зохион байгуулалт өөрөө тийм чадваргүй болсныг харуулж байна. Авлигал нь хүнд сурталтай, эрүүл бус нийгмийн зохион байгуулалтын илрэл юм. Энэ саадыг бий болгосон хүмүүс авлигын үр шимийг сорж амьдардаг учир түүнийг арилгах сонирхол огтхон ч байдаггүй ажээ⁴¹.

⁴¹ Мөн тэнд үзнэ үү.: //http://jargaldefacto.com/article/

7.6. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Ядуурал, ажилгүйдэл, нийгмийн тэгш бус байдал зэрэг эдийн засгийн хүчин зүйлүүдийг бүр эртнээс гэмт явдлын нэг нөхцөл шалтгаан болгон авч үзэж иржээ. Энэ нь нийгмийн эдийн засгийн бүтэц, гэмт явдлын төрлүүдийн хоорондын уялдаа холбоо, онолын болон прагматик судалгаа, статистикийн мэдээллээр давхар нотлогддог.

“Эдийн засаг болон гэмт явдал” сэдвээр дагнан оролддог судлаачид ядуурал, гуйланчлал, ажилгүйдэл зэрэг нь гэмт явдал, зан үйлийн гажуудлын шалтгаан гэж үзэж, өөр хоорондоо зөрчилтэй үр дүнд хүрч байсан бол сүүлийн үед харьцангуй депривацийн үзэл баримтлалд тулгуурласан шинжилгээ судалгаа илүү найдвар төрүүлж байгаа юм.

Харьцангуй деприваци гэдэг нь субъектив ойлголт дахь нийгмийн хавчилт, хяхалтын хүчин зүйлүүдийн нийлбэр мөн. 1982 онд америкийн Блау зэрэг судлаачид хүч хэрэглэсэн гэмт хэрэг болон харьцангуй депривацийн хоорондын уялдаа холбооны шинж чанарыг тогтоож, харьцангуй деприваци нь эдийн засгийн шинж чанартай гэмт хэрэгт ч гэсэн ач холбогдолтой гэдгийг тогтоосон байна.

Хөрөнгөт нийгэм дэх хөдөлмөрийн зах зээлийн ялгаварлан шоовдорлосон шинж чанар, мөн нийгмийн ангийн бүтэц нь харьцангуй депривацийн хувьд “илүүдэл хүмүүс”-ийг үйлдвэрлэдэг байна. Хүн амын эдгээр хэсэг нь архаг ядуурал, ажилгүйдлийг үүсгэнэ. Үүнтэй холбоотойгоор ядуурлын шалгаан болсон амьдралын нөхцөлийн үр дүнд харгис хэрцгий, архаг, гажуудсан зан үйл нь үүсч бий болдог байна. Зан үйлийн гажуудал ингэж тайлбарлагдаад зогсохгүй, мөн орлогын тэгш бус хуваарилалтын асуудлыг тухайн этгээд яаж хүлээн авахаас шалтгаалдаг байна.

Эдийн засгийн эмзэг байдлын таван секторын нэг нь нийгмийн эмзэг байдал юм. Нийгмийн эмзэг байдал дөрвөн үзүүлэлттэй. Эхнийх нь орлогын тэгш бус байдал. Хоёрдугаарт ажилгүйдэл. Гурав дахь нь ядуурлын түвшин. Монгол Улсад энэ үзүүлэлт өнгөрсөн онд 21.6 хувьтай тэнцэж байлаа. Харьцангуй бага гэж үзэж байв. Манай улсын хүн амын ядуурлын түвшин хамгийн сүүлийн судалгаагаар 29.6 хувь болж, нийт хүн амын 907.5 мянга нь ядуу ангилалд багтсан. Энэ нь гурван сая гаруй хүн амтай манай улсын хувьд гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.

Ядуурлын салшгүй нэг хэсэг бол ажилгүйдэл. Монгол Улсад 2017 оны хагас жилийн байдлаар 15, түүнээс дээш насны хүн амын 854.8 (38.4%) мянга нь эдийн

засгийн идэвхгүй хүн ам3 байгаа бөгөөд 343.2 мянга нь эрэгтэйчүүд, 511.6 мянга нь эмэгтэйчүүд байна⁴².

Ажилгүйдлийн түвшин 2016 онд 8.6 хувь байсан бол 2017 оны эцсийн улиралд буурч 7.3 хувьд хүрсэн. Тэгвэл хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 11 дүгээр сарын эцэст 35.3 мянга, үүнээс 24.2 (68.6%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.1 (31.4%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 12.8 (52.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 2017 оны 6.4 хувийн өсөлтөд хүнсний бараа, ундаа, усны бүлэг 1.8 пункт буюу 27.9 хувь, тээврийн бүлэг 1.5 пункт буюу 22.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлэг 0.7 пункт буюу 11.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.7 пункт буюу 11.0 хувийг эзэлсэн байна.

Орлогын тэгш бус хуваарилалтын талаар бид сүүлийн жилүүдэд их ярих боллоо. Баян нь хэт баяжиж, ядуу нь ядуураад байгаа тухай яриа шүү дээ. Өнгөрсөн онд энэ үзүүлэлт 0.31 байв. Энэ жил 0.36 болж өссөн байна.

Америк долларын ханш 1981 онд 2 төгрөг 90 мөнгө, 1990 онд-40 төгрөг, 2000 онд 1076 төгрөг 47 мөнгө, 2017 онд 2440 төгрөг болон өсчээ. Төгрөгийн америк доллартай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 11 дүгээр сард 2 581.88 төгрөг болжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.8 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 7.5 хувь, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.6 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 23.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 7.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.2 хувь (мах, махан бүтээгдэхүүн 20.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

⁴² <http://1212.mn/BookLibrary>

Гэмт явдалд хамтаар хохирох явдлын нэг хүчин зүйл бол улс төр-эдийн засаг сүлбэлдэж, авилга хээл хахууль цэцэглэн хөгжих явдал мөн. Тухайлбал, манайд нэгэнт бий болсон “саарал эдийн засаг” нь өөрийн байнгын тасралтгүй ажиллагаагаа хангаж байхын тулд төрийн түшмэдүүдийг татан оролцуулж, түүний “дээвэрт хоргодох” зорилгоор авилгал-лоббийн холбоог өргөжүүлж байна. Зарим хэвлэлд бичсэнээр “мөнгөтэй эрх мэдэлгүй хүн, эрх мэдэлтэй мөнгөгүй хүн” хоёрын засаглал тогтож, жирийн ард түмний нуруун дээр асар их ачааг үүрүүлж, хохирох явдлыг улам нэмэгдүүлсээр байна. Авилга авах, өгөх гэдэг нь “амьдралын хэрэгцээ” (мансууруулах бодис), зарим тохиолдолд “зайлшгүй байдал” (хорт хавдар) болон хувирч байна.

Статистикийн бизнес регистрийн санд 2017 оны эцсийн байдлаар 155.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 78.6 (50.7%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 11 дүгээр сарын эцэст 16.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 263.1 (1.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.2 (23.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 11 дүгээр сарын эцэст 974.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 70.1 (6.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 80.2 (9.0%) тэрбум төгрөгөөр өсжээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны 11 дүгээр сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 106.6 (5.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 911.0 (78.8%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 12.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 3.8 пунктээр өссөн байна.

Эмэгтэйчүүдийг ажилтай орлоготой байхыг дэмжсэнээрээ гэр бүлийн хүчирхийллийг шийдэх талтай. Манай улсад эрэгтэйчүүд цалин өндөртэй, эмэгтэйчүүд цалин багатай ажил хийж байна. Ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн дундаж цалин ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. 2015 онд эрэгтэйчүүд дунджаар сард 856,000 төгрөгийн цалин авч байсан бол эмэгтэйчүүд 760,700 төгрөг авч байсан байна. Эмэгтэйчүүдийн олонх нь, ялангуяа хөдөө орон нутагт, баталгаагүй албан бус салбарт болон цалин хөлсгүй гэрийн ажил эрхэлдэг ба бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс хавьгүй доогуур байна. Олон ажиллагсад ажлын байрны тогтвортой бус байдал, цалин хөлс нь баталгаатай биш, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн тогтолцоонд хамрагдаж чаддаггүй.

7.7. СОЁЛ, ЁС СУРТАХУУН, ҮЗЭЛ СУРТАЛ

Ёс зүй бол хүний зөв амьдрахуйн тухай ухаан юм. Нийгмийн амьдралын бүх салбар хүрэн дахь үйл ажиллагаа хүний үнэт зүйлс ч ёс суртахууны хэм хэмжээнээс ангид байх боломжгүй. Ёс зүй гэдэг бол хүмүүс бид өөр бусад болон өөрөө өөртөө хэрхэн хандаж биеэ авч явахыг системтээгээр судлах, мөн түүнчлэн хүмүүсийн ямар зан чанар ба харилцааны ямар хэв маяг эрхэм сайн бөгөөд үлгэр дууриалал болох ямар нь муу муухай бөгөөд буруу шаан шүүмжлэж засч залруулж байвал зохихыг судлаж тодорхойлдог ухаан. Эрх чөлөөтэй хүн л ёс зүйтэй байж чадна. Эрх чөлөө бол боломж төдийгүй бас сонголт юм. Эрх чөлөөтэй хүн сонголт хийж чаддаг. Сонголт хийх эрх чөлөө хувь хүнд ажил хөдөлмөр эрхлэх, бизнесийн сонголтыг хийх олон боломжийг олгодог. Эрх чөлөөтэй иргэн бүтээж чаддаг учраас эргээд нийгмийн баялаг үйлдвэрлэхэд хувь нэмрээ оруулж эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлдэг. Эрх чөлөө бол хүмүүст өөрийгөө өөрчлөх, хөгжүүлэх боломжийг авчирдаг төдийгүй нийгэмдээ нөлөөлж хөгжүүлэх боломжийг бий болгодог.

Монголын улс төр, засаг төр улс төрчдийнхөө ёс суртахууны ялзрал, доройтолд туйлдаа хүртэл нэрвэгдчихсэнтэй холбоотой. Улстөрчид нь ёс суртахууныг уландаа гишгэнэ гэдэг тухайн улсад хөгжлийн тухай, шударга ёсны тухай ярих боломжгүй.

Манай залуучуудын ёс суртахууны хариуцлагагүй байдлын шалтгаан нь:1) ёс суртахууны гажуудлыг тэтгэсэн боловсролын тогтолцоо; 2) төрийн удирдлага, түүний зохион байгуулалт; 3) байгууллага, хамт олон болон хувь хүний идэвх оролцоо сул;4) үндэсний уламжлал, ёс суртахууны үнэт зүйлс гээгдсэн; 5) гэр бүлийн болон мэргэжлийн ёс зүйн уналт; 6) ядуурал; 7) нийгмийн хяналтын гажуудал зэрэг олон зүйлтэй холбоотой

Академич С.Нарангэрэл: “Үйлийн үр, ёс суртахууны хариуцлага хуулийн хариуцлагаас ч хатуу. Өнөөдөр манай улсын хөгжил дэвшилд хамгийн том тээг садаа болж буй зүйл нь мөнгөний гачигдал бус, өөрсдийн маань ёс суртахууны доройтол юм. Жишээ нь, монголчуудын нэгнээ хуурч мэхлэх, бие биедээ итгэл алдрах явдал тамтгаа алдлаа”⁴³ гэжээ. Ийм ч учраас хууль бол хуульчлагдсан ёс зүй мөн.

2016 оны сонгуульд АН-аас Баян-Өлгийд нэр дэвшин гарч ирсэн Д.Мурат эмэгтэй хүнийг гутаан доромжилж, ёс бус харьцан, хүчирхийлсэн хэрэт хутгалдав бололтой. Тодруулбал, Д.Мурат нь орон нутагтаа төрийн албанд ажилладаг нэгэн бүсгүйд хувийн дотно харилцаанд орох санал удаа дараа тавьсан тухай бичлэг, зураг хөрөг, захидал

⁴³ Нарангэрэл С., Монголын хөгжлийн хамгийн том тээг нь бидний ёс суртахууны доройтол// <https://www.facebook.com/Mongolianlawsociety/>

мессеж нь сүүлийн үед олон нийтийн сүлжээгээр цацагдах болж, Баянзүрх дүүргийн эрүүгийн анхан шатны шүүхээс Д.Мурат, М.Елузаг нарын хэргийг хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгасан, мөн УИХ-ын гишүүн Д.Гантулга 2017 оны зургадугаар сарын 12-нд Ч.Наранзаяа гэх бүсгүйг хүчиндсэн хэрэгт холбогдож, Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст шалгагдаж улмаар бүрэн эрхээсээ татгалзсан зэрэг нь хүчиндэх, бэлгийн дарамт үзүүлэх, эмэгтэй хүний бэлгийн халдашгүй байдлыг хөндсөн ёс суртахууны доголдол гэж үзэх ёс суртахууны үндэстэй.

Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 5092 (18.7%)-оор өсжээ. Өмнөх оноос нийт гэмт хэрэг өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4840 (36.3%), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 (49.2%)-өөр өссөн нь голлон нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 онд 198.1 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 74.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 35.2 (21.6%) тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 30.5 (69.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2017 онд 37.2 мянга болж, 1758 (4.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 18.1 мянга (48.8%) нь эмэгтэйчүүд байна.

Харин улсын хэмжээнд 2018 оны эхний 11 сард 33.9 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3(14.6%) мянгаар өсжээ. Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг өсөхөд залилах гэмт хэрэг 2197 (83.2 %), хулгайн гэмт хэрэг 757 (6.9%), дээрмийн гэмт хэрэг 397 (37.1%), хөрөнгө завших гэмт хэрэг 181 (56.9%), хүчингийн гэмт хэрэг 123 (34.1%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 490 (6.1%)-ээр өссөн нь голлон нөлөөлөв. Харин бүртгэгдсэн гэмт хэрэг 2018 оны 11 дүгээр сард 3.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 84 (2.3%)-өөр өсөж, харин өмнөх сараас 867 (19.0%)-оор буурсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 11 сард 167.6 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 28.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 24.1 (12.6%) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 43.3 (60.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 2018 оны эхний 11 сард 8.4 мянган хүн гэмтэж, 931 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 1167 (12.2%), нас барсан хүн 394 (29.7%)-оор буурсан байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2018 оны эхний 11 сард 30.6 мянга болж, 1.5 мянга (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 13.3 мянга (43.5%) нь эмэгтэйчүүд байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард 3.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 959 (24.5%)-өөр, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 1621 болж, 961 (37.2%)-ээр, хүүхэд оролцсон хэрэг 674 болж, 154 (18.6%)-өөр буурч, харин эмэгтэй хүн оролцсон хэрэг 2.7 мянга болж, 101 (3.9%)-ээр өсжээ. 18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард улсын дунджаар 165 болж, өмнөх оны мөн үеэс 18 (12.2%)-аар өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2018 оны эхний 11 сард 931 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 331 (26.2%)-ээр буурсан байна. Харин мал хулгайлах гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард 981 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 137 (16.2%)-гоор өссөн байна.

Улсын хэмжээнд 2018 оны эхний 11 сард 76.0 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 9.7 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 1.1(1.5%) мянга, баривчлагдсан хүн 676 (6.5%)-гаар буурсан байна. Улсын хэмжээгээр 2017 онд 32.3 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2000 оноос 8796 (37.5%), 2005 оноос 14848 (85.3%), 2010 оноос 12434(62.7%), 2016 оноос 5092 (18.7%)-оор өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2017 онд 1129 хүн нас барсны 169 буюу 15.0 хувь нь хүнийг санаатай алах, 392 буюу 34.7 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмыг зөрчсөн, 469 буюу 41.5 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Гэмт хэргийн улмаас 127 хүүхэд нас барж, 745 хүүхэд гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 2017 онд 10513 хүн гэмтсэн нь өмнөх оноос 744 хүн буюу 6.6 хувиар буурсан байна. Гэмтсэн иргэдийн 61.6 хувь нь эрэгтэйчүүд, 38.4 хувь нь эмэгтэйчүүд, 7.1 хувь нь хүүхдүүд байна.

Нийт гэмтсэн хүмүүсийн 8041 буюу 76.5 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 89 буюу 0.9 хувь нь хүчингийн хэрэг, 641 буюу 6.1 хувь нь танхайрах гэмт хэрэг, 1135 хүн буюу 10.8 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна.

Үүнээс хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2017 онд 573 болж, өмнөх оноос 189 хэрэг буюу 49.2 хувиар өссөн байна. Энэ төрлийн хэргийн 65.6 хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2017 онд 376 бүртгэгдэж, өмнөх оноос 86 хэрэг буюу 29.7 хувь, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 11 бүртгэгдэж, 3 буюу 37.5 хувиар өсөж, харин биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг 16 бүртгэгдэж, 4 буюу 20.0 хувиар буурсан байна.

Харин 2018 оны Улсын хэмжээнд 2018 оны эхний 11 сард 33.9 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3(14.6%) мянгаар өсжээ. Өмнөх оны мөн үеэс нийт

гэмт хэрэг өсөхөд залилах гэмт хэрэг 2197 (83.2 %), хулгайн гэмт хэрэг 757 (6.9%), дээрмийн гэмт хэрэг 397 (37.1%), хөрөнгө завших гэмт хэрэг 181 (56.9%), хүчингийн гэмт хэрэг 123 (34.1%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 490 (6.1%)-ээр өссөн нь голлон нөлөөлөв. Харин бүртгэгдсэн гэмт хэрэг 2018 оны 11 дүгээр сард 3.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 84 (2.3%)-өөр өсчээ. Гэмт хэргийн улмаас 2018 оны эхний 11 сард 8.4 мянган хүн гэмтэж, 931 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 1167 (12.2%), нас барсан хүн 394 (29.7%)-өөр буурсан байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2018 оны эхний 11 сард 30.6 мянга болж, 1.5 мянга (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 13.3 мянга (43.5%) нь эмэгтэйчүүд байна.

2017 онд биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 16 хэрэг бүртгэгдсэний нь бүгд Улаанбаатар хотод бүртгэгджээ. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг Баянгол дүүрэгт 12 бүртгэгдсэн нь өмнөх оноос 4(50%)-өөр өссөн байна. Энэ төрлийн гэмт хэрэг дүүргүүдээс Баянгол дүүрэгт хамгийн олон бүртгэгджээ.

График 7.1.



Орон нутаг дамжин гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээд, бүлэг бөөгнөрлийг гүйцэтгэх ажлын хяналтад авах, тэдгээрийн үйлдэж буй гэмт хэргийг баримтжуулж, илрүүлэх, таслан зогсоох, эрүүгийн болон гүйцэтгэх ажлын нөхцөл байдлыг саармагжуулах зорилгоор “Маршрут”, нийслэлийн хэмжээнд хууль бусаар мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг болон бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулж, орон байраар хангадаг, биеэ үнэлэхийг зохион байгуулдаг саун, массаж, шөнийн цэнгээний газрын үйл ажиллагааг шалгаж, хууль бус үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд, бүлэг бөөгнөрөл үүсгэж байгаа нийтийн байр, зочид буудал, баар, цэнгээний газрыг гүйцэтгэх ажлын хяналтад авах зорилгоор “Хяналт-2”, “Давалгаа”, гэмт хэргийн замаар олдсон эд зүйлийг худалдан авч борлуулдаг, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж /ломбард/, ченжүүдийг илрүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгоор “Мөнгө угаах гэмт хэрэг 2018”,

маш нууцын зэрэглэлтэй 2 нэгдсэн арга хэмжээг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу тус тус зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллажээ⁴⁴.

Олон жилийн тэртээгээс аливаа улс нийгэм эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүчинд тулгуурласаар ирсэн билээ. Эмэгтэйчүүдийн ёс суртахууны суурь нь нийгэм дэх цорын ганц эерэг нөлөө биш боловч олон нийтийн эрх ашигт ер бусын ач тустай гэдэг нь нотлогдсон юм. Биеэ үнэлэгчид “Бид биеэ үнэлсэн мөнгөөрөө өөрийгөө болон гэр бүлээ тэжээж байна. Хэрвээ бид ингэж хөдөлмөрлөхгүй бол хэн ч бидэнд мөнгө өгөхгүй. Тиймээс энэ бол ажил. Үүнийг нийгэм хүлээн зөвшөөрөх хэрэгтэй” гэсэн үзэл бодолтой байдаг.

Нийслэлийн хэмжээнд биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгт орох зэрэг асуудлууд газар аваад удсан. Эрүүл мэндийн шаардлага хангаагүй орчин нөхцөлд, бэлгийн замын халдварт өвчний үүр, голомт болсон нөхцөлд, бусдын биеийг үнэлүүлж, бизнес хийх байдал өргөн дэлгэр болжээ. Саяхны өдрүүдэд гудамны самбар, шонгийн мод, хашаа байшин, хана гэх мэтэд наасан “гулгаа массаж”, “саун” гэх зэрэг хаяг нь тодорхойгүй, холбогдох утасны дугаартай бичвэрүүдийг хуулах аян өрнүүлж байсан. Нийслэлийн цагдаагийн, Эрүүгийн цагдаагийн газартай хамтран шинэ оны эхэнд биеэ үнэлэж болзошгүй газруудад шалгалт хийж 34 газрыг илрүүлсэн байна.

Хэзээ болтол цалингийн боол болж, амьдралд хүрэлцээгүй цалингаар ар гэр, амьдрал ахуйгаа болгоно гэж зүтгэж явах вэ дээ. Хааяа хүн сайн ирэх үед төсвийн байгууллагын сарын цалинг нэг өдөр авах ч үе ч бий. Сайн талаас нь харвал энэ чинь их олзтой ажил байхгүй юу.

Биеэ үнэлэгчтэй хийсэн ярилцлагаас

2017.10.05

Дунд сургуулийн сурагчид найз хөвгүүн, найз охин нэрийдлээр бэлгийн хавьталд эрт орж, жирэмслэх, 15 настай охин ээж болох нь хэвийн үзэгдэл болоод байна. Мөн оюутан залуус хамтран амьдрагч хэмээх шинэ “гэр бүл” үүсгэдэг. Энэ нь эхнэр, нөхрийн хариуцлага үүрэхгүйгээр хэн хэндээ “ашигтай байх” зарчим. Үүнээс гадна далд амьдралтай ч ил харагдаж байдаг биеэ үнэлэгч нарын асуудал нийгмийн эмзэг сэдэв болоод байна. Мөн хамгийн эрсдэлтэй хүмүүсийн тоонд биеэ үнэлэгч нарыг оруулдаг. Учир нь ХДХВ/ДОХ-той хүмүүсийн 80.6 хувь нь эрэгтэй, 19.4 хувь нь эмэгтэй бөгөөд эрчүүдийн 92.9 хувь нь эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог, эмэгтэйчүүдийн 52.6 хувь нь биеэ үнэлэгч ба бэлгийн олон хавьтагчтай хүн байгаа юм. ХДХВ-ийн халдвар цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгээс шалтгаалах халдвар байдлаар илрээгүй бөгөөд бүгд бэлгийн замаар дамжсан байдаг. Улаанбаатар хотод 2018 оны 11 дүгээр

⁴⁴ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны гуравдугаар улирлын үйл ажиллагааны тайлан//Police.gov.mn/resource/policegovmn

сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол 1 гарч улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ ДОХ-ын тохиолдол нийт 267 болсон байна.

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2017 онд 9019 болж, өмнөх оноос 2453 буюу 37.4 хувиар өссөн байна. Ял шийтгүүлэгчдийн 1977 буюу 21.9 хувь нь урьд нь ял шийтгүүлж байсан, 282 буюу 3.1 хувь нь давтан хэрэг үйлдсэн, 1497 буюу 16.6 хувь нь бүлэглэн үйлдсэн, 2250 буюу 24.9 хувь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлэгчдийн 933 буюу 10.3 хувь нь эмэгтэйчүүд, 425 буюу 4.7 хувь нь хүүхдүүд байна.

2017 онд Монгол Улсын нэг хүнд ногдох архины хэмжээ 8.2 литр болж, өмнөх оныхоосоо нэмэгджээ. Энэ тоо 2016 онд 8.0, 2015 онд 7.1 литр байжээ. Өөрөөр хэлбэл, архины үйлдвэрлэл нэмэгдсэн байна⁴⁵. Архи, согтууруулах ундааг 15 ба түүнээс насны нэг иргэдэд хуваавал нэг хүнд 11.7 литр архи, 1.2 литр дарс, 40.2 литр шар айраг ногдож байна.

2017 онд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж эрүүлжүүлэгдсэн 86.5 мянган хүний 34.2 мянга буюу 39.5 хувь нь аймгуудад, 49.3 мянга буюу 57.0 хувь нь дүүргүүд болон албадан саатуулах төвд, 3.0 буюу 3.5 хувь нь төмөр замын цагдаагийн газарт эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт нийт 280.2 сая төгрөгийг төлсөн байна.

Эрүүлжүүлэгдсэн иргэдийн 5521 буюу 6.4 хувь нь эмэгтэйчүүд, 271 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 102 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс байна.

Харин согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард 3.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 959 (24.5%)-өөр, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 1621 болж, 961 (37.2%)-ээр, хүүхэд оролцсон хэрэг 674 болж, 154 (18.6%)-өөр буурч, харин эмэгтэй хүн оролцсон хэрэг 2.7 мянга болж, 101 (3.9%)-ээр өсжээ. 18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард улсын дунджаар 165 болж, өмнөх оны мөн үеэс 18 (12.2%)-аар өссөн байна.

Улсын хэмжээнд 2018 оны эхний 11 сард 76.0 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 9.7 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 1.1(1.5%) мянга, баривчлагдсан хүн 676 (6.5%)-гаар буурсан байна.

⁴⁵Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2017 онд // <https://ikon.mn/n/1cxa>

7.8. ХҮН АМ ЗҮЙ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, ХОТЖИЛТ

"Монгол Улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа"-г хийсэн Монгол улсын үндэсний их сургуулийн судлаачдын багийн судалснаар 1989 онд хүн амын дөрөвний нэг хувь нь (26.8%) оршин сууж байсан нийслэлд, одоо нийт хүн амын бараг тал (47%) хувь нь оршин сууж байна. ҮСХ мэдээлснээр, 2010-2016 онуудад 126,143 хүн Улаанбаатарт албан ёсоор шилжин суурьшснаар, 2017 онд нийслэлийн хүн ам 1,463,000 гэж тоологджээ⁴⁶.

Төв сууринд амьдрах, алслагдсан бүс нутагт амьдрах нь иргэдийн орлогын тэгш бус байдалд нөлөө үзүүлдэг гэсэн тооцоо бий. Манай улсад ч гэсэн нөхцөл байдал ийм байгаа. Тиймээс хүн амын хөдөөгөөс Улаанбаатар хот руу шилжин ирэх явдал өндөр байна. Мэдээлэл, боломжид ойр байж нийгмийн баялгаас тэгш хүртэх гэсэндээ л хүмүүс нүүж ирцгээж байгаа хэрэг шүү дээ, буруутгах ямар ч арга байхгүй.

Монгол Улсад 1992 оноос хойш хүн амын шилжих хөдөлгөөн чөлөөтэй болсон. Монгол Улсын Үндсэн хуульд улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй гэсэн заалтын дагуу иргэд оршин суух хөдөлгөөнд чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлсэн билээ. 1990 онд Улаанбаатар хотын хүн ам нийт Монгол Улсын хүн амын 26 хувь байсан бол 2017 онд 47 хувь болон өсөж төвлөрөл нэмэгдсэн байна. Агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласан нь үр дүнгээ өгч жилд дунджаар 30 мянган хүн шилжин ирдэг байсан бол 20 мянгаар буураад байна.

Улаанбаатарыг чиглэсэн шилжих хөдөлгөөнд залуучууд тэр тусмаа залуу эмэгтэйчүүд (60%) илүү хамрагдаж байна. Мөн нийт шилжин ирэгсдийн 56.4% нь эмэгтэйчүүд байгаа нь шилжих хөдөлгөөнд эмэгтэйчүүд түлхүү оролцож байгааг харуулж байна.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод оршин суугчдын 3 хүн тутмын нэг нь 1990-2015 оны хооронд шилжиж ирсэн дүр зураг гарч байгаа бөгөөд хүн ам жилд дунджаар 6 хувиар өссөн нь улсын дундаж өсөлт болох 1.83 хувиас даруй 3.3 дахин өндөр байгаа юм. Нийслэлийн хүн амын өсөлтийн 56 хувийг орон нутгаас шилжин ирсэн хүн амын шилжилт хөдөлгөөн эзэлж, нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын нягтрал 286 байгаа нь улсын дунджаас 150 дахин өндөр үзүүлэлт юм.

⁴⁶ "Монгол улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа" УБ., 2018.

Энэхүү төвлөрлөөс үүдэлтэй агаар орчны бохирдол, авто замын түгжрэл үүсэх, дэд бүтцийн ачаалал ихсэх, нийгмийн үйлчилгээний хүчин чадал зэрэг асуудлууд зохист хэмжээнээс 2-3 дахин хэтэрчээ.

Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг даган 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаа батлан хэрэгжүүлж байна. Уг үзэл баримтлалд хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоонд тулгуурлан хот байгуулах, бүсчлэн хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах замаар дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг асуудлуудыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Засгийн газрын гурван тулгуурт хөгжлийн бодлогын эдийн засгийг олон тулгуурт болгож хөгжүүлэх зорилго нь хөдөө аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтцийн салбаруудыг мэдээлэл, санхүү, тээвэр логистикоор уялдуулан төлөвлөж, эдийн засгийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд анхаарч байна. Хотын оршин суугчдын хэт өсөлт нь сүүлийн жилүүдэд байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг зөрчил ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулж байна.

Улаанбаатар хотод шилжин суурьшиж хотын захын хороололд төвхнөсөн иргэд хотын хүн амын 60 гаруй хувийг эзэлж байгаа хэдий ч хот хөгжүүлэх төлөвлөлтөнд тэдний амьдрах орон зай, орчин нөхцөл зохих байр сууриа эзэлж чадаагүй байгаа юм. Хотын захын хорооллын хүн амын 3.1 нь шинээр суурьшин иргэд бөгөөд тэдний 40 хувь нь нийгмийн эмзэг бүлэгт багтдаг тул тусламж дэмжлэг хэрэгтэй хүн амын тоонд орж байна.

Нийслэл Улаанбаатар хотын оршин суугчдын хэт өсөлт нь сүүлийн жилүүдэд хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг зөрчил, ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулах болсон. Нийслэлийн хүн амын механик, хэт өсөлт, Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг бий болгодог гэр хорооллын яндангийн тоо хоёр харилцан шууд хамааралтай байдаг. Энэхүү нөхцөл байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2-т заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг ноцтой хөндөж байгаа юм.

Улаанбаатар хотыг чиглэсэн их нүүдэл, зохисгүй төвлөрөл нь хотын байгаль, экологийн нөхцлийг гамшгийн хэмжээнд хүргэн, инженерийн болон нийгмийн дэд

бүтцэд томоохон хөрөнгө оруулалтыг шаардаж, хотын бүсүүдийн хөгжлийг зогсонги байдалд хүргэж, улмаар Улаанбаатар хот цаашид тогтвортой, тэнцвэртэй хөгжихөд гол бэрхшээл учруулж байна. Нийт шилжин ирэгсдийн 65.6% нь буюу 2/3 нь гэр хороололд амьдарч байна. Мөн шилжин ирэгсдийн 70% нь хотын төвд ойролцоо болон захдуу суурьшиж байна.

Шилжин ирэгчдэд ажилд орох, амьдралаа залгуулах, амьдрах орон байр чухлаар тавигдаж эхэлдэг. Улаанбаатар хотод нийт шилжин ирэгсдийн 38,4 хувь нь амьдрах байр сууриа олоогүй хүмүүс байна.

Боловсролын түвшин өндөр, сэхээтэн гаралтай, удирдах түвшний албан тушаалтай хүмүүс илүү нийгэмд эзлэх байр сууриа олж чаддаг байна. Тийм хүмүүсийн хувьд ажил эрхэлдэг, амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой, тохилог сууцанд амьдардаг байна. Харин боловсролын түвшин бага, малчин болон ажилчин гаралтай, ажил эрхэлдэггүй хүмүүсийн хувьд нийгэмд эзлэх байр сууриа олоход хүндрэлтэй байх бөгөөд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, тохилог бус сууцанд амьдардаг байна. Соёлын капиталгаа хараахан бүрдүүлж чадаагүй хүмүүс эдийн засгийн болон нийгмийн капиталгаа дээшлүүлж чадахгүй байгаа нь харагдана.

Гадаадад буй Монголчууд нийт хүн амын 10 хувьд хүрч, 2-3 аймгийн хүн амтай тэнцэх тооны монгол иргэд харь улс орнуудад байна. Гадаадад зорчсон монгол иргэдийн тоо 2007 онд давхардсан тоогоор 990 мянга байсан бол 2017 онд 2.4 сая болж өссөн. 2016 оны эцсийн албан ёсны мэдээнд гадаадын 74 улсад 144.560 гаруй иргэд оршин сууж, тухайлбал, БНСУ-д 38.000, АНУ-д 25.000, БНХАУ-д 8653, Японд 6590, Шведэд 6000, Чехэд 6412, Казакстанд 15000, Канадад 5500, ОХУ-д 4870, ХБНГУ-д 4746, Францад 4600, ИБУИНВУ-д 4200, Туркэд 4000, Австрид 2500, Австралид 3000, Швейцарьт 2000, Испанид 1500, Унгарт 1320, Бельгид 1080, Польшид 939, Энэтхэгт 700, Нидерланд 530, Украин 518, Малайзид 350, Сингапур 290, Норвег 250 болон бусад оронд, үүнээс албан ёсоор хөдөлмөр эрхэлж буй 26697, гадаадын харъяат болсон 3705, гадаадын иргэнтэй гэр бүл болсон 5999, суралцаж буй сургуулийн насны 2399, оюутан 25989, гадаад улсад төрсөн (зөвхөн харъяа ДТГ-т бүртгүүлсэн байдлаар) 4064, хууль бусаар оршин суугаа 40114 иргэд гэсэн статистик байна. Үүнээс 60000 гаруй Монгол оюутнууд суралцдаг гэсэн албан бус тоо байдаг. Гадаадад хууль бусаар оршин суугаа оршин иргэд БНСУ-д 40110, АНУ-д 915, Японд 600, ОХУ-д 365, Хятадад 103, Европ тивийн Австрид 1000, Бельгид 948, Нидерландад 478, Шведэд 1100, Швейцарьт 1500, Францад 71 гээд олон оронд байна. Эдгээрээс гадаадад байнга оршин суух иргэдийн тоо

2007 онд 4.2 мянга байсан бол 2017 онд 13.8 мянга болжээ.⁴⁷ 2017 оны 10 дугаар сарын байдлаар гадаадын 19 улсад манай 350 иргэн гэмт хэрэгт холбогдож, 14 улсад 162 монгол иргэн ял эдэлж байна⁴⁸.

Тэд бол бүрэлдэхүүний хувьд дунджаас дээш амьдралтай, ид хөдөлмөрийн насны, мэдлэг боловсролтой, овсгоо самбаатай, эрчим хөдөлгөөнтэй, амьдралынхаа төлөө тэмцэж яваа идэвхитэй иргэд, хөдөлмөрч хүмүүс гэж хэлж болохоор байна.

Монгол улсын хувьд олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан үндсэн баримт бичгүүдэд нэгдэн орсон боловч цагаачлалын талаарх тусгайлсан зохицуулалт бүхий “Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай” 1990 оны НҮБ-ын олон улсын конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний тухай” 1949 оны 97-р конвенц, “Цагаач ажилчдын талаарх” 1975 оны 143-р конвенц, тэдгээрийг дагалдан гаргасан зөвлөмж зэрэгт нэгдэн ороогүй байна.

Өнөөг хүртэл МУ-ын Засгийн газар гадаад руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнд оролцогчдын тухай нэгдсэн мэдээлэл, тоо баримт байхгүй, дүрвэн ирсэн болон гарсан иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй учир энэ талаар мэдээ баримтыг цэгцлэх, олон нийт, хүний эрхийн байгуулагуудад нээлттэй болгох шаардлагатай юм.

7.9. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд залуус ардчилал, эрх чөлөө ярьж гэр бүлийн уламжлалт харилцааг умартаж, эхнэр, нөхөр болох уламжлалт ёсоо ч мартаж дуртай үедээ дэр нэгтгэн амьдрах болсон нь гэр бүл хэмээх нандин харилцааны мөн чанар хийгээд үнэ цэнийг алдагдуулж байна.

Судалгаанаас үзвэл таван гэр бүл тутмын нэг нь, нийслэл хотын хэмжээнд гурван гэр бүл тутмын нэг нь гэрлэлтээ цуцлуулж байна. Жилд 3000-4000 орчим гэр бүл шүүхээр гэрлэлтээ цуцлуулж байна. Энэ тоо баримт зөвхөн албан ёсоор гэр бүлээ цуцлуулсан иргэдийнх юм. Салж байгаа гэр бүлүүд 1-2 хүүхэдтэй. Тэгвэл жилд дунджаар 10000 орчим хүүхэд гэр бүл салалтын золиос болж байна.

Шүүхээр гэр бүлээ цуцлуулж байгаа хосуудын мэдүүлэг болон судалгаанаас авч үзэхэд гурван шалтгаан байна. Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл

⁴⁷ <https://www.nso.mn>

⁴⁸ <https://news.mn/r/513469/>

ойлголцлын асуудлууд шалтгаан болдог. Хоёрдугаарт, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа. Гуравдугаарт, хол тусдаа байсан гэсэн шалтгаанаас үүдэж гэр бүл салдаг.

Шүүхээс “Гэр бүлийн тухай” хуулиар 2017 онд 4566 хэрэг шийдвэрлэгдсэний 2791 (61.1%) нь гэрлэлт цуцалсан, 467 (10.2%) нь эцэг тогтоосон, 1056 (23.1%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 24 (0.5%) нь эцэг, эх байх эрх хассан, 50(1.1%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 178 (3.9%) нь бусад хэрэг байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1286 гэмт хэргийн 1117 буюу 86.9 хувь нь хөнгөн, 82 буюу 6.4 хувь нь хүндэвтэр, 65 буюу 5.1 хувь нь хүнд, 22 буюу 1.7 хувь нь онц хүнд гэмт хэрэг байна. Хөнгөн хэлбэрийн гэр бүлийн хүчирхийлэл өмнөх оноос 3.9 пункт, хүнд хэлбэрийн хүчирхийлэл 1.6 пунктээр нэмэгдэж, харин хүндэвтэр хэрэг 5.0 пункт, онц хүнд хэрэг 0.4 пунктээр буурчээ. Хүндэвтэр болон онц хүнд хэлбэрийн хүчирхийлэл буурсан нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлээр гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилдаг болсонтой холбоотой өөрчлөлт юм.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 757 буюу 58.9 хувь нь Улаанбаатар хотод байна. Дүүргүүдээс Баянзүрх (216), Сонгинохайрхан (125), Баянгол (116) –д хамгийн их гэр бүлийн хүчирхийлэл бүртгэгджээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2017 онд 1120 хүн хохирсон нь 2016 оноос 237 буюу 17.5 хувиар буурав. Эдгээр хүмүүсийн 1040 буюу 92.9 хувь нь эмэгтэйчүүд, 90 буюу 8.0 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг МУ-ын Эрүүгийн хуулийн бүлгээр авч үзвэл 85.7 хувь нь Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 12.9 хувь нь Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 0.8 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 0.3 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 0.2 хувь нь Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг, 0.2 хувь нь Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг байна. Сүүлийн 11 жилийн байдлаар жилд дунджаар 1306 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хүүхдүүд ихэвчлэн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирдог байна.

Хүчирхийлэлд өртсөн иргэдийн 516 буюу 46.1 хувь нь ажилгүй иргэд, 96 буюу 8.6 хувь нь төрийн албан хаагч, 221 буюу 19.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн 730 буюу 65.2 хувь нь 0-1 жил, 139 буюу 12.4 хувь нь 1-3 жил, 24 буюу 2.1 хувь нь 3-5 жил, 9 буюу 0.8 хувь нь 5-8 жил, 25 буюу 2.2 хувь нь 8-аас дээш жил хүчирхийлэлд автсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн 732 буюу 65.4 хувь нь жилд 1-2 удаа, 108 буюу 9.6 хувь нь улиралд 1-2 удаа, 42 буюу 3.8 хувь нь сард 1-2 удаа, 29 буюу 2.0 хувь нь 14 хоног тутамд, 2 буюу 0.2 хувь нь 7 хоног тутам, 31 буюу 2.8 хувь нь байнгын хүчирхийлэлд автдаг байна. Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон иргэдийн 53.5 хувийг эхнэр нь, 17.1 хувийг хамтран амьдрагч нь, 3.4 хувийг төрсөн хүүхэд нь, 3.5 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2018 оны эхний 11 сард 931 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 331 (26.2%)-ээр буурсан байна. Харин мал хулгайлах гэмт хэрэг 2018 оны эхний 11 сард 981 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 137 (16.2%)-гоор өссөн байна.

ДЭД ДҮГНЭЛТ, САНАЛ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Гүйцэтгэх зөвлөлийн хурлаар Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д тусгасан хөгжлийн зорилтуудыг хангах, үйл ажил болгоход дэмжлэг үзүүлэх, хувь нэмэр оруулах зорилгоор Монгол Улсад 2017-2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн баримт бичиг батлан гаргасан. Энэхүү баримт бичигт:

- Хүн амын хамгийн ядуу давхаргынхны хувьд эрүүл мэндийн үйлчилгээ хамгийн их хэрэгцээтэй байдаг ч эл үйлчилгээг авч чаддаггүй;
- Хамгийн чинээлэг бүлгийнхний эрүүл мэндийн зардал хамгийн ядуу давхаргын хүмүүсийнхээс бараг 20 дахин илүү;
- Орон байрны дутагдал, орлого болон хоол хүнсний хомсдол, боловсролын дорой байдал нь хүүхдийн эндэгдлийн шалтгаан болж байгаагаагийн зэрэгцээ хүүхдүүд гэртээ гэмтэл авч эндэх явдал нэмэгдсээр байна;
- Нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин ядуу айл өрхүүдийн хувьд улсын дунджаас 3 дахин өндөр;
- Эрүүл мэндийн чанартай үйлчилгээнд хамрагдах магадлал багатай ядуу, боломж муутай бүлгийнхний хувьд шинээр төрсөн хүүхдийн эндэгдэл өндөр байх төлөвтэй;
- Цалин орлогогүй байх, хоол хүнс, боловсролын дорой байдал нь хүүхдийн тэжээлийн доройтлын гол шалтгаан болж буй. Ядуу айл өрхүүдийн хүүхдийн хоол тэжээлийн чанар чинээлэг өрхүүдээс эрс ялгаатай байна гэж дүгнэжээ.

Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн ихэнх улс орнуудтай харьцуулахад Монгол Улсад жендэрийн тэгш бус байдал харьцангуй бага байдаг. Гэсэн хэдий ч олон монгол эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх, ажилд орох боломж нөхцлүүдийг нь хязгаарласан жендэрийн тэгш бус байдалтай тулгарсаар байна.

Монгол эмэгтэйчүүд боловсролын түвшингөөрөө эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү өндөр байдаг. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд өөрсдийн олж авсан боловсролыг ашиглаж, хөдөлмөрийн зах зээлд идэвхитэй оролцох боломжоор харьцангуй дутмаг байна.

Монгол Улсад ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад эрэгтэйчүүдийнх өндөр байсаар ирсэн. 1996-2015 оны хооронд ажиллах хүчний оролцооны жендэрийн ялгаа 4.8 хувь нэгжээс өссөөр 12.6 хувь нэгж хүртэл нэмэгджээ.

Үүнээс гадна, ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн дундаж цалингийн хэмжээ ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийнхээс үргэлж доогуур байсаар ирсэн. 2015 онд цалин хөлсний жендэрийн харьцангуй ялгаа 12.5 хувьтай байв.

Нийтлэг эрхэлдэг ажил хөдөлмөр ч хүйсээр ялгаатай байна. Эмэгтэйчүүдийн олонх нь, ялангуяа хөдөө орон нутагт, баталгаагүй албан бус салбарт болон цалин хөлсгүй өрх гэрийн ажлуудыг хийж байна.

Бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс хавьгүй доогуур байгаагаас гадна эдийн засгийн өөр өөр салбаруудад ажиллаж буй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувь ч мөн ялгаатай байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын үндсэн шалтгаанууд нь гэрлэлт, гэр орны ажил болон бусдыг асран халамжлах, мөн ажил мэргэжлийн сонголт, ажил эрхлэхтэй холбоотой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн талаарх нийгэмд тогтсон ойлголт, хэм хэмжээ зэрэгтэй холбоотой байна.

Эмэгтэйчүүд насанд хүрсэн амьдралынхаа ихэнхийг нь хань нөхрөө дэмжих, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд зарцуулах ёстой гэсэн нийгмийн хүлээлт байдаг.

Хэдийгээр зарим эмэгтэйчүүд дээрх үүргээ биелүүлэхийн хажуугаар ажил мэргэжлээ амжилттай эрхэлж байгаа боловч хүүхэд асрах үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа нь ажил эрхлэхэд саад болдог гэж ихэнх эмэгтэйчүүд үзэж байв.

Ажлын цаг хангалттай уян хатан биш байдгаас хөдөлмөрийн зах зээлд оролцоход хүндрэлтэй байдаг гэж үзэх эмэгтэйчүүд олон байна. Энэ нь мөн эмэгтэй

ажилчдад тулгардаг эл асуудлыг ажил олгогчдын зүгээс үл хайхарч буйн нэг илрэл гэж ярилцлагад оролцогчид үзэж байлаа.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатай үйлчлэх зарим хууль эрх зүйн зохицуулалт нь жендерийн уламжлалт үүргийг хүлээн зөвшөөрөх үндсийг бий болгож байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын хууль эрх зүйн орчинг шинэчлэх, ажилд авахад хүйсээр ялгаварлан гадуурхах байдлыг хориглох хуулийн шаардлагыг тодотгох, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан ялгаварлан гадуурхалтын эсрэг бусад бодлогын хэрэгжилтийг хангах. Хэрэгжилтийг хангахын тулд жендэрийн тусгайлсан шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хяналт үнэлгээг сайжруулах;
- Хөдөлмөрийн зах зээлийн зуучлалын үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээг үйлчлүүлэгч-төвтэй болгож бэхжүүлэх. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогуудыг ерөнхийд нь дэмжиж, эдгээр бодлогоор дамжуулан жендэрийн онцлогтой бэрхшээлүүдийг шийдвэрлэх чадварыг сайжруулах;
- Эмэгтэйчүүдэд бичил бизнес эрхлэх боломжийг бүрэн ашиглахад нь туслах зорилгоор тэдний эзэмшдэг, эрхлэн явуулдаг бичил бизнесүүдэд санхүүгийн болон сургалтын дэмжлэг үзүүлэх зэргээр бичил бизнесийн дэмжлэгийг өргөжүүлэх;
- Илүү олон эмэгтэйчүүдэд хөдөлмөрийн зах зээлд тасралтгүй, үр бүтээлтэй оролцох оролцоог хангах зорилгоор ахмад настны, ялангуяа хүүхэд асрах үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх. Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг ялангуяа тусламж үйлчилгээ хамгийн бага хүртдэг хөдөө орон нутагт өргөжүүлэх;
- Ажил олгогчид, хүний нөөцийн менежерүүдэд хүний нөөцийн хөгжлийн стратегиуд, жендэрийн мэдрэмжтэй, насны ялгаатай ажил төлөвлөлтийн орчин үеийн стратегийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажил, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах замаар ажил олгогчид болон нийт хүн амын дундах жендэрийн хэм хэмжээ, хандлагад нөлөөлөх;
- Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулан, улсын орон зайн хөгжлийг нарийвчлан тодорхойлох;
- Монгол улсад хувийн хэвшилд суурилсан эдийн засаг, бизнесийг хөгжүүлэхийн тулд хүн амын болон зах зээлийн төвлөрлийг оновчтой байршилд зохицуулах

- зайлшгүй шаардлага байна. Ингэхдээ Улаанбаатар төвт хувилбараас Улаанбаатар + бүсүүдийн тулгуур төвүүд гэсэн хувилбарт шилжих;
- “Бүс бүр өөрийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй байх, аливаа бүсийн тэргүүлэх чиглэлд заасан үйлдвэрлэл үйлчилгээг бусад бүсүүдэд тодорхой хэмжээгээр хязгаарлаж бүс хоорондын харилцан хамаарлыг нэмэгдүүлэх;
 - Олон улсын зах зээлд нэвтрэх, дотоодын үйлдвэрийг хамгаалах, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор экспортын чиг баримжаатай үйлдвэрүүдийг тусгайлан дэмжиж хөгжүүлэх;
 - Улаанбаатар хотын хөгжлийг төвийн бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;
 - Нэг төвтэй төвлөрсөн тогтолцоог олон төвтэй тогтолцоонд шат дараалалтайгаар шилжүүлж, Монгол улсын хөгжлийн хэвтээ ба босоо тэнхлэгүүдийг холбох бодлогоор бусад бүсүүдийн төвийг Улаанбаатар хоттой өрсөлдөх чадвартай болгон хөгжүүлэх;
 - Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах зорилгоор дагуул хот суурингуудыг үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлээр түлхүү хөгжүүлэх;
 - Дагуул хот, тосгодод үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, ажиллаж, амьдрах тохилог орчинг бүрдүүлэх зэрэг болно.

1. Цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, **хүчиндэх** гэмт хэрэг 2015 онд 279 бүртгэгдэж байсан бол жил дараалан өсч, 2017 онд 376 болж, 34.8 хувиар өссөн. 2018 оны эхний 10 сарын байдлаар 472 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр 40-50 хувиар өсөх прогноз харагдаж байна.

Гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын байдлыг авч үзвэл, 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар Хүчиндэх 1417 хэрэгт 1232 хүн холбогдон шалгагдаж, 1382 хүн хохирогч болсоны 58 буюу 4.2% нь 7 хүртэлх насны, 233 буюу 16.9% нь 8-13 насны, 384 буюу 27.8% нь 14-17 насны, нийт 675 буюу 48.8% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн **893 буюу 63.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.**

Прокурорын байгууллагаас 2015 онд хүчиндэх 402 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2016 онд буурч, 2017 онд 444 болж, 21.0%-иар өсчээ. 2018 оны эхний 10 сарын байдлаар 948 болж, 2018 оны жилийн эцсийн мэдээллээр 2.6 дахин өсөн прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хүчиндэх 2161 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, **916 хэрэг буюу 42.4%-ийг шүүхэд шилжүүлжээ.**

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх 776 эрүүгийн хүлээн авсаны 697 буюу 89.8% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 776 эрүүгийн хэргийн **573 буюу 73.8%-ийг шүүхээр шийдвэрлэж, 665 хүнд ял оноосон байна.**

Шүүхээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 665 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 193 хүнд, 2016 онд 226 хүнд, 2017 онд 243 хүнд хорих ял оногдуулжээ. Хүчиндэх гэмт хэрэгт хорих ял оногдуулалт өссөн байна.

2. **Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг** 2015-2017 онуудад 21-23 орчим бүртгэгдэж байсан ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 11 бүртгэгджээ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 76 бүртгэгдэж, 67 хүн холбогдон шалгагдаж, 73 хүн хохирогч болсоны 12 буюу 16.4% нь 7 хүртэлх насны, 26 буюу 35.6% нь 8-13 насны, 6 буюу 8.2% нь 14-17 насны, нийт 44 буюу 60.3% нь хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн

бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн **57 буюу 75.0%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.**

2015-2016 онуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 52-63 орчим хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч, 24 болжээ.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 173 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, **139 хэрэг буюу 80.3%-ийг шүүхэд шилжүүлжээ.**

Шүүхээс 2015-2017 онд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 65 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 92.3% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 65 эрүүгийн хэргийн **52 буюу 80.0%-ийг шүүхээр шийдвэрлэж, 55 хүнд ял оноосон байна.**

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн 55 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 18 хүнд, 2016 онд 19 хүнд, 2017 онд 18 хүнд хорих ял оногдуулжээ.

3. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 онд 28-30 бүртгэгдэж байсан бол 2018 оны эхний 10 сарын байдлаар 38 бүртгэгдэж, оны эцсээр 20%-иар өсөх хандлагатай байна.

Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар 134 бүртгэгдэж, 119 хүн холбогдон шалгагдаж, 133 хүн хохирогч болсоны 17 буюу 12.8% нь 7 хүртэлх насны, 111 буюу 83.5% нь 8-13 насны хүүхдүүд байсан байна.

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаар бүртгэгдсэн 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

2015 онд Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 56 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байх ба 2017 он хүртэл буурсан боловч 2018 оны эхний 10 сарын байдлаар 78 болж, өмнөх оныхоос оны эцсээр 70%-иар өсөхөөр прогноз харагдаж байна.

Прокурорын байгууллагаас 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаархи хугацаанд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 232 гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 107 хэрэг буюу 46.1%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Шүүхээс 2015-2017 онд 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 69 эрүүгийн хүлээн авсаны 60 буюу 87.0% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 69 эрүүгийн хэргийн 54 буюу 78.3%-ийг шүүхээр шийдвэрлэж, 65 хүнд ял оноосон байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг үйлдсэн 65 шүүгчдэгчдэд ял оноосон байдлыг авч үзвэл, 2015 онд 15 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2016 онд 13 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2017 онд 15 хүнд хорих, 4 хүнд албадан ажил хийлгэх, 2 хүнд торгох ял оногдуулжээ.

Судалгааны ажлын хүрээнд “Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох нэгжийн гаргаж өгсөн мэдээллийг ашиглалаа. Эдгээр байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээлэл боловсронгуй болсон байна дүгнэж болохоор байна.

4. Өнөөдрийн байдлаар үчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй нийт **530** хоригдол байна. Энэ нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Зөвхөн энэ тооноос харахад хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо Монгол Улсад өндөр байгааг харуулж байна. Үүнээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 81 хоригдол ял эдэлж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдолд оногдуулах ялын бодлого хохирогчийн насны байдлаас шалтгаалан хэт ялгаатай байгаа нь насанд хүрсэн хохирогчийн зөрчигдсөн эрхийг бүрэн сэргээж чадна гэдэгт эргэлзээ төрүүлж байна. Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг нь материаллаг гэхээсээ илүү хохирогчийн сэтгэл зүй, алдар хүнд, оюун санааны хэлбэрээр илэрдэг тул үүнийг мөнгөн илэрхийллээр тооцдог эрх зүйн механизм манай улсад учир дутагдалтай байна. Энэ байдал нь хохирогч гэмт хэргийн золиос болсноо нуух, гэмт этгээдийг илчлэхээс эмээх цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд бугшмал байдлаар өсөн нэмэгдэх эрсдэл байна.

5. 2015-2017 онд Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1 дүгээр зүйлд заасан хэргүүдэд нийт 332 шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийж үзэхэд эдгээр хэргүүдийн 88 хувь нь хүчиндэх (126.1), (12.1) гэмт хэрэг зүйл эзэлж байна.

Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд эзэлж байгаа ч, насны хувьд бага насны хүүхэд өртөж байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч **44.8 хувь нь 11-16 насны охид** эзэлж байна.

Тухайн онуудад **нийт 361 хохирогч, холбогдогч хамрагдсанаас сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан 88**, үүнээс 58 /65 хувь/ хохирогч нь эмэгтэй байна.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7 хувь нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой байлаа.

Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4 хувь нь 17-21 насны залуус эзэлж байна.

6. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэх аргыг “хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах” гэж диспозицид дэлгэрэнгүй зааж, “хохирогчийн хүсэл зоригийн эсрэг” гэж субъектив талын шинжийг шинээр зааж өгсөн нь практикт энэ төрлийг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.

Зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог болсон, хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болохоор тугасан зэрэг нь олон улсын жишигт нийцсэн.

Мөн “бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж заасан нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан үйлдэл (хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар бэлэг эрхтнийг хөхүүлэх, хохирогчийн ам, суга, цавь, шулуун гэдсэнд дур тавих г.м)-ийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулж, гэмт этгээдэд ял завшуулж байсан буруу тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцсэн алхам болсон.

- “Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэж заасан нь практикт бага насны хүүхдийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах арга хэрэглэсэн байхыг шаарддаг буруу хандлагыг өөрчилсөн.

Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан; арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол онц хүндрүүлэхээр заасан нь өсвөр насны хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг онцгойлон эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан алхам болсон.

- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив талыг хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэж шинээр томъёолохдоо объектив талын нэмэгдэл шинж болох цаг хугацааг зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэрэг болохоор заагласан байна.

- Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх хүний насыг 18 байхаар зааж, халдлагад өртөгч (хохирогч)-ийг 14-16 настай болохыг мэдэх боломжтой, мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь практикт энэ хэргийн зүйлчлэлийн талаар үүсдэг маргааныг шийдвэрлэхэд дөхөм болсон. 14 хүртэлх насны буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн шинжид хуульчилсан. Ингэж энэ гэмт хэргийн хохирогчийн насыг тодорхой зааж өгсөн нь нэг мөр ойлголт өгсөн ач холбогдолтой болсон байна.

7. Гадаадын зарим улс орнуудын бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эрүүгийн хуульд хэрхэн тусгасан судалгааг Америк, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн хийж үзэхэд Монгол Улсад бие үнэлэхтэй тэмцэх асуудал “захиргааны аргаас хэтрэхгүй” байна. Судалгааны үндсэн хэсэгт дурьдсан дүгнэлт, саналыг харгалзан үзэх нь зүйтэй.

8. Монголчуудын гэмт хэрэгт хохирохоос айх байдлын судалгааг нийт 1449 иргэнээс авсанаас бөгөөд тодорхой төрлийн 8 гэмт хэргээс түгших хандлагыг дараах асуултаар шалгасан. Судалгааны дүнгээс үзвэл “Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ” гэхээс айдаг гэсэн асуултанд хариулсан байдлын дундаж нь 3.18 бол дараагийн дугаарт “Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна” гэхээс айдаг гэсэн асуултын дундаж хариулт 3.14 гэсэн үзүүлэлттэй байна.

Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн төрөлд бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.94 гэсэн дундаж үзүүлэлтээр орж байгаа бол хууль бусаар мөрдөх гэмт хэргийн 2.96 гэсэн үзүүлэлттэй байна.

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 15 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн

шинжилгээ хийсэн болно. Эх олонлогоос түүвэрлэлт хийх замаар судалгаанд оролцогчдыг сонгож авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын нөхцөл байдлыг илэрхийлэх чадвартай гэж үзсэн болно.

Гэмт хэргийн улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмблэн харуулахад судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 389 буюу 26.9 хувь нь ямар нэгэн байдлаар хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авах замаар хохирсон гэж тус тус хариулжээ.

Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байгаа нь өмнөх асуулгын үр дүнтэй нийцэж байна.

9. Контент анализын аргаар хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл⁴⁹, хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл гэдэг сэдэв нь өөрөө хүний эмзэг асуудлыг хөндсөн сэдэв учраас сэтгүүлч, нийтлэгч нар ихээхэн сонирхож, судалж бичдэг болох нь харагдав. Үүн дотор хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэг гэх мэт дуулиантай хэргүүдийн талаар олон талаас бичсэн нийтлэлүүд цөөнгүй байна. Хэн нэгэн УИХ-ын гишүүн, олны танил хүмүүс тус гэмт хэрэгт холбогдсон талаар хамгийн олон хандалттай, хамгийн олон нийтлэгдсэн байгааг харж үзвэл, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээр бус улс төрийн зорилготой нийтэлсэн гэж харагдаж байна. Мөн нийтлэлүүд нь тоон судалгааг ашигласан байгаа боловч албан ёсны мэдээнээс зөрсөн тохиолдлууд цөөнгүй анзаарагдав. Зарим төр, холбогдох хуулийн байгууллагыг буруутгасан хэн нэг байр сууринаас хандсан нийтлэлүүд ч цөөнгүй байна. Харин албан ёсны байгууллагаас мэргэжлийн тайлбар, ярилцлага өгсөн нийтлэл маш цөөн байгаа нь тухайн хуулийн байгууллагыг олон нийт буруутгах хандлагатай сөрөг үр дагавар харагдаж байна.

10. Нийслэлийн хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн тусгай ангийн /цаашид ЭХТА гэх/ 122 дугаар зүйл буюу 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, 125 дугаар зүйл буюу бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 126 дугаар зүйл буюу хүчиндэх зүйл ангиар зүйлчлэгдсэн нийт **72 хавтас бүхий 66 хэрэг** байгаагийн 17 нь Чингэлтэй, 10 нь Хан-Уул, 29 нь Баянзүрх, 10 нь Сүхбаатар дүүрэгт тус тус байна. Эдгээр хэргийг уншиж, дүн шинжилгээ хийхэд:

⁴⁹ Контент анализ хийсэн дэлгэрэнгүй судалгааны түүврийг хавсаргав.

-Орчин үед өсвөр үеийнхний бэлгийн бойжилт эрт явагдаж байгаатай холбоотойгоор охид ихэвчлэн 14 наснаас, хөвгүүд 15 наснаас бэлгийн харьцаанд орж байх бөгөөд 10 жилийн сургуулийн охидын хувьд хөвгүүдэд таалагдахын тулд архи уух, бэлгийн харьцаанд ороход бэлэн байх нь элбэг байна.

-Нийслэлийн хэмжээнд үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хэргүүдтэй танилцах явцад 13-21 насны хохирогчдын 44% нь өөрийгөө хянах чадваргүй болтлоо согтсоноос бэлгийн хүчирхийлэлд өртөж байна.

-Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн 80 % нь хохирогчийг урьд нь таньдаг эсхүл танилцсан хүн нь хүчирхийлдэг байна.

-Хүүхэд, залуус энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаагийн гол шалтгаан нь хийх ажилгүй, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эдийн засгийн боломжгүйтэй холбоотой байна.

-Хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн 80 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхдээ зөвхөн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, тайлбар зэргийг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь өмнөх ЭБШ хуулийн 166 дугаар зүйлийн 166.1. дэх хэсэгт заасан: “Гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байвал эрүүгийн хэрэг үүсгэнэ” гэснийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн тоо өсч харагдах, мөрдөгч нарына ачаалал зохиомолоор өсөхөд нөлөөлж байна.

-Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3, 25 дугаар зүйлийн 25.1 дүгээр үндэслэлээр хүчиндэх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа буруу практик байна. Учир нь хүчиндэх гэмт хэрэг нь хувийн болон төрийн яллах ажиллагааны буюу хосолсон яллах ажиллагааны гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хүчиндэх гэмт хэрэг нь хохирогчийн /насанд хүрсэн/ гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэх боловч, төрийн яллах ажиллагаа нэгэнт эхэлсэн бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг дуустал явуулах учиртай.

11. Энэ төрлийн шүүхийн шийдвэрүүдэд түүвэрлэн хийсэн судалгаанаас дүгнэн үзвэл, өсвөр насны охидод эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс тавьж буй хараа хяналт сул, халамж дутагдаж охид гэмт хэрэгтний олз болж байна. Энэ нөхцөл байдал нь гэмт хэрэгтэн нэг үйлдлээ дахин давтан хийх сэдлийг өдөөж байдаг гэж үзэж болно. Ялангуяа хөдөө, орон нутагт буйдхан газар, гуу жалга, эзгүй гэр, сууц, орон байр, захын хороолол, дэн буудал, зочид буудал, маншины бүхээгт энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгджээ.

Хохирогчийн ар гэрийхэнд *“арай ч ойр дотны, бага насны охин хүүхдийг хүчиндэхгүй байлгүй дээ”* гэсэн итгэмээргүй нөхцөл байдалд орж, эргэлзээ үүсгэдэг нь хараа хяналтаа сулруулах хүчин зүйл болж байна.

Хохирол нэхэмжлэх асуудал ихэнхдээ орхигддог, ялангуяа хөдөө, орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч тал хохирол нэхэмжлэх асуудлыг тоохгүй өнгөрөөх, далдуур тохирдог зүйл их байдаг тал ажиглагдлаа. Энэ нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох томоохон хүчин зүйл болдог.

Хүчиндэх гэмт хэргийг эвлэрлийн гэрээ байгуулсан нэрээр (эвлэрсэн гэсэн үндэслэлээр) хууль бусаар хэрэгсэхгүй болгож байна. Жишээ нь: Эрүүгийн 201525011364 дугаартай хэрэг.

Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдол ихэвчлэн хохирол төлбөргүй байдаг нь дээр дурдсан шалтгаан нөлөөлдөг. Хохирол нөхөн барагдуулалтын тухайд 66 хэргийн хохирогчдоос 9 хохирогч ямар нэг хэмжээгээр нөхөн төлбөр авсан байна.

Хүчиндэх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэдэг нэг үндэслэл нь *хохирогч өөрийн нийгмийн байдалд гарч болзошгүй сөрөг нөлөөллийг тооцоолж, өөрт ашигтай буюу яллагдагчаас хохирол нэхэмжилж шийдвэрлүүлэх, тохиролцсон болж хувирах, гомдлоо буцаах арга замыг сонгох тохиолдол элбэг* байна.

Гэм буруутай хүн энэ гэмт хэргийг урьдаас төлөвлөх болон гэнэт үүссэн гэмт санаагаар үйлддэг байна. *“Бодлогын хэмжээнд хэрэгжүүлж буй хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаа хүүхэд бүрт хүрэхгүй байгаа нөхцөл”* байдалтай байна.

Дэд судалгааны тайлан тус бүрд тавьсан саналуудаас гадна мөн дараах саналыг нэмж дэвшүүлж байна. Үүнд:

1. Өсвөр үеийнхний бэлгийн бойжилт эрт явагдаж байгаатай холбоотойгоор эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар тогтмол зөвлөгөө өгч байх;

2. Бэлэгсийн гэмт хэрэгт хохирогч санал хүсэлтээ илэрхийлж болохоос гомдлоо буцаан татах тухай асуудал байхгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ердийн журмаар явагдана гэдгийг хуульчид нэг мөр ойлгох;

3. Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн боловсон хүчнийг бэлтгэх хамтын ажиллагаанд анхаарал тавих;

4. Эмэгтэйчүүд хүүхдийн эрхийг хамгаалах талаар хийсэн судалгааны ажил нэг бүрд мониторинг хийж, хэрэгжилтийн үр дүнг тооцож байх. Ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий

төрийн болон төрийн бус байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэж, уг мониторинг шинжилгээний үр дүнг нийтээр жилд нэг удаа хэлэлцдэг байх;

5. Гадаад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх, ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг уруу татсан, олон хүнийг (2 ба түүнээс дээш) зохион байгуулалттайгаар биеийг үнэлүүлсэн, мөн үйлчлүүлэгч (үнэлж авсан) нар, тэднийг ашиг хонжоо олох байнгын хэрэгсэл болгосон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг чангатгах;

6. Бэлгийн мөлжлөг, биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдаалах, бэлгийн эрх чөлөөний эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх урт хугацааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамгийн чухлаар тавигдах ёстой, түүнчлэн хохирогчдыг нөхөн сэргээх нөхцлийг сайжруулах, тэднийг хэвийн амьдралд нь эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг идэвхтэй шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;

Эдгээр хөтөлбөрийг боловсруулахын тулд Европын Холбооноос гаргасан зөвлөмжийн дагуу дараах урьдчилан сэргийлэх ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм:

- Залуучуудыг, ялангуяа охид бүсгүйчүүдийг ажлаар хангах хөтөлбөр хөгжүүлэх;
- Охид бүсгүйчүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрийн хөгжил;
- Хүйсийн тэгш эрхийн ухуулга суртал нэвтрүүлэг;
- Залуучуудын бэлгийн талаарх эрүүл ахуйн суртал нэвтрүүлэг;
- Засгийн байгууллагуудаас хүүхэд залуучуудын санал хүсэлтийг харгалзах, тооцох;
- Хүүхэд эмэгтэйчүүдийг бие үнэлэх болон бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт татан оролцуулахтай болон уруу татахтай тэмцэх;

Биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн үр дагаварыг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнд:

- Хүн худалдаалахын хохирогчтой зохих ёсоор харьцах, тэднийг гутаан доромжилж, ялгаварлан харьцахгүй байх; хүн худалдаалахын хохирогчид цаг алдахгүйгээр үзүүлэх хууль зүйн, эмнэлэгийн, нийгмийн болон эдийн засгийн тусламжид хяналт тавих;
- Нийгмийн халамжийн байгууллага, бүтэц, институцийн урт хугацааны хөгжлийн дэмжлэг;
- Хууль хамгаалах болон хүний эрхийг хамгаалах бусад байгууллагын ажилтнуудад хүндэтгэн харьцах түвшинг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн ур чадварыг дэмжих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

7. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын ихэнх нь бага насны эсхүл насанд хүрээгүй хүн хүчиндсэн байгаа нь дээр дурдсан ялын бодлогын оновчтой биш байдалтай холбоотой. Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдол ихэвчлэн хохирол төлбөргүй байдаг нь судалгааны тайланд дурдсан шалтгаан нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс төлбөртэй хоригдлын төлбөрийг барагдуулах тэднийг цалинтай ажлын байраар хангах зорилгоор тодорхой ажил зохион байгуулж ирсэн боловч хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс шинэ хууль тогтоомжоор байхгүй болсон нь энэ төрлийн үйл ажиллагаанд саад болж байна.

Иймд Хүчиндэх гэмт хэргийн хохирогчийн насны байдлыг харгалзан оногдуулж ирсэн ял шийтгэлийн ялгаатай байдлыг багасгах, хүндрүүлж авч үзэх; Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох; Хоригдлыг ялангуяа төлбөртэй хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн орчныг сэргээх нь зүйтэй.

8. Цаашид сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч нарын 47.7% нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой гэснээс үзэхэд “оюуны хомсдол”-той хүмүүсийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгааг харуулж байна. Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх; Мөн хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4% нь 17-21 насны залуус эзэлж байгаа тул өсвөр үе, залуучуудад чиглэсэн хүмүүжил, хууль, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хийх шаардлагатай байгааг харуулж байна.

9. ХЗДХЯ-наас хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлсэн “Хууль зүйн цахим нэгтгэл” мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох төсөл, мөн ХСИС-иас ХЗДХЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” судалгааны төслийн үр дүнд бий болсон эдгээр байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийн ашиглалтыг хөгжүүлж, “цагдаад бүртгэгдсэн, цагдаагаас шилжүүлж, прокурор хүлээн авсан, прокурор шилжүүлж, шүүх хүлээн авсан, шүүхээс шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээллийн урсгал”-ыг харуулсан статистикийн үзүүлэлтийг сайжруулан гаргаснаар гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Хууль тогтоомж

1. Эрүүгийн хууль, 2015 он
2. Зөрчлийн тухай хууль, 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он
5. Хүүхэд хамгааллын тухай хууль хууль, 2016 он

Ном, бүтээл

1. И. Дамбажав нар., Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг.УБ., 2006. II боть.
2. Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ 2013 он.

Судалгааны тайлан

1. ЭМЯ, ГС, ХТЭТ, “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018.
2. Хөгжлийн академи ТББ, “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. УБ., 2017.
3. Доктор (Ph.D) Б.Энхболд. “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа-2017”, УБ., 2018.
4. "Монгол Улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа" УБ., 2018.
5. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. 2017 он.
6. Монгол Улсын 2017 оны Хүний Эрхийн Тайлан.
7. “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ” Эмхэтгэл 1, 2018 он.

Цахим эх сурвалж

1. UN Women (May 2013). Factsheet - Global, Progress of the World's Women 2011-12 (PDF)
2. Чинзориг С.: Жендэрийн тэгш байдлыг хангах нь хөгжлийн үндсэн түлхүүр // <http://www.mlsp.gov.mn/nnews/242> (нийтлэл)
3. Perceptions of precariousness: a qualitative study of constraints underlying gender disparities in Mongolia's labor market// <http://documents.worldbank.org/curated/en>
4. Мөнхтуяа Ё. Хүний нөөцийн хямрал// <http://tsagtur.mn/>. 2009-09-01-04-10-31 (нийтлэл)
5. <http://www.olloo.mn/n/49403.html>
6. Баасансүрэн Д., Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт// Үзнэ үү.: Katz, R. Canding Models of Party Organization and Party Democracy: The Emergence of Cartel Party/ R.Katz, P.Mair // Party Politics.-1995.-Vol.1, №1.-P.5-28
7. Жаргалсайхан Д., Монголын нийгмийн бас нэг сорилт: улс төр//<http://jargaldefacto.com/article/> (нийтлэл)
8. <http://1212.mn/BookLibrary>

9. Нарангэрэл С., Монголын хөгжлийн хамгийн том тээг нь бидний ёс суртахууны доройтол// <https://www.facebook.com/Mongolianlawsociety/> (нийтлэл)
10. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны гуравдугаар улирлын үйл ажиллагааны тайлан//Police.gov.mn/resource/policegovmn
11. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2017 онд // <https://ikon.mn/n/1cxa>
12. <https://www.nso.mn>
13. <https://news.mn/r/513469/>
14. Shuukh.mn

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон бусад байгууллагын албан эх сурвалж

1. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл.
2. Улсын Ерөнхий прокурорын газрын мэдээлэл.
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэл.
4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээлэл.

Гадаад улсуудын хууль тогтоомж

1. Уголовный кодекс штата Техас. ред. И.Д. Козочкин. "Юрид.центр Пресс", 2006.
2. Уголовный кодекс Испании. Москва. Зерцало., 1998.
3. Уголовный Кодекс Республики Сан-Марино. "Юридический центр Пресс", 2003.
4. Уголовный кодекс Франции. Под ред. Л.В. Головкин, Н.Е. Крылова. М., 2002.
5. Уголовный кодекс Латвийской Республики. ред., Лукашов А.И., Саркисова Э.А. СПб.:Юридический центр-пресс., 2001
6. Уголовный кодекс Швейцарии. Перевод с немецкого / Науч. ред.: Серебрянникова А.В. (Пер., предисл.) - С.-Пб.: Юрид. центр Пресс, 2002.
7. Уголовный кодекс Швеции / Науч. ред.: Беляев С.С., Кузнецова Н.Ф. - С.-Пб.: Изд-во "Юрид. центр Пресс", Изд-во Моск. гос. ун-та, 2001.
8. Sokvk skatot Eiropas Padomes Ministru komitejas "Ministru Komitejas Rekomendācija dalībvalstīm R(2000)11 Par cilvēku tirdzniecības seksuālās izmantošanas nolūkā." (IV daļa 23—25.punkts), ko Ministru komiteja pieņēmusi 2000.gada 19.maijā ministru vietnieku sanāksmē
9. Уголовный кодекс республики Корея. С изменениями и дополнениями на 1 октября 2003 г. Под.ред. А. И. Коробеева. Санкт-Петербург., 2003.
10. Хайонам Мун. Современная ситуация по организованной преступности в корее//www.crime.vl.ru
11. Уголовный кодекс Китайской Народной Республики 1997 г // www.legal-way.ru

БАТЛАВ.
ХСИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D),
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.ЭРДЭНЭБАЯР

“ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ
ГЭМТ ХЭРЭГ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС”
СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ /2015-2017/

2018.10.20.

Улаанбаатар хот

Захиалагч тал:

Хүйсийн тэгш эрхийн төв ТББ

Хэрэгжүүлэгч байгууллага:

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төв

Судалгааны ажлын зорилго:

Манай улс НҮБ-ын гишүүн болохынхоо хувьд тус байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхолыг хамгаалах талаар багагүй хүчин чармайлт гаргаж, олон улсын гэрээ конвенцид нийцүүлсэн хууль тогтоомжийг батлан мөрдүүлж байгаа ч хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, тэр дундаа хүүхэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох тохиолдол буурахгүй харин ч нэмэгдсээр байна. Үүнийг батлах зарим жишээг дурьдвал, сүүлийн 3 жилийн байдлаар ЦБ-д бэлгийн хүчирхийллийн 947 хэрэг бүртгэгдэн шалгагдсан төдийгүй гэмт хэргийн гаралт 30 %-р нэмэгджээ. Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогчдын 87 % нь ЕБДС-ын сурагчид бол гэмт хэрэг үйлдэгчдийн 53.7 % нь ураг төрлийн хүн /2017 оны байдлаар/ байна.

Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн (ЭХ-ийн 12.1, 12.2, 12.5) гаралтад *нөлөөлж байгаа шалтгаан, хүчин зүйлсийн талаар тоон болон чанарын судалгаа хийж, үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулахад* судалгааны зорилго оршино.

Зорилт:

- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгаан, нөхцлийг тогтоох,
- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар хийгдсэн судалгааны бүтээлүүдэд дүн шинжилгээ хийх замаар судлагдсан байдлыг тодорхойлох,
- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх статистикт дүн шинжилгээ хийх,
- 2015-2017 онуудад үйлдэгдсэн үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргүүдийг уншиж судалж, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, *хүчин зүйлсийг* тогтоох, Үүнд:
 - Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг шинжлэх,
 - Эрүүгийн хэрэг үүсгэсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг судлах,

- Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын талаар гаргасан гомдлыг шалган хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан /татгалзсан/ үндэслэлийг судлах,
- Хүүхэд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар тусгайлан судлаж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх санал боловсруулах,
- Шүүх шинжилгээний байгууллагаас хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдалтай холбоотойгоор гаргасан шинжээчийн дүгнэлтүүдтэй танилцан, шинжилгээ хийлгэх орчин үеийн боломж нөхцлийг судлах,
- Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийг мөрдөгч нартай ярилцлага хийж, санал авах,
 - Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай 2002, 2017 оны Эрүүгийн хууль тогтоомжуудад харьцуулсан судалгаа хийж, холбогдох зүйл, заалтуудыг сайжруулах талаар санал боловсруулах,
 - Олон улсын болон гадаадын зарим орнуудад “Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгаа хийх, дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах.

Хэрэгжих хугацаа:

2018.X.20 - 2018. XII.20

Судалгааны арга зүй:

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ юмс үзэгдлийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээнд нь бодитойгоор судлах боломж олгодог шинжлэх ухааны түгээмэл аргуудыг хэрэглэх ба сэдэвт холбогдох мэдээ баримтуудыг холбогдох эх сурвалжаас авч, албан ёсны статистик, хавтаст хэргийн материалд дүн шинжилгээ /задлах, нэгтгэн дүгнэх, харьцуулалт/ хийх, ярилцлага, ажиглалт, анкетын аргыг өргөнөөр ашиглана.

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (ЭХ-ийн 12.1, 12.2, 12.5): *шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлсийг* гэмт хэрэг талаас нь судлах бөгөөд практик болон эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсч буй асуудлууд нь судалгааны ажлын объект болно. Харин судлах зүйлийн хүрээнд 2015-2017 он буюу сүүлийн 3 жилд үйлдэгдсэн бодит хэргүүд, энэ чиглэлээр хийгдсэн судалгааны тайлангууд, үндэсний хэмжээний гэмт хэргийн статистикууд /ЦЕГ, Шүүх, ШШҮХ, ШШБЕГ,ЭМЯ/, Эрүүгийн хууль тогтоомж тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг сонгон авсан болно.

Судалгааны ажлын зохион байгуулалт:

- Судалгааны багийн ахлагч нь удирдамж, төлөвлөгөөний дагуу судлаачдыг удирдан зохион байгуулж, судалгааны ажлыг гүйцэтгэнэ.
- Судалгааг хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах болон эрх зүйн орчинг сайжруулахад нөлөөлөх бодлого боловсруулахад анхаарах асуудлыг тодорхойлох,
- Судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэх,
- Захиалагч талын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хэмжээнд судалгааг явуулж, тайлан бэлтгэх,
- Судалгааны баг нэгдмэл удирдлагыг баримталж, багийн ахлагч судалгааны үр дүнг хариуцна.

Хамтран ажиллах байгууллагууд:

- ЦЕГ-ийн харъяа мэдээлэл судалгааны төв, МБ болон ХБА,
- Статистикийн хороо,
- ХЭҮК,
- ШШБЕГ,
- Эрүүгийн хэргийн архивын газар,
- ШШҮХ,
- ЭМЯ болон ХӨС-ынзэрэг болно.

Судалгааны баг:

Багийн удирдагч: Т.Оюунчимэг - ХСИС-ийн ЭШХ-гийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Багын зөвлөх:

1. Ж.Болдбаатар –хууль зүйн ухааны доктор (Sc.D), профессор

Нарийн бичиг – Уулзахжаргал - ХСИС-ийн ЭШХ-гийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Багийн гишүүд:

9. Ахлах судлаач Ч.Нямсүрэн - ХСИС-ийн ЭШХ-гийн ЦСТ-ийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

10. Судлаач М.Эрдэнэбаяр - ХСИС-ийн ЭШХ-гийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D),

11. Судлаач Б.Мөнхдорж - ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D),

12. Судлаач Б.Мөнхсэргэлэн - ХСИС-ийн ЭШХ-ийн ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

13. Судлаач Л.Цогтбаяр - ХСИС-н Цагдаагийн Сургуулийн ЭХХШЭЗүйн тэнхимийн багш, докторант

Судалгааны үр дүн:

Судалгааны үр дүнгээр тайлан гаргах бөгөөд тайланд тусгагдсан санал, зөвлөмжийг төр засгийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргагчид болон хэрэгжүүлэгчидэд хүргүүлснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх талаар үндэслэл, бүхий оновчтой шийдэлд хүрэхэд судалгааны үр дүн чиглэгдэнэ.

БОЛОВСРУУЛСАН: ДОКТОР (Ph.D),
ПРОФЕССОР

Т.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН: ЗӨВЛӨХ ДОКТОР (Sc.D),
ПРОФЕССОР

Ж.БОЛДБААТАР

**“ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ
ГЭМТ ХЭРЭГ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС”
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хариуцах асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1	2002 оны Эрүүгийн хуулийн хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг /122,125,126 дугаар зүйл/ гэмт хэрэг, 2017 оны Эрүүгийн хуулийн /12.1.,12.2., 12.5 дугаар зүйл/ холбогдох бүлгийн талаар харьцуулсан судалгаа хийж дүгнэлт, санал боловсруулах,	XI/10-XI/25	Доктор (Sc.D), профессор Ж.Болдбаатар
	Судалгааны ажлын төлөвлөгөө, тайланг хянах	XII/10- 15	
2	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр эдийн засгийн шалтгаан, нөхцлийн талаар судлагаа хийх, дүгнэлт бичих,	XI/20-XII/10	Доктор (Ph.D), дэд профессор Ч.Нямсүрэн
	Гадаадын зарим улс орнуудын эрүүгийн хуульд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг тусгасан талаар харьцуулсан судалгаа хийх	XI/5-XI/15	
3	2015-2017 онуудад шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгосон хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргүүд,	XI/12-XI/5	Доктор (Ph.D), дэд профессор Т.Оюунчимэг, М.Эрдэнэбаяр, ЭШ ажилтан Б.Мөнхсэргэлэн, О.Уулзахжаргал
	2015-2017 онуудад хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийн шийдвэрлэлт, татгалзсан, хаасан үндэслэлийг судлаж үнэлэлт дүгнэлт өгөх,		
	Хүчиндэх гэмт хэргээр давхар зүйлчлэгдсэн хүн алах гэмт хэргүүд,		
	Хүүхдийг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргүүдийг тус тус судлан гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, хүчин зүйлсийг тогтоох, дүгнэлт хийх,		
4	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг буюу хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргүүдийн талаархи статистиктуудад дүн шинжилгээ хийх,	XI/10-XII/5	Доктор (Ph.D) Б.Мөнхдорж
	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх мэдээллийн санг бий болгож системчлэх боломжийг судалж, санал дэвшүүлэх		
	Сэтгэгц эмгэг судлалын үндэсний төвөөс хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох зүйл ангиар зүйлчлэгдсэн хэрэг дээр хийгдсэн сэтгэцийн байдлыг тогтоох шинжилгээний үр дүнтэй танилцаж дүгнэлт гаргах		
5	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх,	XI/6-XI/20	ЭШ ажилтан Б.Мөнхсэргэлэн
	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт хийгдсэн /2015-2017/ шинжилгээний дүгнэлттэй танилцан танилцуулга хийх,	XI/20-XI/30	

	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн талаар хийгдсэн судалгааны бүтээлүүдтэй танилцаж судлагдсан байдлыг тодорхойлон танилцуулга бичих	XI/6-XI/30	ЭШ ажилтан О.Уулзахжаргал
7	Олон улсын болон гадаадын зарим орнуудад Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийж дүгнэлт гаргах,	XI/6-XI/25	Докторант Л.Цогтбаяр
8	Хүний бэлгийн эрх, чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн ялтангуудаас судалгаа авч дүгнэлт гаргах,	XI/10-XI/25	Доктор (Ph.D), дэд профессор М.Эрдэнэбаяр,
9	Холбогдох байгууллагуудад хүсэлт гаргах,	XI/05	Доктор (Ph.D), дэд профессор Т.Оюунчимэг
10	Судалгааны ажлын үр дүнгээр тайлан бичих,	XII/5-XII/15	Доктор (Ph.D), дэд профессор Т.Оюунчимэг, Ч.Нямсүрэн
11	Судалгааны тайланг захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх.	XII/20	Доктор (Ph.D), дэд профессор Ч.Нямсүрэн, Оюунчимэг

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: _____